



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

(2018-2020)





МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ ТАЙЛАН (2018-2020)



Улаанбаатар хот
2021

Захиалагч:



Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба



Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс

Гүйцэтгэгч:



“Хууль сахиулахуй, олон нийтийн эрүүл мэнд судлалын хүрээлэн” ТББ

Хамтран гүйцэтгэгч:



Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн

Санхүүжүүлэгч:

НҮБ-ын Хүн амын сангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-өөс санхүүжүүлэв.

“Чөлөөт хэвлэл сан” Хэвлэх үйлдвэрт хэвлэв. 2021 он.

Хэвлэсэн тоо: 50ш

Хэвлэлийн хуудас: 7.5 х.х

АГУУЛГА

УДИРТГАЛ	5
----------------	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ТООН СУДАЛГАА

§ 1.1 Шүүхээр шийдвэрлэгдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон түүнтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ	9
--	---

§ 1.2 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан шийтгэлийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл	20
--	----

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЧАНАРЫН СУДАЛГАА

§ 2.1. Гэр бүлийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүнд хийсэн дүн шинжилгээ	27
---	----

2.1.1. Гэр бүл, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоо бүхий хэм хэмжээ агуулсан хуулийн нэр томъёоны тухай.	27
---	----

2.1.2. Гэр бүл, түүний гишүүдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт	31
--	----

2.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүнд хийсэн дүн шинжилгээ	35
--	----

§ 2.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаар олон нийтийн санаа бодолд хийсэн контент анализ	41
--	----

§ 2.3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох зарим асуудал	58
---	----

2.3.1. Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг тооцоолох, барагдуулах асуудал	58
---	----

2.3.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчид хийсэн шинжилгээ, өнөөгийн нөхцөл байдал	62
---	----

§ 2.4. КОВИД-19 цар тахлын үеэр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж буй олон улсын зарим туршлага	65
--	----

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

§ 3.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал	77
--	----

§ 3.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүн, анхаарах асуудал	91
--	----

НЭГДСЭН ДҮГНЭЛТ	99
НЭГДСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖ	102
Хэлэлцүүлгийн тэмдэглэл, түүнээс гарсан санал, зөвлөмжүүд	107
“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд инноваци нэвтрүүлэх, оновчтой санал дэвшүүлэх” сэдэвт илтгэлийн уралдаанаас гарсан шинэлэг санал, санаачлагын түүвэр	114
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	121

УДИРТГАЛ

Аливаа нийгмийн зохион байгуулалт гэр бүлээр эхэлдэг төдийгүй гэр бүл нь төр улс бүрэлдэх үндэс болдог. Нийгмийн суурь нэгж болох гэр бүлийн гишүүний жам ёсны эрхийг зөрчиж байгаа хамгийн түгээмэл хэлбэр нь хүчирхийлэл, түүний дотор ураг төрлийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэхг “ахуйн хүрээний” гэх гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхий дахины өмнө тулгамдаж буй асуудлуудыг тэргүүлж, тархацын хувьд гэр бүлд төдийгүй нийгэмд мэдэгдэхүйц хор уршиг дагуулах болов.

Дэлхий нийтэд “Гэр бүл нь нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”¹ хэмээн тунхагладаг нь эцсийн бүлэгт нийгмийн тогтвортой байдлыг хангах явдал бөгөөд гэр бүлийн харилцааны хэвийн байдлыг хангах, хамгаалах нь төрийн бодлогын хамгийн чухал асуудлуудын нэгэнд зүй ёсоор тооцогддог.²

Гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн тухайн гэр бүлийн дотоод асуудал бус, нийгэм бүхэлдээ тогтворгүйтэх эрсдэлийг дагуулах, гэр бүлийн гишүүдийн эрхийг ноцтой зөрчдөг “гэмт хэрэг” хэмээн дэлхийн 125 оронд хуульчилсан төдийгүй НҮБ-аас Гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хууль боловсруулан гаргасан юм.

Манай улсын хувьд ХХ зууны сүүл үеэс иргэний нийгмийн байгууллагуудын хүчин чармайлтаар “Гэр бүл дэх хүчирхийлэл нь хүний эрхийг ноцтой зөрчдөг гэмт үйлдэл, нийгмийн тулгамдсан асуудал” болохыг төр засаг, албан тушаалтан, ард иргэдэд нээн харуулсан нь саяхан болтол “Гэр бүлийн дотоод асуудал буюу зөрчил” гэж үздэг байсан бүх нийтийн үзэл хандлагыг өөрчилж чадсан төдийгүй “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хуулийг батлуулж чадсан юм.

Энэ талаар доктор (Ph.D) Г.Ганбаатар: “Ахуйн хүрээний гэх тодотголтой гэр бүлийн хүчирхийлэл нь нийгэмд шинээр гарч буй үзэгдэл биш ч, түүнийг “гэмт хэрэг” хэмээн үзэх хандлага ... харин шинэ тутам билээ” хэмээн тэмдэглэжээ.³

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 онд батлагдан, 2005 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш энэ чиглэлээр олон хөтөлбөр, заавар журмуудыг батлан хэрэгжүүлсэн төдийгүй 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн боловсруулж, өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байгаа төдийгүй Эрүүгийн хуульд ч энэ талаар бие даасан зүйл заалтууд оруулсан юм.

Засгийн газраас гэр бүлийн хүчирхийлэлийн хохирогчдыг хамгаалах байраар хангах, утсаар зөвлөгөө өгөх, нэг цэгийн үйлчилгээ, хамгаалах байруудыг байгуулан олон төрлийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн зэрэг нааштай алхмууд хийгдсээр байгаа ч хүчирхийлэл буурсангүй, эрдэнэт хүн амь нас эрсдэх, эрүүл мэндээрээ хохирох нь ихсэж, илүү ноцтой хэлбэрт шилжин олныг цочроох боллоо

Гэр бүл, түүний хүрээнд үүсэж буй харилцааны асуудал нь гүн ухаан, нийгэм судлал, сэтгэл судлал, түүх судлал, угсаатны зүй, хүн ам зүй, эдийн засаг, эрх зүй зэрэг шинжлэх ухааны судлагдахууны хувьд үе үеийн судлаачдын анхаарлын төвд байж, янз бүрийн төвшинд олон талаас судлагдсан нийгмийн институт болон бүрэлдсэн бөгөөд өнөөдөр гэр бүл судлал (Family studies-семьеведение) нь бие даасан мэдлэгийн салбар болон хөгжиж байна.⁴

¹Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946. 16 дугаар зүйл. х.3

²Д.Зүмбэрэллхам. Монгол Улсын Гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт номын өмнөх үг. УБ., 2009. х.6

³Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүйн тулгамдсан асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2016. 3 дахь тал

⁴Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүйн тулгамдсан асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2016. 11 дэх тал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 60 дугаар зарлигаар 2019-2020 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгон зарлаж, хүүхдийн эрхийг хүндэтгэх, эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд туслах, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлд идэвх санаачилга гаргаж ажиллахыг ард иргэддээ уриалж, Засгийн газарт 9 чиглэл хүргүүлсэн.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас НҮБ-аас Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх “Яг одоо” арга хэмжээний дэд төлөвлөгөө гарган, тодорхой ажлуудыг 2020 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 11-ний өдөр хүртэл хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх гэмт хэргийн криминологи судалгааны ажил” хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, НҮБ-ын Хүн амын сан, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн захиалгаар ДХИС-ийн Эрдэм Шинжилгээний Нэгдсэн Хүрээлэн /цаашид ЭШНХ гэх/, Хууль сахиулах, олон нийтийн эрүүл мэнд судлалын хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын баг энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

2020 оны 4 дүгээр сарын 29-нд баталсан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.20 хэсэгт: “гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, түр хамгаалах байранд шаардлагатай хөрөнгө оруулалт болон 24 цагаар ажиллуулах утасны санхүүжилтийг шийдвэрлэх” гэж заасан.

Монгол улсад “цар тахал” зөөвөрлөгдөн орж ирсэнтэй холбоотойгоор хорио цээрийн дэглэм тогтоосноос биечлэн хийж гүйцэтгэх шаардлагатай зарим судалгааны аргыг ашиглах явдал хязгаарлагдмал байсаныг тэмдэглэх нь зүйтэй. Гэвч бид судалгааны уламжлалт болон уламжлалт бус зарим аргын тусламжтайгаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт явдлын гаралт, түүний шалтгаан нөхцлийг илрүүлэхийг зорисон болно.

Судалгааны зорилго:

Монгол Улсад сүүлийн 3 жилд /2018, 2019, 2020/ үйлдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаар судалгаа хийж, шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга замыг эрэлхийлсэн санал, зөвлөмж, шийдэл боловсруулах замаар судалгааны ажлын үр дүн болох тайланг холбогдох шатанд танилцуулж, хэвлүүлэн, олон нийтийн хүртээл болгоход оршино.

Судалгааны ажлын зорилт:

Дэвшүүлсэн зорилгоо хангахын тулд доорх зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Сүүлийн 3 жилд үйлдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг цуглуулах;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд харьцуулсан дүн шинжилгээ хийж, тэдгээрийг боловсронгуй болгох санал дэвшүүлэх;
3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүний дотор таслан зогсоох, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, түүний үр дүнг сайжруулах санал санаачлага эрэлхийлэх;

4. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тодохойлох замаар тулгамдсан асуудлыг нээн, шийдвэрлэх гарцыг эрэлхийлэх;

5. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар санал, дүгнэлт дэвшүүлэх;

6. Судалгааны тайланг товхимол хэлбэрээр хэвлүүлэн, нийтийн хүртээл болгох.

Судалгааны арга: Энэхүү судалгаанд криминологи, виктимологийн шинжлэх ухааны судалгааны арга зүйд тулгуурлан тоон ба чанарын судалгаа хийв.

Тоон судалгааны хүрээнд шүүхийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистик мэдээг ашиглан, шүүхээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шийдвэрлэлт, шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд тулгуурлан дүн шинжилгээ хийлээ. Мөн судалгааны явцад ҮСХ, ЦЕГ-ын холбогдох мэдээ мэдээллийг ашиглав.

“Ковид-19” цар тахлын онгой нөхцөл байдлын улмаас санал асуулга, ярилцлагын аргуудыг ашиглаагүй болно.

Чанарын судалгаанд цар тахлын үед гадаадын зарим улс орнууд гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг өөрийн орны эрх зүйн зохицуулалттай харьцуулах, баримт бичгийн болон контент анализийн судалгааны аргуудыг ашигласан болно. Мөн иргэдийн хандлагыг тандах зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, түүний дотор нийтлэл, өгүүлэл, ярилцлагыг контент анализын аргаар харууллаа.

Хугацаа:

2020 оны 11-р сарын 15-наас 12-р сарын 15-ны өдөр хүртэл, нийт нэг сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Судалгааны баг:

Судалгааны багийн ахлагч: Хууль зүйн доктор, профессор Ч.Нямсүрэн

Судалгааны багийн зөвлөх: Хууль зүйн доктор Т.Очирбат

Судалгааны нарийн бичгийн дарга: Хууль зүйн доктор Б.Мөнхдорж

Судалгааны багийн гишүүд:

Хууль зүйн доктор, профессор Т.Оюунчимэг

Хууль зүйн магистр Б.Даяадан-Эрмэд

Сэтгэл судлалын докторант Ш.Доржханд

Докторант Ч.Отгонсүрэн (ДХИС)

Докторант Н.Сайнбаяр (ДХИС)

Докторант Д.Цэрэнлхам (ДХИС)

Докторант Г.Балжмаа (ДХИС)

Докторант Г.Ганхөлөг (ДХИС)

Докторант П.Анхмаа (ДХИС)

Докторант М.Болормаа (ДХИС)

Магистрант Б.Мөнхшүр (ДХИС)

Магистрант Н.Наранцэцэг (ОУУБИС)

Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургууль, хууль зүйн салбарын их, дээд сургууль, иргэний нийгмийн байгууллагын эрдэмтэн, судлаач, практикийн ажилтан нартай нягт хамтран ажилласан.

Судалгааны үр дүнгийн ач холбогдол:

Энэхүү судалгааны үр дүнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, нөхцөл байдлыг бодитой үнэлж, оновчтой шийдвэр гаргах, бодлого хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ хэмээн үзэж байна.

Судалгааны тайлангийн агуулга, бүтэц:

Судалгааны ажил нь удиртгал, 3 бүлэг, 8 дэд бүлэг, нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмж, хавсралт, ашигласан эх сурвалжийн жагсаалтаас бүрдэнэ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ТООН СУДАЛГАА

§ 1.1. Шүүхээр шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон түүнтэй холбоотойгоор үйлдсэн гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ

Улс орон амар амгалан оршин тогтноход гэр бүлийн дотоод харилцаа чухал болохыг төрөөс анхаарч Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд: “Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ. Гэр бүлийн гишүүд нь ..., **хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй байх, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх ... үүргийг адил хүлээнэ**”¹ хэмээн гэр бүлийн харилцааны суурь зарчим, гэр бүлийн гишүүдийн үндсэн чиг үүргийг ийнхүү хуульчилсан нь тэдний хүсэл, зоригоос шалтгаалахгүйгээр биелэгдэх шинжийг агуулсан, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх хууль зүйн үр дагавар бүхий чухал хамгаалалт болсон.

1990 оноос эхлэлтэй нийгмийн шинэчлэл нь шинэ соёл, шинэ цагийн хүн төлөвших зэрэг эерэг үр дагавруудыг авчирахын зэрэгцээ нийгмийн тэгш бус байдал, хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн болон орлогын тэгш бус байдлаас шалтгаалан олон өрх гэрүүд амьжиргааны асуудлаас хэрүүл тэмцэлтэй амьдрах нь түгээмэл болж, хүч хэрэглэсэн гэмт хэрэг тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нийгмийн бүхий л хүрээ, давхаргыг хамарч өнөөгийн тулгамдсан асуудлуудыг тэргүүлэх болов.

Гэр бүлийн хүчирхийлэл буюу хүч хэрэглэсэн гэмт хэрэг гэр бүлийн хүрээнд үйлдэх нь илт ихэссэн энэ цаг үед, энэхүү үйлдлийг “**энгийн үзэгдэл**” мэт хүлээн авах сэтгэгдэл нийгэм даяар тархах нь хамгийн аюултай юм.

Ийнхүү хүний үнэт зүйлс, ёс заншлууд орхигдон гээгдэж, тэр хэрээр гэр бүлийн харилцааны үнэт зүйлс алдагдах, гэр бүлийн харилцаа тогтворгүй, ёс зүйгүй болох, гэр бүл салах, гэр бүлд хүч хэрэглэх гэмт явдал өдрөөс өдөрт өссөөр байгаа нь үндэсний сэтгэц зүй хувьсан өөрчлөгдөж байгаагийн илрэл юм.

Бид 2018-2020 онд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийн талаар хэргийн материалтай танилцан судалгаа хийх тооцоололтой байсан ч, Улсын Онцгой Комиссоос Монгол Улсад Ковид 19 цар тахлын халдвар бүртгэгдсэнтэй холбоотойгоор бүх нийтийн бэлэн байдалд шилжин хөл хорио тогтоосны улмаас тухайн нөхцөл байдалдаа тохируулан Шүүхийн www.shuukh.mn албан ёсны сайтад тавьсан шийдвэрүүдийг ашиглан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах үйл ажиллагаа, оногдуулж буй ялын үр нөлөөний байдалд дүн шинжилгээ хийхийг зорьлоо.

Энэхүү судалгаанд www.shuukh.mn сайтад тавигдсанаар 2018 оны 01 сарын 01-ний өдрөөс 2020 оны 11 сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд **Анхан шатны шүүхээр**:

- 1) Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг /ЭХ. 11.7/ 410, давж заалдах шатны шүүхээр 103, хяналтын шатны шүүхээр 30, өссөн дүнгээр нийт **543 гэмт хэрэг**,
- 2) Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж бусдыг алах /ЭХ. 10.1.2./ 19 гэмт хэрэг, давж заалдах шатны шүүхээр 9, хяналтын шатны шүүхээр 3, өссөн дүнгээр **нийт 31 хэрэг**,
- 3) Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хүчиндэх /ЭХ. 12.1.2./ 32 гэмт хэрэг, давж заалдах шатны шүүхээр 19, хяналтын шатны шүүхээр 4, өссөн дүнгээр **нийт 55 хэрэг** шийдэгдсэн байна.

¹Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. 10 дугаар зүйл. 10.3. 1999. //Төрийн мэдээлэл. 1999. № 30.

Өөрөөр хэлбэл, сүүлийн 3 жилд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн **461** хэрэг, өссөн дүнгээр 629 /давж заалдах болон хяналтын шатаар хэлэлцүүлсэн/ хэргийн шийтгэх тогтоол уг сайтад бүртгэгдсэн байна.

Хүснэгт 1.1. www.shuukh.mn сайтад бүртгэлтэй гэмт хэрэг

Зүйл анги	Анхан шатны шүүх			Давж заалдах шатны шүүх			Хяналтын шатны шүүх		
	2018	2019	2020.11.30	2018	2019	2020.11.30	2018	2019	2020.11.30
11.7.1.1	48	87	36	14	18	16	3	3	6
11.7.1.2	21	50	21	7	11	6	2	2	2
11.7.1.3	1	2	2	0	1	1			
11.7.2.1	31	32	29	13	8	15	3	4	3
11.7.2.2	2	0	0						
11.7.2.3	2	2	2	2	0	1	1	0	1
нийт	105	173	90	36	38	29	9	9	12
10.1.2.8	0	2	17	0	1	8	0	0	3
12.1.2.3	9	16	7	6	8	5	1	2	1
Бүх хэрэг	114	191	114	42	47	42	10	11	16

Дээрхи сайтад бүртгэлтэй хэргүүдээс Анхан шатны шүүхээр шийдэгдсэн бүрэн нээгдэх боломжтой **139** гэмт хэргийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж, хэргүүдийг зүйл заалтаар нь авч үзвэл,

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг /ЭХ.11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1./ - **121**,
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж бусдыг алах гэмт хэрэг /ЭХ.10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.8./ - **8**,
- Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хүчиндэх /ЭХ.12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.3./ - **10** гэмт хэрэг байна.

Нийтлэгдсэн 139 хэргийг хэргийн ангиллаар авч үзвэл: 87.7 % нь хөнгөн, 12.3 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар орныг илэрхийлэх нэг хэлбэр болох хэрэг шийдэгдсэн аймаг, нийслэлийн дүүргүүдээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн гэмт хэргийн газар орны байдлыг авч үзвэл:

**Хүснэгт 1.2. Анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн
гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой
үйлдсэн гэмт хэргийн тоо**

№	Гэмт хэрэг үйлдсэн нутаг дэвсгэрийн нэр	Гэмт хэргийн тоо
1	Баянзүрх дүүрэг	27
2	Сонгинохайрхан дүүрэг	19
3	Баянгол дүүрэг	13
4	Чингэлтэй дүүрэг	8
5	Хан-Уул дүүрэг	4
6	Сүхбаатар дүүрэг	4
7	Багахангай дүүрэг	2
8	Багануур дүүрэг	1
9	Сэлэнгэ аймаг	8
10	Орхон аймаг	7
11	Говьсүмбэр аймаг	6
12	Дорнод аймаг	5
13	Архангай аймаг	5
14	Хөвсгөл аймаг	5
15	Завхан аймаг	4
16	Дархан-Уул аймаг	4
17	Өмнөговь аймаг	3
18	Увс аймаг	3
19	Ховд аймаг	3
20	Өвөрхангай аймаг	2
21	Төв аймаг	2
22	Дундговь аймаг	1
23	Говь-Алтай аймаг	1
24	Баянхонгор аймаг	1
25	Дорноговь аймаг	1

Дээрхи тоо баримтаас харахад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотойгоор хүнийг алах, гэр бүлийн хамаарал бүхий хүчиндэхгэмт хэрэг **нийслэлд нийт 77**, орон нутагт **62** хэрэг бүртгэгдсэн байх бөгөөд нийслэлийн хүн амын төвлөрөл ихтэй Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт, орон нутагт нилээд хотожсон, хөл хөдөлгөөн ихтэй Сэлэнгэ, Орхон, Говьсүмбэр аймагт гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотой гэмт хэрэг илүү их үйлдэж байна.

Харин гэмт хэргийн 97 хувь нь гэр, орон сууцанд буюу гэр бүл амьдарч байгаа газраа үйлдэгддэг бол, 3 хувь нь хохирогчийн ажлын байр, гудамж талбайд үйлдэгжээ.

Хохирогчдын талаар:

Шүүхийн шийтгэх тогтоолуудад хохирогчдын хувийн мэдээлэл байхгүйгээс зөвхөн шүүхийн тогтоолд нотлох баримтаар дурьдагдсан мэдүүлэгүүдэд түшиглэн гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийг тодорхойллоо. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбогдон үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчдыг гэр бүлийн хүрээгээр нь авч үзэхэд:

82 буюу 59.4 % нь эхнэр,

47 буюу 34 % нь хамтран амьдрагч,

2 буюу 1.4 % нь төрсөн эцэг, эх,

4 буюу 2.9 % нь төрсөн ах дүүс,

10 буюу 7.2 % нь хүүхэд (төрсөн 5, дагавар 5) байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлд эхнэр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эх, ах дүүс гэхчилэн гэр бүлийн бүх гишүүд өртдөг болохыг харуулж байна. Тухайлбал, нэгэн эх хүү маань намайг эрүүл, согтуу байсан ч

хамаагүй байнга л мөнгө нэхэж, ямар ч шалтгаангүй зоддог. Би сүүлдээ айгаад гэртээ байж чадахгүй байгаа¹ гэсэн мэдүүлэг.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас нийт 142 иргэн хохирсоны 97.1 хувь нь эмэгтэйчүүд, 4 хэрэгт хохирогч эрэгтэй хүн гэж бүртгэгдсэнээс 3 хэргийн хохирогч нь бага насны эрэгтэй хүүхэд байна.

Гэмт хэргийн улмаас хохирогчдын 79 нь бие мах бодийн, 10 нь бэлгийн, 2 нь эдийн засгийн, 8 нь сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн бөгөөд 49 иргэн хөнгөн, 4 нь хүндэвтэр гэмтэл авч, 8 иргэн нас баржээ. Мөн бие мах бодийн хүчирхийлэлтэй бусад /сэтгэц зүйн, эдийн засгийн, бэлгийн/ хүчирхийлэл дагалдах нь цөөнгүй.

Мөн хохирогч хүчирхийлэл үйлддэг тухай холбогдох байгууллагад мэдэгдэж арга хэмжээ авхуулсаны дараа хүчирхийлэл үйлдэгч өширхөн дахин улам харгис хэрцгий хүчирхийлэл үйлдэх нь цөөнгүй байна.

Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт: “Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол, шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцална” гэсэн заалт нь зөвхөн гэрлэлтээ цуцлуулахыг хүссэн иргэн төдийгүй гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд ч хамааралтай заалт юм. Гэтэл үүнийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах чиг үүрэг бүхий этгээдүүд анхаардаггүйгээс гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч амь нас, эрүүл мэндээрээ дэнчин тавин хоног өдрийг төөрүүлж байна. Тухайлбал, нэгэн хохирогч мэдүүлэгтээ: “Нөхөр архи уусан үедээ догшин авиртай, тэр үед нь би зодож болох бүхий л юмыг нуудаг. Тогооны залгуурыг нугалж эрчилж давхарлаж байгаад намайг ороолгодог, галын дэгээ төмрөөр цохих, хөл, гараар өшиглөж үсдэж чирдэг, тэр битгий хэл, 2 хүүхдийнхээ нүдэн дээр дүн өвлөөр нүцгэн /зөвхөн левчиктэй/ байхад үсдээд цасан дээгүүр, жалганы хажуугаар чирч явсан. Төрсөн өдрөөрөө архидаж, намайг хардаад зодоод байхаар нь би 2 хүүхэдтэйгээ гэр рүүгээ явсан. Эргэж нийлэх хүсэлгүй байсан, гэтэл охиныг маань хулгайлж авч яваад охиноор барьцаалж, намайг буцаж очихыг шаардсан, тэгээд арга буюу би гэртээ ирсэн”² гэсэн нь өнөөгийн бодит амьдрал юм.

Харин гэр бүлийн хүчирхийллийн гэрч төдийгүй хохирогч болох үр хүүхэд нь мэдүүлэхдээ: “Аавтай байхад үргэлж айдастай хэцүү байдаг. Аав архи уусан үедээ дандаа ээжийг зоддог. Намайг 8 настай, дүүг 2 настай байхаас эхлээд бид хоёрыг загнаж гараараа зодох болсон. Аав “засарна” гэж дандаа худлаа ярьдаг. Одоо аав байхгүй ээж, анай бид гурав хамт амьдарч байгаа. Удахгүй манайх байгаа газраасаа нүүх гэж байгаа. Аав бид нарын байгаа газрыг мэдчих байх гээд ойрхон ойрхон нүүдэг” гэсэн нь энэ төрлийн гэмт хэрэг ямар их айдас түгшүүрийг орчиндоо бий болгож, хүмүүсийн амар тайван амьдралыг сүйтгэдэгийн нэг жишээ юм.

Сайтад тавигдсан гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хүчиндсэн 10 хэргийг судлан үзэхэд эхнэрээ хүчиндсэн 1, салсан эхнэрээ хүчиндсэн 1, хамтран амьдрагчаа хүчиндсэн 3 хэрэг, дагавар охиноо хүчиндсэн 2, төрсөн охиноо хүчиндсэн 2, дүүгийнхээ хүүхдийг хүчиндсэн 1 гээд үйлдэгдсэн гэмт хэргийн 50 % нь насанд хүрээгүй хүүхдүүдийг хүчиндсэн байх бөгөөд тэдгээрийн үйлдэл нь нэг удаагийнх бус удаа дараа хүчиндсэн байх нь эмзэглүүштэй асуудал юм. Энэ бол эцэг эх, ах, эгч дүүс хүүхэддээ болон дүү нартаа тавих халамж анхаарал, хараа хяналт үгүй болсонтой холбоотой төдийгүй эцэг эх хүүхдээ хайхрахгүй байгаагийн бас нэг илрэл гэлтэй.

¹ Дорнод аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2018/211

²СХД-н Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 100 /www.shuukh.mn 2018

Гэр бүлийн хүчирхийллийн нэгэн төрөл болох бэлгийн хүчирхийлэл, тэр дундаа насанд хүрээгүй болон бага насны хүүхдийг хүчиндэх гэмт явдал буурахгүй, зарим тохиолдолд хохирогчийг айлган сүрдүүлснээс эсвэл хор уршгийг ойлгохгүйгээс нууж явсаар хүүхдээрээ хүүхэд төрүүлэх нь тохиолдол байсаар байна. Тухайлбал, хойт эцэгтээ удаа дараа хүчиндүүлэн хүүхдийг нь төрүүлсэн насанд хүрээгүй хохирогч мэдүүлэхдээ: “Би өөрөө аавгүй өссөн болохоор дүү нараа өнчирүүлмээргүй байна. Би гомдолгүй”¹ гэжээ. Шүүх шүүгдэгчид 3 жилийн хорих ял шийтгэжээ.

Мөн сайтад 2018-2020 оны хооронд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн 8 хэргийн шийтгэх тогтоолыг тавьсан байх ба тэдгээрийн 1 нь насанд хүрээгүй төрсөн дүүгээ зодож алсан, 3 нь эхнэрээ хутгалж алсан бол, 1 эмэгтэй нөхрөө хутгалж алсан, хамтран амьдрагч эмэгтэйг боож алсан, хамтран амьдрагч эмэгтэйгээ хутгалж алсан төдийгүй бага насны /12 настай/ дагавар хүүхдийг нь хутгалж алахыг завдсан, эх нь согтуугаар төрсөн хүүхдээ /6 настай/ заазуурдаж алахыг завдсан хэргүүд байна.

Дээрх хэргүүдийн 2-ыг хардалтын улмаас, 5 хэрэг нь таарамжгүй харилцааны улмаас маргалдаж амь насыг нь хөнөөсөн бол, архины хамааралтай эх өөрийн ухаангүй согтуу байхдаа 6 настай хүүгээ заазуурдсан байна.

Эдгээр хэргийн 4 буюу 50 % нь согтуугаар үйлдсэн бол, 6 буюу 75%-ийг хүйтэн зэвсэг /хутга, заазуур/ хэрэглэж үйлдсэн байна. Гэмт хэрэг үйлдсэн 2 эмэгтэй архины хамааралтай байжээ.

Кейс:

Хохирогч О мэдүүлэхдээ: Би нөхөртэйгээ 2003 онд гэр бүл болж одоо хүртэл хамт амьдарч, байна. Дундаасаа охин, хүү 2-той. Хурим хийснээсээ хойш нөхөр хааяа архи уухаараа тодорхой шалтгаангүйгээр гар хүрдэг байсан. Сүүлийн хэдэн жил архи согтууруулах ундааны зүйл байнга хэрэглэж, уух болгондоо хэрүүл маргаан хийдэг. Хоёр хүүхэд маань байнга айдастай, согтуу үед нь гэртээ байж чадахгүй шөнө орой гадуур хонох үе олон гарч байсан. 2017 оны 05 дугаар сарын сүүлээр согтуу ирээд шөнө унтаж байхдаа сэрээд хажууд байсан цэнэглэгчээр хоолой боосон. 2018 оны 05 дугаар сарын эхээр архи ууж ирээд гал тогооны шүүгээн дээрээс хутга аваад та нарыг ална гээд бидэн рүү дайрах үед бид гэрээсээ зугтааж тэр өдрөөс хойш гэртээ ооогүй. Нөхрөөсөө нууцаар хаа сайгүй байшин түрээслэж амьдарч байна. Бид сэтгэл санааны хувьд байнгын айдас түгшүүртэй хэцүү байна. Аль болох хурдан хэргийг шийдэж өгч хуулийн хариуцлага оногдуулж өгнө үү...” /хх-ийн 65-67 дугаар хуудас²

Ийнхүү гэр бүлийн доторх замбраагүй /эр, эмгүй/ архидалт, хардалт, гэр бүлийн харилцааны тогтворгүй байдал /ялангуяа хамтран амьдрагчдын/ зэрэг нь дээрхи гэмт хэргүүд үйлдэгдэх шалтгаан нөхцөл нь болж байна.

Энэ бүхэн нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч эрхэлсэн ажилгүйн улмаас бухимдаж, бухимдлаа архи ууж согтууран гэр бүлдээ агсам тавих, гэр бүлийн гишүүдийг дарамтлах, зодох, гэр бүлийнхнээ уруу татан архинд оруулах, эдгээр үйлдэл нь даамжирсаар өөрийг нь хохирогч, өрөөлийг гэмт хэрэгтэн болгоход ч хүргэж байна.

Хорих ангид ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн 30 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртөж, тэсвэр тэвчээр алдагдсаны улмаас нөхөр эсвэл хамтран амьдрагчийнхаа амь насыг хөнөөсөн хэрэгт 10-15 жил, түүнээс дээш жилээр хоригдох ял эдэлж байна. Хохирогчид дунджаар 2-3 хүүхэдтэй, орох оронгүй, ах дүү, төрөл садангүй, заримынх нь хүүхэд нь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай аав ээжтэй зэрэг нь тэднийг байнгын сэтгэл зүйн дарамтад байлгадаг тухай³ судалгаа ч өмнө нь хийгдэж байсан билээ.

¹ БЗД-ийн Эрүүгийн хэргийн Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 1207. 2018.08.23. www.shuukh.mn

² Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 488. 2018.10. 12.

³ Г.Ганбаатар. Хүн алах гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй ялтангуудын дунд явуулсан судалгаа. 2015.

Ийнхүү “гэр бүлийн хүчирхийлэл” гэх үзэгдэл үйлдэж байгаа болон өртөж байгаа хэн хэнийхээ амь биед аюултай гэдгийг харуулж байна.¹

Судалгаагаар ял эдэлж байгаа эмэгтэйчүүдээс хань ижил, ах дүү, найз нөхөд нь нүүр буруулсан, 35.3 хувь нь гэр бүл цуцалсан, 27.7 хувь нь хүүхэд нь сургууль завсардсан, 16.8 хувь нь тэнэмэл амьдралтай болсон, 36.1 хувь нь орон гэргүй болсон, эд хөрөнгөө алдсан, 23.5 хувь нь эцэг, эхийнх нь аль нэг нь нас барсан² зэргээр гэр бүлд нь өөрчлөлт гарсан байгаа нь тэдгээрийн ар гэр давхар хохирол амсдаг болохыг харуулж байгаа төдийгүй ял эдэлж байгаа эмэгтэйчүүд ял эдлээд гарахад очих орон гэргүй, ажил олдохгүй, хүмүүс үл ойлгох, үл итгэх, бичиг баримтын асуудалтай зэрэг бэрхшээл тулгарахаас эмээж суудаг нь сэтгэл зүйн давхар дарамт эдэлж суугаагийн илрэл юм.

Гэр бүл нь нийгмийг бүрдүүлэгч анхдагч нэгж болохын хувьд нийгмийн хөгжлийн өөрчлөлтийг дагаж хувьсаж гэр бүлийн амьдралын тогтсон хэв маяг өөрчлөгдөх, хүмүүсийн төрх, ёс суртахуун, харилцаа эрс хувирах нөхцөл³ болдогийн бодит жишээ энэ ажээ.

Энэ бүхнээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл манай оронд бодитойгоор оршин нийгмийн тодорхой хэсгийн, тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг ихээхэн зөрчиж байдаг нь харагдаж байна.

Гэмт хэрэг үйлдэгсдийн талаар:

Сайтад байршуулсан шүүхийн шийтгэх тогтоолд хүний эрх, нэр төрийг хамгаалахтай холбоотойгоор зарим шүүгдэгчийн хувийн огт мэдээлэл байхгүй, заримд нь хагас дутуу байсан ба бид байгаа мэдээллийн хүрээнд дараах судалгааг хийлээ.

Шүүгдэгчдийн нийгмийн байдал:

1) Хүйс

- Эрэгтэй - 100
- Эмэгтэй – 3 /хүн амины хэрэг/

2) Нас

- 18 настай - 1
- 20-25 насны – 5
- 26-30 насны – 12
- 31-35 насны – 14
- 36-40 насны – 18
- 41-46 насны – 11
- 47-50 насны – 7
- 51- 56 насны – 4

3) Боловсрол

- Дээд - 16
- Тусгай дунд - 5
- Бүрэн дунд – 26
- Бүрэн бус дунд - 19
- Бага боловсролтой - 6
- Боловсролгүй - 7

4) Мэргэжил

- Мэргэжилтэй - 50

¹Т.Мөнхдалай. Гэр бүл дэх хүчирхийлэл, эмэгтэйчүүдээс гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлөх нь //Шинжлэх ухаан, практикийн анхаарал татсан асуудлууд. Эрдэм шинжилгээний бичиг-23. УБ., 2010. х.18.

²Г.Ганбаатар. мөн тэнд

³А.Цэрэннадмид. Монголын гэр бүлийн харилцааны уламжлал, шинэчлэлийн зарим асуудал //Монгол гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэлийн зарим асуудлууд. ЭШХ-ын илтгэлүүд. УБ., 1998. х.24

- Мэргэжилгүй - 38
- 5) Хөдөлмөр эрхлэлт**
- Төрийн алба хаагч – 2
- Төрийн бус байгууллагын ажилтан -3
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч - 29
- Малчин - 8
- Ажилчин - 10
- Ажилгүй – 47
- Сурагч – 1

Гэмт хэргийг согтуугаар үйлдсэн 79, урьд ял шийтгэгдэж байсан 19, тэдгээрийн 12 нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хэргээр ял шийтгүүлж байжээ.

Дээрх тоо мэдээг дүгнэн үзвэл, гэр бүлийн хүчирхийллийг боловсрол, мэргэжлийн төвшин хамаарахгүйгээр бүх насныхан үйлдэж байгаа бөгөөд тэр дундаа гэр бүлийн амьдрал зохин, амьдралаа авч явах үүрэгтэй, ухаан сууж төлөвшсөн байх учиртай 35-55 насныхан энэ төрлийн гэмт хэргийн бараг 50 %-ийг үйлдэж байгаа нь түгшүүр төрүүлж байна.

Нөхрөө алсан 62 настай эмэгтэйн мэдүүлэг: Бид хоёулаа хамт архи хэрэглэдэг болсон төдийгүй нэгэн удаа миний 2 дүү ирээд 4-л архи ууцгаасан. Энэ үер би дүү нартаа нөхрөө миний шүднүүдийг цохиж унагасан, одоо хиймэл шүдтэй, бас хөл хугалсан хэцүү байна гэж ярьсан. Дүү нарыг явсаны дараа нөхөр “чи муу дүү нартаа намайг хөл хугалсан, дарамтал сан гэж хэлээд байхдаа яадаг юм бэ” гээд уурлаад, босч ирээд хоёр гараараа миний хоолой боосон. Яг тэр үед миний баруун гарт хар иштэй хутга / махан дээр байсан/ баригдсан. Би нөхрөө айлгах санаатай хутгатай гараараа өөдөөс нь далайгаад баруун дээрээс зүүн доошоо чиглэлтэй савсан гэхдээ хутгалчихлаа гэж мэдээгүй. Айлгах санаатай өөрийгөө хамгаалаад л урдаас нь хутгатай гараараа савахад ийм зүйл болчихсон байна¹ гэж мэдүүлжээ.

www.shuukh.mn сайтын шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэрэг үйлдэгчдийн **51.7 хувь нь эрхэлсэн ажилгүй, 57 хувь нь согтуугаар** гэмт хэргийг үйлджээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид нь гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд, бие махбодид халдан гэмтэл учруулах, амь насыг нь хохироох явдал шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргүүдийн **60 хувийг** эзэлж байна.

Шүүхээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, түүнтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчид дараах шийтгэлийг оногдуулсан байна. Үүнд:

- Тэнссэн -19;
- Нийтэд тустай ажил -12;
- Торгох – 11;
- 6 сараас 11 сар хүртэл хугацаагаар хорих – 25;
- 1 – 2 жил хүртэл хугацаагаар хорих – 10;
- 3-5 жил хүртэл хугацаагаар хорих – 4;
- 5-10 жил хүртэл хугацаагаар хорих -6;
- 10-15 жил хүртэл хугацаагаар хорих – 1;
- 16-20 жил хүртэл хугацаагаар хорих -2;
- Бүх насаар нь хорих – 1.

Нийт шийтгэлийн 53.8 %-ийг эрх чөлөөг нь хязгаарлаж нийгмээс тусгаарлах буюу хорих ялаар, 12 %-ийг торгох, 20.8 %-ийг тэнсэх, 13.1%-ийг нийтэд тустай ажил хийлгэхээр

¹ Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 0278. 2020.03.18

шийдвэрлэсэн байна. Бага хугацаагаар хорьж байгаа тохиолдолд тухайлбал, 6 сараас 1 жилийн хооронд хорих ялыг оноохдоо нийтэд тустай ажил хийлгэх, архи уухийг хориглох зэрэг үүрэг хүлээлгэх арга хэмжээ хамтад авч байна.

Мөн хугацаанд судалсан 139 хэргийн 10 буюу 7.1 хувийг хэрэгсэхгүй болгожээ. Хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн үндэслэлд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсвэл тухайн үйлдэлд захиргааны арга хэмжээ авагдсан гэх үндэслэлүүд багтаж байна.

Хохирогчдын ядуу, зүдүү амьдралтай холбоотойгоор шалтаг шалтгаангүйгээр байнга дарамтлах, амжиргаатай буюу ажил хөдөлмөргүй, эдийн засгийн чадвахгүй байдалтай холбоотой хэрүүл, маргаан, хардалт, бие биедээ үл итгэх, үл хүндлэх, үл ойлголцол зэргээр шалтаглан гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотой хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдэх нь ердийн үзэгдэл болсон байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын ихэнх нь хүчирхийлэлд өртөж байгаа тухайгаа бусдад мэдэгдэж байгаагүй, харин хүчирхийлэл даамжирсаны дараа буюу тэсэж чадахаа больсон тохиолдолд цагдаагийн байгууллагад хандах нь нийтлэг байна.

Хохирогчид хүчирхийлэл ийнхүү даамжирсаныг: Цагдаагийн байгууллагад хандсан иргэдийн хувьд, хүчирхийлэгчийг согтуу байвал цагдаагийн байгууллага эрүүлжүүлээд гэр рүү нь явуулдаг, эсвэл хэд хоног баривчлагдаад буцаад ирдэг төдийгүй эрүүлжигдсэн болон торгуулийн мөнгийг хохирогч төлөх болдогтой холбоотойгоор хүчирхийллийг тэвчин амьдардаг гэсэн бол, зарим иргэдийн хувьд: “Гэр бүлийн нэр хүндийг бодох, хүүхдүүдийнхээ эцэг нь гэж хүндэтгэхийн зэрэгцээ хүүхдээ өнчрүүлэхгүй байх, тэжээгчээ алдахаас айх, хүчирхийлэгчийг ухаарах байх гэж итгэх” зэрэг шалтгаануудын улмаас цагдаагийн байгууллагад хандаагүй хэмээн шүүхийн болон мөрдөн байцаалтын шатанд мэдүүлжээ.

Хохирогч ийнхүү гэр бүлийн хүний хүчирхийллийг “хэвийн үзэгдэл” мэт хүлээн авдаг хандлага нь хүчирхийлэл оршин байсаар байх нэг үндсэн шалтгаан болж үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Дийлэнхи хохирогчдын хувьд өөрийн нь гэх ах дүү муутай, эцэг, эх нь өндөр настай буюу өмгөөлөн хамгаалах чадваргүй, эдийн засгийн хувьд хүчирхийлэгчээс хараат /хохирогч эрхэлсэн тодорхой ажилгүй, цалин хөлсгүй буюу эдийн засгийн эрх чөлөөгүй/ байдал, өөрийн гэсэн орон байргүй зэрэг нь хүчирхийллийг тэвчин амьдрах гол хүчин зүйл болж байна.

Мөн хохирогчдийн бараг 90-д хувь нь шүүхийн шатанд гомдох, нэхэмжлэх зүйл байхгүй гэж мэдүүлсэн нь гэмт хэрэг үйлдэгчийн хэргийг хөнгөрүүлэх, хөнгөн шийтгэл оногдуулах нөхцөл болсон байна.

Ийнхүү нийгмийн тогтолцоо шинэчлэгдэн хэлбэршихэд хүмүүсийн аж төрөх арга ухаан, оюун санаа, ёс суртахуун, гэр бүлийн харилцааны өвөрмөц шинэ төрх бүрддэг бөгөөд энэ чанараараа гэр бүл нь нийгмийг бүрдүүлэгч анхдагч нэгж болохынхоо хувьд нийгмийн хувьсал, шинэчлэлийн үүр нь болж байдгийн¹ жишээ энэ байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-д заасан бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн зэрэг хүчирхийллийн аль нэгийг “байнга” үйлдсэн тохиолдолд дээрхи гэмт хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдэх тухай 2019.12.04-ний өдрийн УДШ-ийн 630 дугаар тогтоол гарсан.

Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл нь ямар тохиолдолд гэмт хэрэгт тооцохыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан” үйлдэл нь “**байнга**” буюу “байнгын

¹А.Цэрэннадмид. Монгол гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэл//Монгол гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэлийн зарим асуудлууд. ЭШС-ны илтгэл өгүүлгүүд. 1998. х.19

шинжтэй” байхаар хуульчилсан нь тодорхой үйлдэл, эс үйлдэхүйн давтамжийг тодорхойлох эрүүгийн эрх зүйн онолын ойлголт бөгөөд харин тоон илэрхийллийн хувьд 3 ба түүнээс дээш удаа үйлдэгдсэн байхыг шаарддаг нь хууль хэрэглээний ойлголт юм.

Гэр бүлийн хамааралт байдлыг далимдуулан 3 ба түүнээс дээш удаагийн хуульд тоочин заасан бие даасан үйлдэл нь Эрүүгийн хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх шинжийг агуулах бөгөөд шүүхүүд ч УДШ-ийн дээрх тогтоолыг баримтлан хэргийг шийдвэрлэж байна.

Бодит байдлаас үзэхэд хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүд энэхүү байнгын шинжийг илэрхийлэх 3 ба түүнээс дээш удаа гэсэн тоог гүйцээхийн тулд зодуулах, харгис хэрцгий харьцаа, догшин авир, тарчлаасан үйлдлийг тэвчин тэсэхэд хялбар биш бөгөөд хор уршгийг урьдчилан таашгүй. Тиймээс эл хэм хэмжээг гэр бүлийн хүчирхийллийн “зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан” үйлдэл бүхий хэрэг дээр хэрэглэх нь хир зохимжтой талаар эргэн харууштай санагдана. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн захиргааны арга хэмжээ авагдсан бол 3 дахь удаагаа үйлдэхийг хүлээхгүйгээр эрүүгийн хариуцлага тооцдог байх, харин гэр бүлийн хамааралт байдлыг далимдуулан сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд “байнгын” шинжийг шаардах нь илүү зохимтой гэж үзэж байна.

Тиймээс Монгол улсын Эрүүгийн хуулийн 11.7 зүйлийн 1 хэсгээс :байнга: гэдэг үгийг хасаж 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “**Гэр бүлийн хүнийг: гэх, мөн зүйлийн 1.3 заасан хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд байнга халдсан бол ...**” гэж өөрчлөх нь зүйтэй.

www.shuukh.mn албан ёсны сайтад байгаа Анхан шатны шүүхийн шийдвэрүүдийг үндэслэн сүүлийн 3 жилд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон түүнтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэргүүдээс дүгнэлт хийвэл:

1) Иргэний нийгмийн байгууллагуудаас явуулсан олон арван судалгааны дүнд манай улсад гэр бүлийн хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, эрэгтэйчүүдийг хүчирхийлэх, хүүхэд хүчирхийлэх, ахмад насныхныг хүчирхийлэх хэлбэрээр явагддаг гэж ангилан төрөлжүүлсэн нь үндэслэлтэй болохыг дээрхи хэргийн баримтууд нотлон харуулж байна.

2) Хэдийгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгааг мэдсэн хэн боловч Цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүргийг хуулиар хүлээлгэсэн ч өнөөдөр гэртээ болон гудамжинд гэр бүлийн гишүүнийг хүчирхийлэх явдал байсаар байгаа бөгөөд хүчирхийлж байгаа нь ч, түүнийг харж, сонсож байгаа нь ч өрөвдөн хайрлах сэтгэлгүй, ёс суртахуунгүй, үүрэг хариуцлага гэдгийг мэддэггүй иргэд өсөн торнисоор байгаагийн илрэл төдийгүй иргэдийн дунд гэр бүлийн хүчирхийлэл хэмээх гэмт явдал “ердийн үзэгдэл”-ийн хэмжээнд үнэлэгдэх болсны илрэл юм.

3) Сошиал медиагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тухай мэдээлэх нь энэхүү гэмт үзэгдлийг ердийн үзэгдлийн хэмжээнд үнэлэх хүчин зүйл болж байна.

4) Манай иргэдийн эдийн засгийн боломж нөхцөлтэй холбоотойгоор дийлэнх гэр бүлүүд эцэг эх, ахан дүүс болон хадмуудтайгаа нэг гэрт, эсвэл нэг хашаанд хамтран амьдардаг, тэндээс гараад буюу хүчирхийлэгчээс салахад очих газар, дэмжин туслах хүнгүй байдал нь хохирогчийг хүссэн, хүсээгүй гэмт этгээдтэй эвлэрэхээс аргагүй байдалд хүргэж байгаа бөгөөд төр засаг нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн олговор өгөх зэрэг эдийн засгийн чадавхгүй байдал нь хохирогч хохирогчоороо үлдэх, Үндсэн хуульд заасан “аюулгүй орчинд амьдрах, халдашгүй дархан байх” эрх зөрчих нөхцөлийг бүрдүүлж байна.

5) Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой харилцах хууль, шүүхийн байгууллагын ажилтнууд нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг өнөө ч зөрчил

төдийгээр үздэг хандлага, хохирогчийг гэм бурууг тогтоон нотлох хэрэгсэл болгодог уламжлалт хандлагаас салж чадахгүй байгаатай холбоотойгоор иргэдийн амь насыг хамгаалж чадахгүй байна. Тухайлбал, 2015 онд иргэн Б гомдлыг нь шалгаж байсан хүнд хамтран амьдрагч нь алахаар заналхийлж байгаа тухай мэдэгдсэн боловч, албаны хүний хайхрамжгүй, хариуцлаггүйн уршгаар иргэн Б тухайн өдөртөө хамтран амьдрагчийнхаа гарт амиа алдсан¹ хэрэг гарч байсан билээ гэтэл энэ байдал мөн л 2020 онд давтагдсан харамсалтай хэрэг гарсан байна.

6) Монгол улсын Үндсэн хуульд: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсан ч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон түүнтэй холбоотой үйлдэгдэх гэмт хэргүүдийн өнөөгийн нөхцөл байдлаас харахад төр Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн хангалттай биелүүлж чадахгүй байна гэж үзэх үндэстэй байна.

7) Үндсэн хуульд заасанчилан Монгол улсын иргэн нь амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй ч гэр бүл, түүний гишүүдийн амгалан тайван, сайн сайхан амьдралын баталгааг бүрдүүлж өгөх үүрэгтэй төр нь иргэдийн эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ялангуяа ажлын байрыг бий болгох чиглэлд далайцтай арга хэмжээ авахгүй байгаа нь гэр бүлд хямрал үүссэх нөхцлийг бүрдүүлж байна.

8) Хэдийгээр гэр бүлийн бүрэн бүтэн байдал чухал ч зайлшгүй шаардлагатай тохиолдолд Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1. дэх хэсэгт: “*Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцална*” гэсэн заалтыг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч төдийгүй хүний эрх ашгийг хамгаалж байгаа байгууллага, иргэдийн санаачлагаар хэрэгжүүлэх боломжтой гэдгийг практик ажилтнууд нэг мөр ойлгож хэрэгжүүлэх нь шаардлагатай.

9) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж эхэлсэн цагаас хойш энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрөөс олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч гэмт хэрэг буурахгүй харин ч өссөн байна. Тухайлбал, 2015 онд хийсэн гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотойгоор үйлдэгдэг гэмт хэргийн талаар хийсэн судалгаа, 2020 онд хийсэн энэхүү судалгаатай харьцуулан үзэхэд гэмт хэргийн тоо өссөн, үйлдлийн арга нь улам харгис хэрцгий шинжтэй болсон байна.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй дан ганц эрх зүйн аргаар тэмцэх нь үр дүн багатай байх тул:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн болон Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тухай хуулийн заалтын талаар сошиал медиагаар сурталчлан таниулах,
- Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл нь ямар тохиолдолд гэмт хэрэгт тооцохыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан” үйлдэл нь “байнга” буюу “байнгын шинжтэй” байхаар хуульчилсаныг дараах байдлаар өөрчлөх шаардлагатай. Монгол улсын Эрүүгийн хуулийн 11.7 зүйлийн 1 хэсгээс “байнга” гэдэг үгийг хасаж “*Гэр бүлийн хүнийг:*” гэх, мөн зүйлийн 1.3-т: хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд гэдэг үгийн дараа “байнга”

¹Эрүүгийн 2015..... дугаартай хэрэг

гэдэг үгийг оруулан “хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд байнга халдсан бол ... “ гэж өөрчлөх,

- Нийгэм, эдийн засгийн арга буюу гэр бүлийг ажилтай орлоготой /гэр бүл, амжиргаагаа аваад явах цалин хангамжтай буюу эдийн засгийн чадвартай/ болгохын тулд ажлын байр олноор бий болгох,
- Гэмт хэргийн хохирогч, гэрч мэдүүлэгээсээ татгалзсан, гомдлоо буцаан авах хүсэлт гаргасан эсэхийг үл харгалзан хэргийг шүүхээр шийдвэрлэдэг байх,
- Гэр бүлийн харилцааны уламжлалт зан заншил, ёс зүйг бүх нийтэд төлөвшүүлэх үүднээс гэр бүлийн харилцааны боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх нь энэ цаг үед хамгийн үр дүнтэй байх болно гэж үзэж дээрх саналуудыг дэвшүүлж байна.

Ийнхүү манай улс нийгмийн шинэ тогтолцоонд шилжиж, нийгэм, улс төр, эдийн засгийн шинэ нөхцөлд иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэр бүлийн харилцаанд хямрал үүсэх нь нийгэм болон улс оронд тулгарч буй хямрал, бэрхшээлийн илэрхийлэл, харин гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн харилцааны тогтворт байдал алдагдсаны шинж, гэр бүлийн дотоод хямралын илрэн гарах хэлбэр нь болж байна.¹

¹ Г.Ганбаатар Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүйн тулгамдсан асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2016. 3 дахь тал

§ 1.2 . Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан шийтгэлийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл

Гэр бүлийн хүчирхийлийн улмаас гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан эрүүгийн хариуцлагыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрхэн хэрэгжүүлж буй байдалд сүүлийн 3 жилийн статистик мэдээлэл болон бусад судалгааны эх сурвалжид тулгуурлан дүн шинжилгээ хийж тулгамдсан асуудал, хүндрэл бэрхшээлийг нээн харуулах, тодорхой санал дэвшүүлэх, шийдлийг гаргах зорилгоор энэхүү судалгааны дэд бүлгийг боловсруулав.


2020 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа 71 ялтан, баривчлах ялаар шийтгэгдсэн 7420 этгээд, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 2, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан 73, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан 18 этгээдэд шүүхээс оногдуулсан эрүүгийн хариуцлагыг эдлүүлэн ажилласан байна.

Шүүхээс оногдуулсан эрүүгийн хариуцлагыг төрлөөр нь ангилавал:

Нэг. Хорих ял

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэж /ЭХ-ийн 11.7/ хорих ялаар шийтгэгдэн ял эдэлж байгаа хоригдлын тоон судалгааг урьд оны мөн үетэй харьцуулахад 16.3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

График 1.2. Харьцуулсан тоон үзүүлэлт **График 1.3.** Боловсролын түвшин



Хүснэгт 1.3. Хорих ялаар шийтгэгдсэн хоригдлын боловсролын түвшинг насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт /2020 оны байдлаар тоо болон хувиар /ЭХ-ийн 11.7/

Насны бүлгээр	Хоригдол	Боловсролгүй	Бага	Бүрэн бус дунд боловсролтой	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Нийт	71	8	11	11	28	6	9
20-24	-	-	-	-	-	-	-
25-34	21	1	2	2	7	2	3
35-44	21	3	6	3	11	-	1
45-54	25	4	2	5	9	1	5
55-64	4	-	1	1	1	1	-

Хүснэгт 1.4. Дүнд эзлэх хувь

Насны бүлгээр	Хувь	Боловсролгүй	Бага	Бүрэн бус дунд боловсролтой	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Нийт	100	11.2	15.4	15.4	39.4	8.4	12.6
20-24	-	-	-	-	-	-	-
25-34	29.5	1.4	2.8	2.8	9.8	2.8	4.2
35-44	29.5	4.2	8.4	4.2	15.4	-	1.4
45-54	35.2	5.6	2.8	7.0	12.6	1.4	7.0
55-64	5.6	-	1.4	1.4	1.4	1.4	-

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222.1-д: “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм бодистой холбогдсон, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйл нөлөөлөх албадан сургалтыг:

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдсон гэмт хэрэгт шийтгүүлсэн хоригдолд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний аргачлал”,
- “Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх нь”,
- “Уур бухимдлаа зохицуулах нь”,
- “Харилцах чадвараа сайжруулах нь” сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрүүдийг сургалтад ашиглаж, мөн өөрсдийн нөөц боломжид тулгуурлан сургалтын материалыг бэлтгэж, ганцаарчилсан-бүлгийн, биечилсэн -видео- алсын зайн сургалт зэргээр зохион байгуулж байна.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222.1-д зааснаар хорих анги, байгууллагад зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг 7-14 хоногт 1 удаа зохион байгуулж байгаа ч хорих ялын хугацаа бага, хорих ангид ирсэн, суллагдсан хөдөлгөөн ихтэй байдал нь сургалтын үйл явц, үр дүнд нөлөөлж, хэлбэр төдий зохион байгуулахад хүргэх талтай байна.

Улс оронд цар тахалын хүндрэлтэй нөхцөл байдал үүсэнтэй холбоотойгоор хорих ангид ял эдэлж буй хоригдлуудад зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хэсэгчлэн ганцаарчилсан, цахим хэлбэрээр 2020 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд зохион байгуулсан ба дүнг нэгтгэж үзэхэд:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн давхардсан тоогоор 2510 хоригдолд 322 удаагийн 543 цагийн, 4 сэтгэл зүйн хөтөлбөр, 36 сэдвээр сургалтыг;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдож гэмт хэрэгт шийтгүүлсэн давхардсан тоогоор 5037 хоригдолд 341 удаагийн, 572 цагийн, 117 сэдэв, 7 сэтгэл зүйн хөтөлбөр, аргачлалаар сургалтыг;

- Согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай давхардсан тоогоор 5095 хоригдолд 269 удаагийн 542 цагийн 120 сэдэв, сэтгэл зүйн 3 хөтөлбөр сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

График 1.4.



Дээрх графикаас үзэхэд согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдож гэмт хэрэгт шийтгүүлсэн хоригдлын зан үйлд нөлөөлөх, албадан сургалтад хамруулах үйл явц, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн хоригдолд зохион байгуулах сургалтаас 50 хувийн зөрүүтэй байгаа нь харагдаж байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэйн улмаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулж байгаа эрүүгийн хариуцлагын хувьд хорихоос өөр төрлийн ял албадлагын арга хэмжээ тулхүү оногдуулж байгаатай холбоотой.

Хорих ял эдэлж буй хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан тэдэнд зориулсан сургалтыг зохион байгуулах нь тэдний зан үйлд эерэг сэдэл өгөх, бодол, санаанд нөлөөлөх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, өөртөө дүгнэлт хийх, эерэг өөрчлөлтийг хэрэгжүүлэх зан үйлд сургах зэрэг ач холбогдолтой юм

Хорих анги, байгууллагын сэтгэл зүйчдийн хувьд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа хоригдлуудын зан үйлд нөлөөлөх албан сургалтын хөтөлбөр, аргачлал боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Энэхүү сургалтын үр дүнг сайжруулах чиглэлээр:

- Ажлын байрны онцлогтой холбоотойгоор сэтгэл зүйчийг мэргэшүүлэх, заах арга зүй, бүлгийн зөвлөгөөн зохион байгуулах арга зүйд суралцуулах;
- Хоригдлын сэтгэл зүйн онцлогт тохирсон хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах;
- Хоригдлын зан үйлийн илрэл, бусад хамаарлыг тодорхойлон холбогдох сургалтад хамруулах зэрэгт анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хоёр. Хорихоос өөр төрлийн ял:

2020 оны байдлаар улсын хэмжээнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн 2 ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хэргээр буюу 50 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Гурав. Албадлагын арга хэмжээ:

2020 оны 9 дүгээр сарын байдлаар нийслэл, орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгүүд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэж албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны 40, тухайн онд шүүхээс ирүүлсэн 50, эрэн сурвалжилж албадан ирүүлсэн 1, нийт 91 этгээдэд хяналт тавьж ажиллаа. Энэ хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлж, хяналтын хугацаа дууссан 43, хугацаанаас өмнө ялаас чөлөөлсөн 2 шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан 17, дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 3, нас барсан 2, тайлант хугацаанд шинээр эрэн сурвалжилсан 2 этгээд тус тус хасагдаж, одоогийн байдлаар нийт 34 этгээд хяналтад байна. Албадлагын арга хэмжээ авагдсан төрлөөр нь авч үзвэл:

1) Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээний талаар:

2020 оны 11 дүгээр сарын байдлаар хорих ял оногдуулахгүйгээр тэнссэж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны 38, тухайн онд шүүхээс ирүүлсэн 34, эрэн сурвалжилж албадан ирүүлсэн 1, нийт 73 этгээдэд хяналт тавьж эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлж, хяналтын хугацаа дууссан 28, хугацаанаас өмнө ялаас чөлөөлсөн 1, тэнссэж үүрэг хүлээлгэх, дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн 1, хяналтын хугацаанд нас барсан 1 нийт 41 хасагдаж одоо хяналтанд 32 этгээд байна.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн дээрх 73 этгээдэд шүүхээс зан үйлээ засах сургалтад хамрагдах 23, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах 8, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж буй эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх 2, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах 34, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг 38 этгээдэд хэрэглэхийг хориглох үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг тус тус давхардсан тоогоор оногдуулжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан **“Зан үйлд нөлөөлөх сургалт”** зохион байгуулах журам, сургалтын төлөвлөгөөний дагуу хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч,

“Хөдөлмөрлөх дадал олгох” сургалтыг хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, “Гэр бүл хүүхдийн сэтгэл зүйн боловсролыг дэмжих төв” төрийн бус байгууллага, нутаг дэвсгэрийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх “Насан туршийн боловсролын төв”, орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран,

“Сэтгэл зүйд нөлөөлөх” сургалтыг согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглосон үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнтэй тус тус хамтран сургалт зохион байгуулж байна.

2) Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоогдсон этгээдийн талаар:

2020 оны 11 дүгээр сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгэгдэн хугацаанаас өмнө тэнсэн суллагдах албадлагын арга хэмжээ авагдсан урьд оны 2 этгээд, мөн онд шүүхээс ирүүлсэн 16 нийт 18 этгээдэд хяналт тавих эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас шүүхээс хүлээлгэсэн үүрэг,

хязгаарлалтыг биелүүлж, хяналтын хугацаа дууссан 15, дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн 1, нийт 16 этгээд хасагдаж одоо хяналтанд 2 этгээд байна.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Хорих ял эдлүүлэх алба, хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгүүдээс хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоогдсон этгээдүүдийн талаарх мэдээ, дэлгэрэнгүй судалгааг нэрсээр гаргуулан авч, нэгдсэн бүртгэл хөтлөн тухайн этгээдэд хуульд заасан үүргийг танилцуулж, мэдэгдэх хуудсыг гардуулах, шүүгчийн захирамж, холбогдох материалын бүрдлийг ханган тогтоосон хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Хүснэгт 1.5. Хорихоос өөр төрлийн ял шийтгэл, албадлагын арга хэмжээг сүүлийн 3 жилийн байдлаар хүснэгтээр авч үзвэл /ЭХ-ийн 11.7/:

Шүүхийн шийдвэрийн төрөл	Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих			Гүйцэтгэсэн			Үлдэгдэл			
		2018	2019	2020	2018	2019	2020	2018	2019	2020	
Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн	Нийт ялтны тоо	5	4	2	4	4	2	-	-	-	
Үүнээс	Торгох ял	Ялтны тоо	4	4	2	4	4	2	-	-	-
		Мөнгөн дүн	1800,0	1500,0	800,0	1800,0	1500,0	800,0	-	-	-
	Нийтэд тустай ажил хийлгэх ял	Ялтны тоо	1	-	-	1	-	-	-	-	-
		Мөнгөн дүн	300	-	-	300	-	-	-	-	-
Албадлагын арга хэмжээ авагдсан	этгээдийн тоо	52	83	91	9	44	57	43	39	34	
Үүнээс	Тэнсэж, үүрэг хүлээлгэх эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ	Этгээдийн тоо	48	70	73	7	32	41	41	38	32
	Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон	Этгээдийн тоо	4	13	18	2	12	16	2	1	2

Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 2, албадлагын арга хэмжээ авагдсан 91 этгээдийн боловсролын түвшинг авч үзвэл, 20-24 насны 3, 25-34 насны 32, 35-44 насны 29, 45-49 насны 19, 50-64 насны 10 ялтан буюу 80 ялтан 25-49 насны хооронд байгаа нь 89.2 хувийг эзэлж байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны 2019, 2020 оны статистик, мэдээ дэлгэрэнгүй судалгаа


Дөрөв. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн хэрэгт оногдуулсан шүүхийн шийдвэрийн биелэлт

2020 онд Баривчлах төвд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зөрчих зөрчил үйлдэж /ЗТХ-ийн 5.4/ баривчлагдсан этгээдийн тоон судалгааг урьд оны мөн үетэй харьцуулахад 1.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Бүдүүвч 1.5.Харьцуулсан тоон үзүүлэлт



Бүдүүвч 1.6.Насны түвшин



Зөрчил үйлдэж баривчлагдсан 7420 этгээдийн насны байдлыг авч үзвэл: 20-24 насны 319, 25-34 насны 2039, 35-44 насны 2692, 45-54 насны 1577, 55-64 насны 730 этгээд байгаа бөгөөд тэдгээрийн 63,7 хувийг 25-44 насныхан эзэлж байна.

Хүснэгт 1.6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зөрчих зөрчил үйлдэж баривчлагдсан этгээдийн боловсролын түвшинг насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт /2020 оны байдлаар /ЗТХ-ийн 5.4/

Насны бүлгээр	Хоригдол	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Нийт	7420	473	952	1640	2903	632	820
20-24	319	10	62	47	164	27	9
25-34	2039	21	206	506	966	175	165
35-44	2692	180	364	626	1061	196	265
45-54	1577	206	250	264	556	153	148
55-64	730	52	64	159	152	73	230
65 дээш	63	4	6	38	4	8	3

2019 онд Гэр бүлийн хүчирхийллийн улмаас зөрчил үйлдэж баривчлагдсан этгээдүүдийн 524 нь тухайн зөрчлийг давтан үйлдэж баривчлагдсан бол, 2020 онд 140 этгээд дээрх зөрчлийг давтан үйлдэж баривчлагдсан нь урьд оны мөн үетэй харьцуулбал буурсан үзүүлэлттэй байна.

Гэсэн хэдий ч 2020 онд баривчлах төвд баривчлагдсан нийт этгээдүүдийн 62 хувийг гэр бүлийн хүчирхийллийн улмаас зөрчил үйлдсэн этгээдүүд эзэлж байгаа нь нэг талдаа энэ төрлийн зөрчлийн тоон үзүүлэлт нэмэгдсэн боловч боловч иргэдийн эрх зүйн мэдлэг дээрдэж, далд нуугдмал үйлдэгдэг гэр бүлийн хүчирхийлэл ил болж байгаа эерэг талтай юм.

Тав. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зөрчих зөрчилд оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл

Шүүхээс оногдуулж байгаа эрүүгийн хариуцлагын 60-70 хувьд нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг оногдуулж байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүн цаашид гэмт санаа бодол бүхий бие хүн болж төлөвшихгүй, шоронжихгүй буюу эрүүгийн хэв шинжтэй зан үйлтэй болохоос урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн төрийн бодлоготой холбоотой.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль зөрчих зөрчил үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан эрүүгийн болон зөрчлийн хариуцлагыг эдлүүлэхдээ дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдуулахгүй байх үүднээс зан үйл засах сургалтанд хамруулдаг.

Эрүүгийн хуулийн 11.7-д заасан гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа болон Зөрчлийн тухай хуулийн 5.4-т заасан зөрчил үйлдэж баривчлагдсан этгээдүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222.1-д зааснаар ажил үүргийн хуваарийн дагуу тухайн хорих анги, баривчлах төвийн нийгмийн ажилтан сэтгэл зүйчид холбогдох сургалтыг хөтөлбөрийн дагуу явуулдаг. Гэтэл хорихоос өөр төрлийн албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд 2020 оны 06 дугаар сараас эхлэн тухайн хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид холбогдох сургалт явуулах болсон нь нэг талаасаа шийдвэр гүйцэтгэгч ганцаараа сургалт явуулдаг байсныг бодвол сайжруулсан мэт харагдах ч, нөгөө талаасаа нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн ажлын ачаалал 2-3 дахин их байхад нэмээд албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд “Зан үйл засах” сургалтыг хариуцуулж байгаа нь үр өгөөж муутай, тайланд тусгагдах хэлбэр, тоо баримт төдий зүйл болон хувирч байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.13-т “Албадлагын арга хэмжээ авагдсан хүний “Зан үйлд нөлөөлөх” сургалтыг зөвшөөрөл бүхий төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно”. Мөн хуулийн 299 дүгээр зүйлийн 299.5-д “Энэ хуулийн 169.1-д зааснаас бусад тохиолдолд захиргааны, зөрчлийн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болох хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн хэдий ч дээрхи зардлуудыг улсын төсөвт тусгаж олгохгүй байгаа нь шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Тиймээс энэ асуудлыг зөв оновчтой шийдвэрлэх нь аль аль талдаа үр дүнтэй байх болно хэмээн үзэж дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Нийслэл болон орон нутагт хорихоос өөр төрлийн албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд “Зан үйл засах” сургалтыг дагнан хариуцах мэргэжлийн алба хаагчийн орон тоог бий болгох;
2. Нийгмийн хариуцлагын хүрээнд үүрэн утасны оператор байгууллагуудтай хамтран иргэн бүрийн утсанд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй болон гарсан үед холбогдох байгууллага, албан газрын байршил, албан тушаалтны утасны дугаар зэрэг шаардлагатай мэдээллийг хүргүүлэх ажлыг зохион байгуулах;
3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа этгээдүүд насны хувьд залуужиж байгаатай холбоотойгоор гэр бүлийн зөв хүмүүжлийн тухай эцэг эхэд нь зориулж ажлын байрны сургалт, алслагдсан буюу гэр хорооллынхонд орчинд нь буюу хороо, гудамжаар нь хамруулсан биечилсэн сургалт, сургуулийн насныханд бага, дунд, ахлах гэхчилэн түвшин түвшинд нь зохицсон урт болон богино хугацааны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЧАНАРЫН СУДАЛГАА

§ 2.1. Гэр бүлийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, дүн шинжилгээ

2.1.1. Гэр бүл, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоо бүхий хэм хэмжээ агуулсан хуулийн нэр томъёоны тухай

Монголчуудын хувьд гэр бүлийн үүсэл, хөгжлийг нийгмийн хөгжил, зохион байгуулалттай холбон үзэж судалсаар ирсэн бөгөөд гэр бүлийн харилцаанд ёс заншлын болон хуулийн зохицуулалтын аль алиныг ашиглаж ирсэн өвөрмөц түүхэн уламжлалтай ард түмэн юм.

Этимологи буюу үгийн гарвал зүйн талаас авч үзвэл: “Гэр бүл” гэдгийг Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв нар “айл өрх”, “айл гэр”¹ гэж тайлбарласан бол, Я.Цэвэл “Айл” гэдэг нь өрх ам, гэрийн доторх хүмүүс² гэж тайлбарлажээ.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн нэр томъёоны тайлбар³ хэсэгт: “Гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг ойлгоно” гэж тайлбарласан нь үгийн гарвал зүй дэх “айл гэр”, “айл өрх”, “гэрийн доторх хүмүүс” гэсэн тайлбаруудтай утга нэг байна.

Харин гэр бүлийн гишүүн гэж хэнийг ойлгох тухайд Гэр бүлийн тухай хуулийн нэр томъёоны тайлбар хэсэгт:⁴

➤ “Гэр бүлийн гишүүн” гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг;

➤ “Төрлийн хүн” гэж гэрлэгчдийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг;

➤ “Садангийн хүн” гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг ойлгоно гэсэн нь монгол уламжлалаар өрх гэрийн нэгдлийг илэрхийлсэн бүлэг хүмүүсийг ийнхүү тодорхойлсон байх бөгөөд ерөнхий нэр нь “гэр бүлийн гишүүн” байна.⁵

Гэр бүлийн тухай хуулийн нэр томъёоны тайлбараас харахад гэр бүлийн үндсэн бүрэлдэхүүн буюу гэр бүлийг “хамтран амьдарч буй гэрлэгчид болох эхнэр нөхөр, тэдний төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, харин гэр бүлийн гишүүн нь нэг гэрт амьдардаг эсэхээс хамааралгүй ургийн, овгийн, төрлийн буюу бүхэлдээ цусан төрлийн холбоонд үндэслэсэн төрөл, саданг хамруулсан байна. Өөрөөр хэлбэл, төрөл садан нь “Гэр бүлийн гишүүн” гэсэн нэршилд багтах төдийгүй гэр бүлээс өргөн хүрээтэй ойлголт болох нь харагдаж байна.

Хуулийн дээрх заалтыг үндэслэвэл гэр бүл, түүний гишүүнд тавигдах шаардлагыг:

➤ Гэрлэсэн хосууд болох хамтын амьдрал бүхий эхнэр, нөхөр, хүүхэд байх;
➤ Ургийн болон овгийн холбоотой хүмүүс байх гэдгээр хязгаарласан байгааг хуульчид онцгойлон анхаарах шаардлагатай.

Манай улсын өрхийн бүтэцийн талаар ҮСХ-ноос гаргасан статистик мэдээлэлд тулгуурлан үзвэл: өдгөө Монгол Улсад нийт 823,000 өрх тоологдон, эхнэр нөхөр, хүүхдийн хамт эсхүл эцэг, эхийн аль нэг нь хүүхдийн хамт амьдарч байгаа нь нийт өрхийн 62.4 хувийг

¹Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос-Монгол толь. 55000 орчим үг. УБ., 1982. х.641

²Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. 30.000 орчим үг. УБ., 1966. х.169

³Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.2. 1999. //Төрийн мэдээлэл 1999. №30

⁴Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. 3 дугаар зүйл. 1999

⁵Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүйн тулгамдсан асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2016. 14 дэх тал

эзэлж, нийлмэл ам бүлтэй буюу хамаатан садны хамааралтай хүмүүс өрх үүсгэн (24.9%), ганц бие болон эмэгтэйчүүд толгойлсон өрх (10.6 %) үүсгэн амьдрах хэлбэрүүд бий болжээ.

Гэр бүлийн харилцааны нэр томъёо нь “Хамтран амьдрагч”, “Гэрээт гэр бүл”, “Гэр бүлийн хамаарал бүхий хүн”¹ гэхчилэн шинэчлэгдэн баясан аж.

Манай улсын Эрүүгийн хуулийн Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэмээх 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон ... хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ. “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн” гэдгийг мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт:

- гэр бүлийн гишүүд,
- бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа,
- гэрлэлт нь цуцлагдсан,
- бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн,
- асран хамгаалагч,
- харгалзан дэмжигч,
- асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн,
- тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно” гэж тайлбарласан байна.

Дүгнэн үзвэл, гэр бүлийн хүчирхийлэлд гэр бүлийн гишүүд өртөөд зогсохгүй тухайн гэр бүлтэй харилцаа, холбоотой хүмүүс өртдөг гэсэн санаа урган гарч байгаа ч чухам ямар шалтгаанаар “өртөх магадлалтай” гэж үзсэн нь ойлгомжгүй байгаа юм.

Олон Улсын эрх зүйн хэм хэмжээнд “хохирогч” гэсэн ойлголтод шууд хохирогчийн гэр бүлийн гишүүдээс гадна тэжээн тэтгэгч, түүнчлэн хүнд байдалд орсон хохирогчид тусламж үзүүлэх оролдлого хийж байгаад хохирсон хүмүүс хамаарна² гэсэн заалтыг удирдлага болгосон гэж үзэж болох ч дэлхий нийтэд жишиг болсон зарим эрх зүйн зохицуулалтыг “хэмнэлттэй байх” зарчмын үүднээс “нутагшуулах” гэж байгаа тохиолдолд үндэсний онцлог, хууль тогтоомжийн хэм хэмжээнд нийцэх эсэхийг судалж хэрэглэх нь зохистой.³

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай /гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа/ хүнийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй гэж үзэх нь маргаантай. Учир нь:

1) Цуцлагдсан гэр бүл, түүний гишүүний тухайд, Гэр бүлийн тухай хуулийн “**гэр бүлийн гишүүн**” гэсэн тодорхойлолтод салсан буюу гэр бүл цуцлагдсан этгээдийг гэр бүлийн гишүүнд хамруулан ойлгох тухай заалт байхгүй. Энэ байдлыг залруулах үүднээс салсан эхнэр /нөхөр/, хүүхдийг гэр бүлийн гишүүн гэсэн тодорхойлолтод хамруулан томъёолох нь ч багагүй бэрхшээлийг дагуулж байна. Учир нь Гэр бүлийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1. дэх хэсэгт: “Гэрлэгчдийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах болон гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцогдохоос өмнө, эсхүл гэрлэлтээ цуцлуулснаас хойш нэг жилийн дотор *хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан нь “гэр бүлийн хүчирхийлэл”* ... тэй шууд холбоотой үүссэн... бол салсан нөхөр буюу эхнэрээрээ тэжээн тэтгүүлэх эрхтэй” тухай хэм хэмжээг баримталбал, тэдгээрийг гэр бүлийн гишүүн гэж үзэж болох ч гэр бүлийн хүчирхийллийн улмаас хөдөлмөрийн чадвараа алдаагүй гэрлэлтээ цуцлуулсан болон

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015. 11.7 дугаар зүйл. 11.7.1, 12.1 дүгээр зүйл 2.3.

² Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал. 2 дах хэсэг. НҮБ-ын ЕА. 40/34. 1985.11.29.

³ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. Хохирогч судлал. УБ., 2006.

гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон эхнэр, нөхрийн хувьд гэр бүлийн гишүүн байх боломж нөхцөл нь хаагдаж байгаа юм.

Зарим тохиолдолд салсан нөхөр, хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхгүй атлаа хүүхэдтэйгээ уулзах нэрээр салсан эхнэр, түүний гэр бүлийн гишүүдийг дарамтлан хүчирхийлэх нь бий. Энэ тохиолдолд эцэг эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотойгоор гэр бүлийн гишүүнд тооцож болох ч Гэр бүлийн тухай хуульд зааснаар “гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд ...” гэсэн тодорхойлолттой уялдуулан авч үзвэл “эхнэр, хүүхэд хамт амьдардаг байх” нөхцөлөөр хязгаарлалт хийсэн байх тул салсан эхнэр, хүүхэд хамт амьдардаггүй шалтгаанаар бас л гэр бүлийн гишүүн байх эрх нь хасагдаж байгаа юм.

Тиймээс салсан эхнэр, хүүхэд түүний гэр бүлийнхнийг нь дарамтлан хүчирхийлж байгаа үйлдэл нь гэр бүлийн гишүүд хоорондын буюу гэр бүлийн хүчирхийлэл мөн эсэх нь бас л маргаантай.

2) Амьдрал баялаг учраас асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг дарамтлах, хүч хэрэглэх асуудал гарч болох ба асран хамгаалагч, харгалзан дэмжигч¹ нь төрөл садангийн хүн байгаа тохиолдолд тэдгээрийг гэр бүлийн гишүүн гэж үзэх нь зүй ёсны асуудал ч, харин төрөл, садангийн бус хүн асран хамгаалагч, харгалзан дэмжигч байгаа тохиолдолд тэднийг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнд тооцох асуудал мөн л маргаантай.

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т: “Энэ гэмт хэргийг асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн бол тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгажээ.

Дээрх заалтаас харахад гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн гишүүдээс гадна асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн байж болох тухай заасан нь ойлгомжгүй. Нийгмийн халамж үйлчилгээний ажилтан иргэдийн хүсэлтээр асран хамгаалах, харгалзан дэмжих хүний гэрт амьдарч үйлчилгээ үзүүлдэг болсонтой холбоотойгоор тэднийг гэр бүлд хамааруулав уу? эсхүл асрамж үйлчилгээний байгууллагынхныг бүхэлд нь нэг гэр бүл гэж үзсэн үү? гэдэг нь тодорхойгүй. Эсвэл асруулж байгаа гэр бүлийн гишүүнийг хүчирхийлсэн гэдэг утгаар нь гэр бүлийн хүчирхийлэлд тооцов уу, асран хамгаалж байгаа хүндээ хүч хэрэглэсэн тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэж үзэх болж байна уу? Аль ч утгаар авч үзсэн гэр бүлийн хүчирхийлэлд хамруулах боломжгүй санагдана.

Манай Улсын Эрүүгийн хуульд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ... урвуулан ашигласан... тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай бие даасан зүйл анги бүхий заалт бий.²

3) Бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа гэх этгээдүүд болох гэрийн үйлчлэгч, байр хөлслөгчийг хэлж байна гэж ойлговол, байрны буюу гэрийн эзэн тэдгээрийг дарамталсан, хүч хэрэглэсэн үйлдэл гэрт нь үйлдэгдсэн гэдэг утгаар гэр бүлийн хүчирхийлэлд тооцох уу? Энэ бас л эргэлзээтэй байна.

4) Энэ гэмт хэргийг таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн гэдгийг зөвхөн гэр бүлийн гишүүдээс гэмт хэргийг таслан зогсоох гэсэн үйлдийг эсэргүүцсэн тохиолдлыг хэлж байна гэж ойлгогдож байгаа юм. Түүнээс дээр дурьдсанчилан гэр бүлийн

¹Асран хамгаалагчийг 0-14 хүртэл насны хүүхэд болон сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгээ зөв удирдан жолоодож чадахгүй болсон этгээдийг шүүх эрх зүйн чадамжгүй гэж тооцож, асран хамгаалагч тогтоодог бол харгалзан дэмжигчийг 14-18 хүртэл насны иргэнд тогтоохоос гадна мансуурах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийн иргэний эрх зүйн чадамжийг сонирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх тодорхой хугацаагаар хязгаарлаж харгалзан дэмжигчийг тогтоодог. Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010. х.320

² Монгол Улсын Эрүүгийн хууль. 118 дугаар зүйл. 2002. // Төрийн мэдээлэл. 2002. № 05

хамаарал бүхий харилцаатай хүмүүсээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үед тухайн үйлдлийг таслан зогсоохоор хөндлөнгөөс оролцох үедээ цохиулсан, зодуулсан, эд зүйлээ уруулсан гэдгээр нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэх үү?

Бидний үзэж байгаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх үед гэмт үйлдлийг таслан зогсоохоор оролдож гэмтэл бэртэл авсан, эд материалын хохирол хүлээсэн этгээдүүдийн асуудал нь гэр бүлийн хүчирхийлэлд хамаарахгүй бөгөөд харин гэм буруутай этгээдийн хувьд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хэрэг дээр бусдын эрх, эрх чөлөөнд халдсан, бие эрхтэнд гэмтэл учруулсан, танхайрсан гэхчилэн тухайн үйлдэлд тохирох зүйл ангиар давхар зүйлчилнэ гэж үзэж байна.

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай гэр бүлийн гишүүдээс бусад, хуульд нэр заагдсан этгээдүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл тэдгээрээс үйлдсэн гэмт үйлдлийг “гэр бүлийн хүчирхийлэл” хэмээн өргөн хүрээнд авч үзэх нь энэ төрлийн гэмт хэргийн “**Гэрийн**” буюу “**Гэр бүлийн**” хэмээн онцгойлон авч үздэг шинжийг үгүйсгэсэн гэж үзэх үндэстэй байна.

Учир нь гэр бүлийн хүчирхийлэл нь хүчирхийлэл хаана үйлдэгдсэнээс хамааралгүйгээр зөвхөн гэр бүлийн гишүүдээс үйлддэг буюу гэмт хэргийн эзэн холбогдогч гэр бүлийн аль нэг гишүүн байдаг бол, гэмт хэргийн хохирогч нь ч мөн л гэр бүлийн гишүүд байдагтай холбоотойгоор “Гэр бүлийн хүчирхийлэл” гэж нэрших, хүчирхийлэл үйлдэх зорилго, хүрээ, давтамж зэрэг шинжээрээ бусад төрлийн хүчирхийллийн гэмт хэргээс ялгагдах онцлог нь тодорхойлогдож байдаг.

Тиймээс Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг” гэснийг “**гэр бүлийн гишүүдийг**” гэж өөрчлөх, мөн зүйлийн 2 дах хэсгийн 2.2., 2.3. дахь заалтуудыг хүчингүй болгох саналтай байна.

Хэдийгээр төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар олон төрлийн арга хэмжээ авч байгаа ч энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил буурахгүй харин ч хэргий шинжид шилжиж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлээс иргэдийг хамгаалах бодит алхам бол гэмт хэргийг “бүлийн гишүүдээс үйлдсэн байх” шинжийг ял хүндрүүлэх нөхцөлд тооцож хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын хугацааг нэмэгдүүлэн чангаруулах нь зүйтэй.

Манай улсын өрхийн бүтэцийн талаар ҮСХ-ноос гаргасан статистик мэдээлэлд тулгуурлан үзвэл: өдгөө Монгол Улсад нийт 823,000 өрх тоологдон, эхнэр нөхөр, хүүхдийн хамт эсхүл эцэг, эхийн аль нэг нь хүүхдийн хамт амьдарч байгаа нь нийт өрхийн 62.4 хувийг эзэлж, нийлмэл ам бүлтэй буюу хамаатан садны хамааралтай хүмүүс өрх үүсгэн (24.9%), ганц бие болон эмэгтэйчүүд толгойлсон өрх (10.6 %) үүсгэн амьдрах хэлбэрүүд бий болжээ. Гэр бүлийн харилцааны нэр томъёо нь “Хамтран амьдрагч”, “Гэрээт гэр бүл”, “Гэр бүлийн хамаарал бүхий хүн”¹ зэргээр шинэчлэгдэн баяжээ.

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015. 11.7 дугаар зүйл. 11.7.1, 12.1 дүгээр зүйл 2.3.

2.1.2. Гэр бүл, түүний гишүүдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцид: **“Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”¹, “Гэрлэгсэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлах үед тэгш эрхийг эдэлнэ”²** гэж гэр бүлийн харилцааны суурь зарчмуудыг тунхаглан баталгаажуулсан байх бөгөөд эдгээр хэм хэмжээнүүд нь улс орон болон нийгмийн гишүүн бүрийн, гэр бүлийн гишүүдийн, хүн бүрийн чандлан сахих ёстой нийтлэг стандарт болон тогтжээ.

Хүн бүр амьдарч буй орчин, гэр бүлдээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци, түүний нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн тухай Конвенци, Эхчүүдийг хамгаалах тухай Конвенци, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай Тунхаглал зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичигт баталгаажуулсан байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад гэр бүлийн харилцааны тухайд: “Харилцан бүрэн зөвшилцөөгүй аливаа гэрлэлт байж үл болно. Оролцогч улс бүр ... гэрлэгчдийн эдлэх эрх, хүлээх хариуцлагыг тэгш хангах зохистой арга хэмжээ авах, хүүхдийг яс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйн хувьд шаардлагатай бүхий хамгаалалт эдлэх эрхтэй” болохыг болон гэрлэлт цуцлах тохиолдолд аливаа хүүхдийг хамгаалах талаар шаардлагатай заалт гаргах ёстойг анхааруулжээ.

Эмэгтэйчүүдийг алагчлах буюу ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай Конвенци³ “Эмэгтэйчүүдийг хүчирхийлэх гэдэг нь эмэгтэйчүүдэд бие махбод, бэлгийн буюу сэтгэл санааны гэм хор, зовлон шаналал учруулсан буюу учруулж мэдэх, бэлгийн харьцааны шинжтэй үндэслэлээр үйлдэгдсэн хүчирхийллийн аливаа үйлдэл, мөн ийм үйлдэл хийхийг албадсан, нийгмийн буюу хувийн амьдрал дахь эрх, эрх чөлөөг дур мэдэн хасах явдал мөн” гэж тодорхойлжээ.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Конвенци “Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авах”⁴- ыг үүрэг болгосон нь хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай шууд заасан онцгой ач холбогдолтой.

Мөн хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг бүхий газар, алба, байгууллагыг тухайн тодорхой салбарт аюулгүй байдал, хүүхдийн амьдрах, эсэн мэнд өсөж, хөгжих бололцоог хангах зорилгоор ажиллагсдын орон тоо, чадавхад хяналт тавих үүднээс эрх бүхий байгууллагаас жишигт нийцсэн нөхцөлөөр хангах шаардлагатай болохыг ч анхааруулжээ. Конвенцид оролцогч улсууд нь:

¹Иргэний болон улстөрийн эрхийн тухай олон улсын пакт. НҮБЕА. 1966. 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

²Хүний эрхийн түгээмэл Тунхаглал. НҮБЕА. 217/A/III тогтоол. 1946. 16 дугаар зүйл. 1 дэх хэсэг.

³Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай Конвенц. НҮБЕА. 1993

⁴Хүүхдийн эрхийн тухай Конвенци. 19 дүгээр зүйл. 1989.

- Хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх;
- Хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих;
- Хүүхдийг садар самуун үзүүлбэр болон зүй бус байдлыг сурталчилсан материалд ашиглах зэргээр хүүхдийг бэлгийн замаар мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүүхдийг үл хайхрах, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлагын ... хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэхэд тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэгтэй болохыг онцлон тэмдэглэсэн байна.

Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглалд “Хохирогч” гэдгийг “Гишүүн орнуудын хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийг зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас:

- Бие махбодын гэмтэл авсан;
- Сэтгэцийн гэмтэл, сэтгэл санааны дарамтад орсон;
- Санхүүгийн алдагдал хүлээсэн;
- Үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсэн, гарз хохирол учирсан бие хүн болон хамт олныг ойлгоно” хэмээн тодорхойлоод гэмт этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, баривчлагдсан, шүүх хэргийг хянан шийдвэрлэсэн эсэхээс болон **“хохирогчтой гэр бүл, хамаатан садангийн харилцаатай”** эсэхээс үл шалтгаалан хохирсон этгээд түүний гэр бүлийн гишүүд, халамжид нь байгаа хүмүүсийг хохирогч хэмээн үзэж “хохирогчоор тогтоох” тухай тусгасан байна. Гэмт хэргийн улмаас учирсан аливаа хохирол нь хохирогчоос гадна түүний гэр бүл, ойр дотны хүмүүст хамаарах тул зохих тохиолдолд “Хохирогч” гэдэгт хохирогчийн гэр бүл буюу түүгээр тэжээлгэж буй хүмүүсийг болон хохирогчид туслах, хохирол учруулах үйлдэлд саад хийх явцад хохирол амссан этгээдийг ч хамруулсан байна.

Хохирогчийн эрх хамгаалах ажиллагаа нь аливаа хүнийг алагчлалгүйгээр бүгдэд адил тэгш үйлчлэх, гэмт этгээдтэй гэрлэсэн буюу гэр бүлийн харьцаатай байдал нь хохирогчийн статусыг бууруулахгүй гэдгийг ч анхааруулсан байна. Дээрх тунхаглалын зургаагийн “d”-д хохирогчийг хамгаалах айлган сүрдүүлэх, өс хонзон авах зэргээс хамгаалагдах зарчмыг: “Хохирогчид учирч болох аюул заналхийллийг багасгах, амь насыг нь шаардлагатай аливаа тохиолдолд хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гэр бүлийн гишүүд, гэрчийн аюулгүй байдлыг хангах, айлган сүрдүүлэх, өшөө хонзон авалт зэргээс хамгаалах арга хэмжээ” хэмээн тайлбарлажээ. Харин хохирогчид үзүүлэх тусламжийн тухайд шаардлагатай материаллаг, эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн халамжийн туслалцаа үзүүлэх, эх үүсвэрийг төрийн, сайн дурын, орон нутгийн эх үүсвэрээс олгохыг зөвлөсөн байна.

Үндсэн зарчмуудад гэмт этгээд, түүний өмнөөс хариуцлага хүлээх гуравдагч тал нь хохирогч, түүний гэр бүл, түүгээр тэжээлгэж буй хүмүүсийн хохирлыг шударгаар барагдуулах тухай заагаад энэ нь нөхөн олговор (restitution), нөхөн төлбөр (compensation) гэсэн хоёр хэлбэртэй байхаар тусгажээ.

Нөхөн олговор. Эд хөрөнгийг эргүүлэн өгөх, учруулсан гэмтэл, хохирогч болсонтой холбогдон гарсан зардлын нөхөн төлбөр төлөх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх, эрхийг нь сэргээх зэргийг,

Нөхөн төлбөр. Нөхөн олговрын хөрөнгийг гэмт этгээд буюу бусад эх үүсвэрээс гаргах боломжгүй бол төр нь:

- Хүнд гэмт хэргийн улмаас бие махбодын хүнд гэмтэл авсан, бие буюу сэтгэцийн эрүүл мэнд нь алдагдсан;

- Хүнд гэмт хэргийн улмаас сэтгэцийн өвчтэй буюу тахир дутуу болсон эсхүл нас барсан хохирогчийн гэр бүл, түүний дотор тэжээгчээ алдсан хүмүүст мөнгөн нөхөн олговрыг олговол зохино гэжээ.

Олон оронд нөхөн олговрын эх үүсвэрийг төрөл бүрийн торгууль, шимтгэл, гэмт этгээдээс хураан авсан эд хөрөнгө, хувийн даатгалын шимтгэл зэргээс бүрдүүлдэг, төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй албан тушаалтан эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах, тухайн төлбөрийг хариуцах ёстой Засгийн газар өөрчлөгдсөн ч дараагийн Засгийн газрын тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирогчийн хохирлыг барагдуулах нь зүйтэй болохыг тусгасан байдаг.

Дээрх хэм хэмжээнүүд нь гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах, эрхийг нь хангах, хамгаалахад чиглэгдсэн төдийгүй олон орны Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрийн байр суурийг нэгэнт эзэлжээ.

НҮБ-аас улс орнууд үндэсний хууль тогтоомжоо сайжруулах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусгайлсан хууль боловсруулахад зориулан хүйсийн өвөрмөц байдлыг тусгасан, хүчирхийлэлтэй холбоотой бүх асуудлыг багтаасан зөвлөмж болгон гэр бүлийн гишүүд буюу ойр дотны харьцаатай хүмүүсийн эсрэг ... хүчирхийлэл үйлдсэн бол гэр бүл дэх хүчирхийлэл гэж үзэх, дээрх нэр заасан хүмүүсийг хүчирхийлэхийг хориглосон, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалсан, хүчирхийлэл дахин гарахгүй байхад чиглэгдсэн хууль тогтоомж боловсруулан гаргахыг уриалж 1993 онд **“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”** загвар хууль боловсруулан гаргасан юм. Гэр бүл дэх хүчирхийллийн шинжтэй үйлдлүүдийг “бие мах бод, сэтгэл зүйн болоод бэлгийн харьцааны шинжтэй хэл амаар доромжлох, айлган заналхийлэхээс эхлээд бие махбодод хүнд гэмтэл учруулах, хулгайлах, бэртээж гэмтээхээр заналхийлэх, айлган сүрдүүлэх, албадах, мөрдөн мөшгөх, хэл амаар доромжлох, орон байранд хүчээр буюу хууль бусаар нэвтрэн орох, өмч хөрөнгө устгах, бэлгийн хүчирхийлэл, хүчээр гэр бүл болох, инж сүй буюу төлөөстэй холбоотой хүчирхийлэл, бэлгэ эрхтэнг бэртээж гэмтээх, биеийг нь үнэлэхтэй холбоотой хүчирхийлэл, гэрийн үйлчлэгчийг хүчирхийлэх хүртэл хүчирхийллийн шинжтэй бүх үйлдэл, мөн тийм үйлдэл хийх оролдлогыг **“гэр бүл дэх хүчирхийлэл”** гэж үзэх ёстой” гэжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх гомдлыг хохирогч, түүний гэр бүлийн гишүүд, хүчирхийллийн гэрчүүд, хохирогчийн найз нөхөд, хохирогчид үйлчилсэн төрийн болон хувийн эмнэлгийн байгууллага, хоргодох байраар үйлчилсэн этгээдүүд, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд цагдаад мэдүүлж бүртгүүлэх, шүүхэд өргөдөл гаргах, мөн цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийг журамлан, шүүгчид хохирогчийн эрхийг хамгаалахыг үүрэг болгосон юм.

Загвар хуульд хохирогчийн мэдүүлэг нь хүчирхийлэгчид ял тулгахад хангалттай байх, хохирогчийн мэдүүлгээс өөр нотлох баримт байхгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож болохгүй талаар дурдаад талуудын хувийн амьдралыг хамгаалахын тулд хэргийг хаалттай хэлэлцэх, шүүхийн гаргасан хамгаалах шийдвэрийг зөрчсөн эсхүл үл биелүүлбэл “торгох”, “шүүхийг үл хүндэтгэсэн” гэж буруутгах, эрх чөлөөг нь хасах хүртэл арга хэмжээ авах эрхийг баталгаажуулжээ. Уг гэмт хэргийг давтан үйлдсэн, галт зэвсэг болон зэвсгийн чанартайгаар эд зүйл ашигласан зэрэгт ял шийтгэлийг хүндрүүлэх нь зүйтэй болохыг тусгасан байна.

Манай орны тухайд олон улсын гэрээ конвенци, НҮБ-аас гаргасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар зөвлөмжийн дагуу олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар гэр бүлийн хүчирхийлэл манай улсад бодитойгоор оршин байгааг бүх нийтэд дэлгэн харуулж бодлого, шийдвэр гаргадаг, хуулийг хэрэгжүүлдэг албан тушаалтнуудад хүчирхийллийг ойлгуулснаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулснаас хойш нилээдгүй хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд хуулийг хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, хохирогчдод туслах хамтарсан баг ажиллуулах, хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчид сэтгэл заслын сургалт зохион

байгуулах, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий албан хаагчдад тусгайлсан сургалт, судалгаа явуулах, хүүхдийн утасны тусгайлсан сүлжээ бий болгох зэргээр олон ажлыг эрчимтэй зохион байгуулж байна.

НҮБ-аас жишиг зөвлөмж болгосон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид туслалцаа үзүүлэх бие даасан алба, хамгаалалтын хэлбэрүүд нь ихэнх улс орнууд төдийгүй манай улсын холбогдох хуулиудад, тухайлбал, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тусгалаа олсон юм.

2.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүнд хийсэн дүн шинжилгээ

2020 оны 12 сарын байдлаар Монгол Улсад **765 хууль, 9502** эрх зүйн акт хүчин төгөлдөр үйлчилж байна.¹

Аливаа төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар эрх зүйн зохицуулалтыг тусгасан Монгол Улсын нэгдсэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ **26** байна.

Харин гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар зохицуулсан шууд холбогдолтой

- Монгол Улсын хууль – **10**
- Сайдын тушаал – **3** хүчин төгөлдөр үйлчилж байна.

Манай улс 1992 онд социалист маягийн Үндсэн хуулийг халж, ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталжээ. Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөө, шудрага ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлалгүй, нийтлэг ашиг сонирхлыг нь хамгаалж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгосон билээ.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт: “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж тогтоосон нь гэр бүлийн харилцааг хуулиар хамаалах, гэр бүлийн гишүүд аливаа хүчирхийллээс ангид байх эрх зүйн зохицуулалтын үндэс болж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2007 онд батлан хэрэгжүүлж байжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай 2004 оны хуульд хохирогчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан.

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн хүрээнд нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг, гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн гэсэн хэлбэрүүдтэй байхаар хуульчилжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, цагдаагийн байгууллага, төрийн бус байгууллага болон бусад этгээдийн эрх, үүрэг, хохирогчийг хамгаалах арга, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах журам, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг түр хамгаалах байранд байрлуулах, энэ ажиллагааны зарим үйлчилгээг төрийн бус байгууллага бие даан хэрэгжүүлж, түүнийг нь төрийн байгууллага санхүүжүүлсэнээр гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төрийн болон төрийн бус байгууллага хамтдаа тэмцэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар заажээ.

¹ legalinfo.mn сайтад байршуулсанаар. 2020

2007 онд Монгол Улсын Засгийн газраас “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр” –ийг баталсан.

Хөтөлбөрийн эрхэм зорилго нь гэр бүлийн гишүүд хүчирхийллээс ангид амар амгалан, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн харилцаанд хүчирхийллийн бус арга, хэлбэрийг нэвтрүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хангаж, гэр бүлийн хүчирхийлэл үүсэн гарч байгаа шалтгаан нөхцөл болон нийгмийн сөрөг үзэгдлийг арилгахад оршино¹ гэж тодорхойлжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь дараах 10 үндсэн зорилтын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

1. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох механизмыг бий болгон хөгжүүлнэ;
2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид болон тэдний гэр бүлд зориулсан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгон хөгжүүлнэ;
3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх нийгмийн ажлын үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлнэ;
4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн эрх ашигт нийцсэн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлнэ;
5. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлнэ;
6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлнэ;
7. Гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих нийгмийн ухамсрыг дээшлүүлнэ;
8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд салбар хоорондын зохицуулалтыг хангах үндэсний чадавхийг бэхжүүлнэ;
9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр салбарын болон орон нутгийн хооронд мэдээлэл байнга солилцох нөхцөлийг бүрдүүлнэ;
10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.

Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацааг 3 үе шаттайгаар зохион байгуулж шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төрөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг 2016 онд шинэчлэн баталж тухай бүр нь өөрчлөлт оруулан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож байна.

Энэ хуулиар гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилсан юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Холбогдох төрийн захиргааны байгууллага, Прокурорын байгууллага, Аймаг, нийслэл, сум, дүүргийн

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр ., Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолын хавсралт

иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Бүх шатны Засаг дарга, Хамтарсан баг, Төрийн бус байгууллагын чиг үүргийг тусгасан байна.

Мөн хуулийн 3 дугаар бүлэгт гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох харилцаанд цагдаагийн байгууллага, сум, багийн засаг дарга, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтны чиг үүргийг тодорхойлсон бол, 5 дугаар бүлэгт гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх үйлчилгээ, тэдний аюултай байдлын эрсдлийн үнэлгээ хийх эрх зүйн зохицуулалтыг тусгасажээ.

Монгол Улсын нэгдсэн орсон аливаа хүчирхийллийн эсрэг олон улсын гэрээ, конвенц

Монгол Улс аливаа хүчирхийллийн эсрэг 26 олон улсын гэрээ, конвенци, пактад нэгдэн орсон бөгөөд ингэснээрээ хүчирхийллийн аливаа хэлбэртэй тэмцэх, үндэсний хууль тогтоомжоо тэдгээрт нийцүүлэх амлалт, үүрэг авсан юм. Эдгээр олон улсын гэрээ конвенцоос дурьдвал:

- **Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц**-Улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон нийгмийн амьдралын бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг тэгш хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, үгүйсгэх зорилго бүхий арьс үндэс, арьсны өнгө, ураг төрөл, үндэсний буюу угсаатны гарал үүслийн үндсэн дээр ялгаварлах, онцлох, хязгаарлах буюу дээрд үзэхийг хязгаарлахыг үүрэг болгосон.
- **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт**-Улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй. Эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах, эрх зүйн хамгаалалтыг олгож түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах ёстой.
- **Хүний эрхийн түгээмэл тунхаглал**-Хүн үндсэн эрхтэй, хувь хүн нэр төр, үнэ цэнэтэй, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй, насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс үндэс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах, гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдлэнэ. Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.
- **Хүүхдийн эрхийн конвенц**-Хүүхдийг, түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон гэр бүлийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшлийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчилахгүй бөгөөд шийтгэхээс хамгаалах бүх зохистой арга хэмжээг авч, хүүхдийнмхалдашгүй дархан байх мэргийг хүндэтгэх, тэдний аз жаргалтай, амар амгалан нэр бүлд өсөж хүмүүжих эрхийг хангах, хамгаалах үүрэгтэй.
- **Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц**-Нийгмийн харилцаа болон гэр бүлд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй байж, гэрлэлт, гэр бүлийн харилцааны бүх асуудлаар эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах зохистой бүх арга хэмжээ авах, эмэгтэйчүүдийг хүчирхийллийн аливаа хэлбэрээс хамгаалаж, тэдний эрхийг хангах арга хэмжээг авахыг үүрэг болгосон.

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ДАХЬ ЗАРИМ ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ХИЙДЭЛ:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль:

- 20 дугаар зүйл. Хамтарсан баг: “эрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална”¹ хэмээн заасан. Дээрхи хүмүүс бол гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хамгийн анхны тусламжийг үзүүлэх чухал хүмүүс байдаг. Мөн хамтарсан баг нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх анхдагч нэгж учраас мэргэшсэн байх, тэднийг мэргэшүүлэхийн тулд үзүүлэх үйлчилгээ, хэрэгжүүлэх ажиллагааны талаар тусгасан хөтөлбөр, тодорхой давтамж бүхий сургалт байх шаардлагатай.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчих зөрчилд хөгжлийн бэрхшээлтэй, эрх зүйн чадамжгүй иргэд, хүүхэд хохирох нь цөөнгүй. Тиймээс ийм хохирогчид зориулан тусгайлсан тусламж, үйлчилгээ үзүүлэх хэм хэмжээ тусгасан зохицуулалтыг тусгах, мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх зэрэг асуудлыг орхигдуулсан байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлбэр, авах арга хэмжээний талаар тусгасан боловч тэрхүү ажиллагааг хянах, хариуцлага тооцох тогтолцоог мөн л орхигдуулсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль:

- Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу баривчлагдсан этгээдэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг орхигдуулсан.

Жендерийн тухай хууль:

- 6 дугаар зүйл. 6.2. Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн дарамт нь жендэрийн ялгаварлан гадуурхалтад хамаарна² гэж заасан боловч жендэрт суурилсан хүчирхийллийг хориглох, тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг тооцох, хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг орхигдуулсан.
- 26 дугаар зүйл. 26.3. Гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно³ гэсэн бол, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт: зөрчил гаргачийг заавал албадан сургалтад хамруулахаар заасан байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дээрхи хэм хэмжээ нь гэмт этгээдийг “Зан үйлийн албадан сургалт”-д хамруулахгүй байж болохоор хоёрдмол утгатай байгаа төдийгүй Зөрчлийн тухай хуульд заасан хэмжээтэй зөрчилдсөн хэм хэмжээ болжээ.

Зөрчлийн тухай хууль:

- Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн хариуцлага нь 200 нэгжтэй тэнцүү төгрөгөөр торгох буюу мөнгөний ханшаар /2020.12.11- ний өдрийн/ 200.000 төгрөгөөр торгон шийтгэж байна. Энэ нь эдийн засгийн боломжтой хүчирхийлэл үйлдэгчид нөлөөлөх эсэх,

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016он

² Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 он

³ Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 он

харин эдийн засгийн боломж муутай иргэнд дахин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх шалтгаан, хүчин зүйл болж байна.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн 4 хэлбэрийг заасан ч Зөрчлийн тухай хуульд эдгээр эдгээр хэлбэрээр илрэх үйлдлийг зөрчил гэж тооцоогүй байна.

Иргэний хууль:

- 9 дүгээр зүйлийн 9.4.5. Эдийн бус гэм хорыг арилгуулах гэж заажээ. Гэтэл Монгол Улсын Иргэний хуульд одоо хүртэл сэтгэл санааны хохирол болох эдийн бус гэм хорыг тооцох, арилгах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль:

- Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, түүнтэй холбоотойгоор үйлдэгдэж болзошгүй 6 төрлийн гэмт хэрэг, хүүхдийн эсрэг 11 төрлийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага оногдуулахаар хуульчилжээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үйлдэх гэмт хэрэгт оногдуулж буй эрүүгийн хариуцлагын хувьд 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 2 жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Энэ санкц нь гэр бүлээ байнгын айдаст автуулж, харгис, догшин авирлаж хүчирхийлдэг этгээдийн хувьд шийтгэл, хохирогчийн хувьд хамгаалалт болж чадахгүй байна.

Дүгнэлт

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчих зөрчлийн асуудал нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль зэрэг холбогдох 40 гаруй хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа боловч, хуулиудын уялдаа холбоо муу, хүлээлгэх хариуцлагын хэмжээ бага, хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

Эдгээр хууль эрх зүйн актуудын уялдаа холбоог сайжруулах, гэр бүл, түүний гишүүд тэр дундаа хүүхдийн эрхийг хамгаалах хуулиудын хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй үр нөлөөтэй болгох шаардлагатай. Учир нь цөөн тооны төрийн болон төрийн бус байгууллага өөрсдийн хязгаарлагдмал нөөцөөр төв суурин газруудад хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлж байгаа ч хүртээмж нь хангалтгүй, хөдөө орон нутагт хүүхэд хамгааллын асуудал орхигдсон хэвээр, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшсэн ажилтан ажилтан үгүйлэгдсээр байна.

Хэдийгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчилтэй тэмцэх хууль, эрхийн актууд олон ч энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралт улам бүр өссөөр байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, зогсоох чадвар бүхий эрх зүйн зохицуулалт дутагдалтай байгаагийн илрэл гэж үзэж байна.

Монгол хүүхдүүдийг багаас нь гэр бүл, түүний харилцааны нандин өв уламжлал, зөв хандлагыг төлөвшүүлэн хэвшүүлэх зорилго бүхий сургалтын хөтөлбөрийг боловсруулан сургуулийн өмнөх наснаас эхлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Санал

1. Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт: “гэр бүлийн харилцааны мэдлэгтэй, ёс зүйтэй, ухамсар бүхий иргэдийг төлөвшүүлэхийн тулд сургуулийн өмнөх наснаас эхлэн шат дараалсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ” гэсэн нэмэлт өөрчлөлт,

2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсэгт “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх мэргэшсэн албан хаагч байх” гэж нэмэлт өөрчлөлт,

3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт: “Хамтарсан баг нь өрхийн эмч, мэргэшсэн сэтгэл зүйч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны нийгмийн ажилтан ахална” гэсэн нэмэлт өөрчлөлт,

4. Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.4-т: “Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан, сэтгэл санааны гутралд оруулсан, сэтгэл санааны шаналал учруулсан, эдийн засгийн хувьд эрхшээлдээ байлгасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол **албадан сургалтад хамруулж, 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна**” гэсэн өөрчлөлт оруулах саналтай байна.

§ 2.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг талаарх олон нийтийн санаа бодолд хийсэн контент анализ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг нь цахим орчинд тавигдсан хүчирхийллийн талаарх мэдээ мэдээлэл, бичлэг, контент болон подкастаас харахад энэ төрлийн мэдээлэлд иргэдийн хандалт их байна.

2015 оноос эхлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлын талаар цахим орчинд мэдээ мэдээлэл, бичлэг, контент, нэвтрүүлэг, сурталчилгаа оруулж эхэлсэн байх бөгөөд 2015-2018 онд 55, 2019 онд 49, 2020 онд 31 мэдээ мэдээлэл, контент оруулсанаас 86 мэдээлэл, хууль хяналтын байгууллагатай хамтарсан, мэргэжлийн судлаачидтай хийсэн ярилцлага подкаст, хүчирхийлэл үйлдэгдсэн талаарх бичлэг, контент, кэйсийг түүврийн аргаар цуглуулж дүгнэлт хийлээ.

Хүснэгт 2.1. Ерөнхий мэдээлэл

Төрөл		2018	2019	2020	Нийт
1	Эрдэмтэн судлаачийн бүтээл	2		2	4
2	Сурвалжлага	2	3	3	8
3	Подкаст	20		14	34
4	Ердийн контент	10	4	4	18
5	Бичлэг	21	4	4	29
6	Кейс		2	4	6


Цахим орчинд дахь “**контент**” гэдэг нь нийгэмд хэрэгтэй, хамааралтай, үнэ цэнтэй, асуудлыг нь шийдсэн контентуудыг бүтээж, түгээх замаар анхаарлыг нь татаж, мэдээлэл дамжуулах хүргэх зорилготой маркетингийн арга технологи юм.

“**Подкаст**” гэдэг нь яг л радиогийн нэвтрүүлэг шиг өөрийн гэсэн хөтлөгчтэй, тусгайлсан сэдэвтэй бөгөөд аудио хэлбэрээр мэдээллийг хүргэж буй байдал юм.

“**Сурвалжлага**” нь сэтгүүл зүйн хамгийн шуурхай төрөл бөгөөд гол сэдэв нь үйл явдал юм. Өөрөөр хэлбэл, дэлгэцнээ өрнөж буй үйл явдал юм.

Бичлэг /**видео**/ гэдэг нь урлагийн болон технологийн үйл явц юм.

График 2.1. Контент анализийн судалгаа




2020 онд гэр бүлийн хүчирхийлэл ихсэж байгаа нь дэлхий даяар дэгдээд байгаа COVID -19 цар тахал өвчний улмаас хөл хорионд орсонтой холбоотойгоор нэмэгдсэн.

Цахим орчин дахь мэдээллээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл гэр орондоо буюу гэр бүлийн хүмүүсийн амьдарч байгаа газар ихэвчлэн үйлдэгддэг байна.

Судалгаанаас харахад гэр бүлийн хүчирхийлэл, түнтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил орон сууц хороололд 11 буюу 40.7%, гэр хороололд 15 буюу 55.6%, бусад газар газар 1 буюу 3.7% нь үйлдэгдсэн байх бөгөөд эдгээрийн дундаас гэр хороололд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх нь илүү өндөр байна.

График 2.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх орчин



Орон сууц хороололд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа нэг хүчин зүйл нь нэг талаас тухайн гэмт хэрэг үйлдэж байгаа хүнтэй холбоотой ч нөгөө талаасаа иргэдийн шилжилт хөдөлгөөн /хөршөө танихгүй, зарим тохиолдолд танилцах ч боломжгүй олон айл нүүж ирдэг, явдаг/, иргэд зөвхөн өөрийн амьдрал ахуйд санаа тавих, хувиа хичээх үзэлд хэт автаж байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна. Иймд уламжлалт найрсаг харилцаа, хөршийн холбоог өнөө цагт сэргээх нь чухал болжээ.


Жилээс жилд боловсролгүй иргэдийн тоо нэмэгдэж, дээр нь ажилгүйдэл, ядуурал ихэссэн зэргээс үүдэн гэр бүлийн хүчирхийлэл нь буурахгүй байна.

Хүснэгт 2.3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх цаг хугацаа

№	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн улирал, цаг хугацаа	Тоо
1	Өдөр	6
2	Шөнө	11
3	өвөл	7
4	зун	10
5	намар	10
6	хавар	9
7	ажлын өдөр	7
8	амралтын цаг	13

Цахим орчин дахь мэдээлэл, контент дээрээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд хэзээ хамгийн их үйлдэгддэг вэ? гэсэн асуулт гарч ирсэн. Дээрх судалгаанд түгээмэл дурьдагдаж байгаа цаг хугацаа нь гэртээ буюу амралтын өдрүүдэд хамгийн их үйлдэгддэг байна.

График 2.3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх цаг хугацаа



Судалгаанаас харахад амралтын цагт 17.8% буюу хөдөлмөр эрхлэх цагаас бусад цагт хүчирхийлэл хамгийн ихээр үйлдэгдсэн, өөрөөр хэлбэл, оройн 19 цагаас өглөөний 06 цагийн хооронд хамгийн их үйлдэгддэг гэсэн судлагаа гарсан.

Энэ төрлийн гэмт хэрэг хавар 12.3%, өвөл 9.6%, зун, намрын цагт адил түвшинд буюу судалгаанд хамрагдсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийн 13.7%-ийг эзэлж байгаа нь нийт иргэдийн амралтын улиралтай холбоотой байх магадлалтай ажээ. Харин ажын цагаар буюу 08-19 цагийн хооронд энэ төрлийн гэмт хэргийн 9.6% нь үйлдэгдэж байгааг бид ажилгүйдэлтэй холбоотой хэмээн үзэж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй этгээд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн талаар цахим орчинд байгаа мэдээллийг үндэслэн хүйс болон насны байдлаар нь харьцуулан үзэхэд хүчирхийлэгчдийн 17 буюу 68% нь эрэгтэй, 8 буюу 32% нь эмэгтэй, насны хувьд 16-35 насны 9, 36-45 насны 11, 46-65 насны 1, 65-аас дээш насныхан 4, харин хохирогчдын хувьд 23 буюу 72% нь эмэгтэй, 9 буюу 28% нь эрэгтэй, насны хувьд 0-15 насны 18, 16-35 насны 12, 36-45 насны 2 хохирогч байна.

Энэ нь гэр бүлийн хүчирхийллийг ихэвчлэн идэр насны буюу 36-45 насны эрэгтэйчүүд үйлддэг бол, хохирогчдын хувьд 16-35 насны эмэгтэйчүүд, хүүхэд илүүтэй өртөгдөг ажээ. Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдээс хохирогчдын тоо байнгын илүү буюу олон байдаг нь эмэгтэй хохирогчдын хамт хүүхэд хохирч байдагтай холбоотой.

Манай улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийг аль ч насныхан тэр дундаа ач зээгээ тойруулан жаргаж суух насандаа байгаа иргэд ч үйлдэж байгаа нь анхаарал татсан асуудлын нэг мөн бөгөөд монгол хүний ёс суртахуун доройтсоны илрэл юм

График 2.4.




График 2.5.



Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн нас: гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт насан хүрээгүй 18 хүүхэд хохирсон нь нийт хохирогчдын 56% –ийг эзэлж байгаа бөгөөд эдгээр насныхан өөрийгөө хамгаалах чадвар суугаагүй, үйл явдлын мөн чанар, учрыг ойлгохгүй зэрэг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөх хүчин зүйл нь болж байна.

Цахим мэдээллээс үзэхэд ихэвчлэн 16-35 насныхан /12 буюу 38%/ гэр бүлийн хүчирхийллийн золиос болж байгаа ба харин 36-45 насныхан хохирсон нь хамгийн бага үзүүлттэй буюу 6% байгаа ч хүчирхийлэлд мөн л өртөж байна.

Цагдаагийн байгууллагаас жил бүр эрхлэн гаргадаг гэмт хэргийн статистик мэдээлэлтэй харьцуулахад цахим орчинд хүүхэд, хүчирхийллийн хохирогч болсон мэдээ, мэдээлэл их байгаа нь иргэд энэ үйл явдалд ихээхэн эмзэглэн эгдүүцдэгээс хандалт өндөр байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн 3 нь хувийн хэвшилд ажилладаг, ажилгүй 4, 25 хүний хөдөлмөр эрхлэлт тодорхойгүй байгаа бол, хохирогчдын 5 нь ажилгүй, оюутан 1, сурагч 1, хөдөлмөр эрхэлдэг эсэх нь тодорхой 32 хүн байна.

График 2.6.




График 2.7.



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй этгээдийн нийгэмд эзлэх байр суурь: Цахим орчинд гэмт хэрэг үйлдэгчийн нийгэмд эзлэх байр суурийн талаар дурдаагүй ч олсон тоо баримтан дээр тулгуурлан авч үзвэл, хувийн хэвшилд 3 буюу 12% нь хөдөлмөр эрхэлдэг ба гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхдээ бүгд согтуу байсанаас үзэхэд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байгаа гол шалтгаан нь “архидалт” байна гэж дүгнэж болохоор байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн ажилгүй 4 (16%) хүн нь үүрэг хариуцлагаа ухамсарладаггүй, бэлэнчлэх сэтгэлгээтэй, ажил хийх чадваргүй, архи болон сэтгэцэд нөлөөлөх эм бодис хэрэглэдэг зэрэг нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын нийгэмд эзлэх байр суурь:

Цахим орчинд дурьдагсанаар хүчирхийллийн хохирогчдын 5 буюу 16% нь ажилгүй гэрт байдаг, хүүхдээ хардаг гэх шалтгаантай бол оюутан сурагчдын /2 буюу 6%/ хувьд гэртээ арай илүү цагаар байдаг болон хэн нэгний хараат байдал нь хохирогч болоход нөлөөлсөн байна.

Энэ бүхнээс үзэхэд өөрийгөө хамгаалах чадваргүй, хэн нэгнээс хараат, бие бялдар, оюун санааны хувьд төлөвшөөгүй сул дорой иргэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болдог нь харагдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй болон өртөгдөж буй иргэдийг цахим сүлжээн дэх материал дээрээ тулгуурлан боловсролын түвшинг харуулбал: хүчирхийлэл үйлдэгчийн хувьд: дээд боловсролтой 1, дунд 1, бага боловсролтой 2, боловсролын талаар дурдагдаагүй 21 байгаа бол, хохирогчдын хувьд дээд боловсролтой 1, дунд боловсролтой 3, бага боловсролтой 1, боловсролын талаар дурьдагдаагүй 27 байгаагаас үзэхэд боловсролын хувьд хохирогч, хүчирхийлэгч адил түвшинд байгаа нь харагдана.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчдын боловсролын түвшин:

График 2.8.






График 2.9.



Цахим мэдээлэлд дурдагдсанаар гэр бүлийн хүчирхийллийн бусад гэмт хэргээс ялгагдах онцлог нь хүчирхийллийг гэр бүлийн гишүүд болох хамгийн ойр дотны хүмүүс үйлддэг төдийгүй өртдөг нь илэрхий байна. Тухайлбал, социал мэдээлэлд дурдсанаар гэр бүлийн хүчирхийллийг аав /хойт эцэг/ 13, ээж /хойт эх/ 4, нөхөр 4, эхнэр 1, хамтран амьдрагч 2, гэрлэлтээ цуцлуусан нөхөр 1, үр хүүхэд 1, эцэг эхийн найз 1, хамаатны ах, эгч 4 үйлдсэн байхад, хохирогч нь эхнэр 5, нөхөр болон хамтран амьдрагч тус тус бүр 1, төрсөн болон дагавар хүүхэд 14, дүү болон бэр тус тус 1 хүн хохирчээ.


Сошиалд тавигдсанаар гэр бүлийн хүчирхийллийг хамгийн ихээр үйлддэг хүн нь ерхийн тэргүүн болох төрсөн болон хойт эцгүүд нийт гэмт хэргийн 42 хувийг үйлдсэн байгаа бол, харин хүчирхийлэлд хамгийн их өртөг хүн нь нийт хохирогчдын 45.1%-ийг эзэлж байгаа төрсөн болон дагавар хүүхэд байна.

График 2.10.



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн хувийн байдлыг судлан үзэхэд архи болон мансуурах бодисийн хамааралтай 8, хаяа хэрэглэдэг гэх 1, хамааралгүй 1 хүн, хүчирхийлэлд өртөгсдийн хувьд дээрх зүйлүүдэд хамааралтай гэж хүн байхгүй байна.

График 2.11.



Дүгнэн үзвэл хүчирхийлэгчдийн 80% нь архи, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ гэмт хэргийг үйлдэж байгаа ба хохирогчид зүй бус ааш авир гаргасан, зодсон, бие махбодид гэмтэл учруулсан, хүчин үйлдсэн байх бөгөөд гол бурууг архитай холбож тайлбарлах нь бодитой бөгөөд цаашид архи болон мансуурах бодисийн хамааралтай хүний тоо өсөн нэмэгдэх магадлал өндөр байна.

График 2.12.





График 2.13



Контентод дурьдагдсанаар хүчирхийлэл үйлдэж түүнд өртөж буй хэлбэр нь давхардасан тоогоор гарч байсан бөгөөд хохирогчдын хувьд хүчирхийлэгчийн зүгээс үзүүлж буй хүчирхийлэл сэтгэл санаа, бие махбод, эдийн засгийн дарамт учруулах нь дангаараа биш хавсарч үйлдэгддэг гэдгийг давхар нотолж байна. Тухайлбал, бие махбодийн хүчирхийлэлд 19, сэтгэл санааны хүчирхийлэлд 21, бэлгийн хүчирхийлэлд 1 өртсөн төдийгүй 1 хохирогч амь насаа алджээ.

График 2.14.




График 2.15



Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргүүдээс сэтгэл санааны хүчирхийлэлд хохирогч хамгийн их /42%-/ өртөж байгаа бөгөөд сэтгэл санааны хүчирхийлэлд үгээр гутаан доромжилох, дарамтлах, заналхийлэх, айлгах зэрэг үйлдлүүд хамаарч байна. Биеийн хүчирхийлэл /38%/ үйлдэж буй хэлбэр нь гараар цохих, хөлөөр өшиглөж дэвсэх, үсдэх, чирэх зэргээр биеэр үйлдэх хэлбэр нь давамгайлж байна.

Эдийн засгийн хүчирхийлэл нь эдийн засгийн хувьд чадамжгүй байлгах /мөнгө төгрөг өгөхгүй байх, өгсөн ч түүнээ байнга тооцож хянадаг байх, хариултыг нэхэх, эд зүйл авсан баримт нэхэх/, эдийн засгийн эрх чөлөөг нь боогдуулах /цалинг нь хурааж авах,

авсан, үрсэн зүйлсийн талаар асууж шалгаах, байнга тайлбар нэхэх г.м./ хэлбэрээр үйлдэгдэж байна.

Хүчирхийллийн хэлбэр болох бие махбодь, сэтгэл санааны хүчирхийлэл нь тус бүр 22 (42.3%) буюу ижил тоогоор үйлдэгдсэн байгаа нь энэ төрлийн хүчирхийлэл нь давхар үйлдэгдэж байгаагийн илрэл бөгөөд бусад хүчирхийллээс 0,3-иар илүү байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл далд хэлбэрээр явагддагийг илрэл юм. Харин эдийн засгийн хүчирхийлэл нь бага байгаа мэт харагдаж байвч бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэл илүү их зовлон шаналал учруулдагтай холбоотойгоор энэ тухай дурьддаггүй байна.

Хүүхдүүдийн хувьд тэр дундаа дагавар хүүхдүүдийн хувьд хүчирхийллийн гэмт хэргийн гол байх болсон байх бөгөөд ялангуяа дагавар охид хойт эцэг, хамаатны ах дүүсийн хувьд бэлгийн ташаал авах эсвэл гаж хүслээ биелүүлэх хэрэгсэл болж байгаа бол, хөвгүүдийн хувьд насны байдлаас хамааралгүйгээр хойт эцэг, хамаатны ах дүүсийн нүдэнд орсон хог, шүдэнд хавчуулагдсан мах мэт үзэгдэж эрүүлдээ ч согтуудаа ч ад үзэн гадуурхах, зодож цохих нь элбэг байна. Ээжүүд ихэвчлэн тэднийг хүчирхийлүүлдэд өртөж байгааг мэдсэн ч байх л ёстой зүйл мэт хандаж байгаа нь хамгийн эмгэнэлтэй.

Ийнхүү гэр бүлийн хүчирхийлэл нь аль ч хэлбэрээр үйлдэгдсэн дангаар үйлдэгддэггүй, өөрөөр хэлбэл гэмт этгээд нэг үйлдлээр нэг дор хэд хэдэн гэмт хэрэг үйлддэг бол, хохирогч мөн л нэг дор хэдэн төрлийн хохирол хүлээдэг онцлогтой байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэл дамжирсаар гэр бүлийн хүний амь нас хохирох болсон энэ төрлийн гэмт хэрэг хүнд хэлбэр лүү шилжиж байгаагийн илрэл юм.

5. Хүчирхийллийн төрөл


Цахим мэдээлэл контент, сурвалжлага, кейсээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн төрлөөр ангилан үзвэл:

Хүснэгт 2.10.

Хүснэгт 2.11

Хүчирхийллийн төрөл			Хүчирхийлэлд өртсөн хэлбэр		
1	Зодох, тарчлаах	14	1	Зодох, тарчлаах	10
2	Гутаах, доромжлох, дарамтлах	21	2	Гутаах, доромжлох	19
3	Бие махбодид гэмтэл учруулах	15	3	бие махбодид гэмтэл учруулах	15
4	Дарамтлах, заналхийлэх	4	4	гэрээс үл гаргах, хорих	6
5	Гэрээс үл гаргах, хорих	8	5	өлсөж цангаах	2
6	Өлсөж цангаах	2	6	архи, мөнгө олж ирэхийг шаардах	2
7	Архи, мөнгө олж ирэхийг шаардах	2	7	цаг хугацаагүй хөдөлмөрлүүлэх	1
8	Цаг хугацаагүй хөдөлмөрлүүлэх	1	8	Амь насанд нь халдах	2
9	Алах	2			

График 2.16. Хүчирхийлэл үйлдэж буй хэлбэр



Дээрхи хүснэгтэд байгаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй хэлбэрүүдээс харахад: хүчирхийлэл үйлдэж буй этгээд хохирогчийг гутаах, доромжлох, дарамтлах нь хэлбэр нилээд өндөр үзүүлэлт байгаа бөгөөд энэ үйлдэл нь хохирогчийн сэтгэл санааны байдалд шууд хүндээр тусдаг байна.

Дарамтлах, заналхийлэх 4(5%), айлган сүрдүүлэх, байнга загнах, өлсөж цангаах, архи, мөнгө төгрөг олж ирэхийг шаардах, цаг хугацаагүй хөдөлмөрлүүлэх нь ч бас хүчирхийлэл бөгөөд ийм үйлдлийн талаар ч мэдээлэл дээр нилээдгүй гарчээ.

Харин бие махбодийн хүчирхийллийн улмаас хохирогч хүнд, хүндэвтэр, хөнгөн хэлбэрээр гэмтэл авах нь элбэг байна.

Гэрээс үл гаргах буюу хууль бусаар хорих 8(9%) хүчирхийлэл нь ихэвчлэн хүчирхийлэл үйлдсэнээ нуух, бусдад мэдэгдүүлэхгүй байх, өөрийн эрхшээлдээ байлгах буюу хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж байгаагийн нэг хэлбэр юм. Энэ хүчирхийлэл нь түгээмэл биш ч амьдрал дээр нуугдмал байдлаар байгаа нь дээрхи тоо баримтаас харагдаж байна. Хохирогчдын хувьд нэр төрөө бодох, бусдаас ичиж зовсондоо энэ байдлаа аль болохоор мэдэгдэхгүйг хичээдгээс энэ төрлийн гэр бүлийн хүчирхийлэл далд хэлбэрээр байсаар байна.

График 2.17. сошиалд тавигдсан хүчирхийллийн хэлбэрүүд




Дээр дурдсан хүчирхийллийн хэлбэрүүд нь давхардсан тоогоор 75 удаагийн үйлдэл бөгөөд хохирогч нь хүчирхийллийн талаар хэлэхээс айж нуусан, хэнд хандахаа мэдэхгүй

байх, хэлж болохгүй гэж айлгаж сүрдүүлсэн, нийгмийн зүгээс өөрийн буруутгах байх гэдгээс айсан, нэр хүндээ хамгаалах зорилгоор нуусан, өөрийгөө буруутгаж арга мухардсан, туслах хүн олдохгүй сэтгэл гутрал, айдас, стресст орсон зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч илүү их хохирсоор байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг цахим орчинд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- эрх зүйн орчин 40%,
- нийгэм, эдийн засгийн байдал 28%,
- боловсрол, хүмүүжлийн төлөвшил 22%,
- улс төр 10%

График 2.18. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж буй хүчин зүйл




Иргэдийн хувьд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг нэрлэхдээ хамгийн өндөр буюу 40%-ийг эрх зүйн орчин гэж нэрлэсэн нь эрх зүйт төртэй нийгэмд амьдарч байгаа гэдэг утгаараа зөв ч, нөгөө талаасаа өөрсдийн оролцооны талаар огт дурьдаагүй байгаа нь орчин цагийн хүний мөс чанар, тухайн асуудал нь “бусдын асуудал” гэж үзэж байгаатай холбоотой байна. Энэ буруу хандлага л хүчирхийлэлтэй тэмцэхэд сөргөөр нөлөөлсөөр байгаа билээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа шалтгааны тухайд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх болон урьдчилан сэргийлэх ажил дутмаг 14
- Боловсролын тогтолцооны гажуудал 10
- Согтуурал, мансуурал 10,
- Ажилгүйдэл 8 ,
- Ёс суртахууны доройтол 7,
- Улс төрийн тогтворгүй байдал 6,
- Ядууралтай холбоотой гэж 3 хүн үзсэн байна.


График 2.19. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж буй шалтгаан нөхцөл



Энэ нь үнэхээр л бидний амьдарч буй нийгэмд оршин буй сөрөг зүйлүүд мөнөөс мөн бөгөөд нийгмийн хувьсал өөрчлөлт нь хувь хүн, гэр бүлийн харилцаанд шууд нөлөөлдөг болохыг харуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлж буй хувь хүнээс шалтгаалах субъектив шалтгаан нөхцлийг ажилгүйдэл, архи, сэтгэцэд нөлөөлөх эм бодисын хамаарал сэтгэцийн өвчин гэж үзжээ.

График 2.20.



Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээлэлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт 2020 оны эхний 3 сард 259 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 36.3 (69) хувиар өссөн байна. Эдгээр шалгагдсан иргэдийн 61.8 (160) хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 48.4 хувь ажилгүй гэсэн мэдээлэлтэй цахим орчинд тавигдсан энэ төрлийн гэмт хэргийн таларх мэдээллийг харьцуулан үзэхэд бидний хийсэн судалгаатай агуулга нь нийцэж байна.

Цахим сүлжээн дэх кэйс:

Кэйс 1:

Хаалгаа цоожлон гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эрэгтэйг саатууллаа

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны 75/6 дугаар байранд иргэн Н /29 настай, эрэгтэй/ нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ гэр бүлдээ хүчирхийлэл үйлдэж байсныг цагдаагийн алба хаагчид илрүүлжээ. Улмаар тус байрны хаалгыг онгойлгох тухай хүсэлтийг 2020.11.06-ны өдрийн 00:31 цагт хүлээн Онцгой байдлын албанд ирүүлснээр Нийслэлийн Аврах анги-105-ын алба хаагчид 11 км зам туулан 00:50 цагт очиж хаалгыг онгойлгон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.

Эх сурвалж: Цахиур.МН сэтгүүлч З. Гантулга 2020 оны 11сарын 14¹

Кэйс 2:

Хаалттай сэдэв: Хүчирхийллийн хууль чангарсан ч эерэг өөрчлөлт гарахгүй байна

Нөхөртэйгээ 10 жил ханилсан бүсгүй одоо гурван хүүхэдтэй. Түүний нөхөр сүүлийн жилүүдэд архи ихээр ууж, дарамталж, зоддог болжээ. Төрсөн аавтай нь хүртэл хардаж, гэрээс нь гаргадаггүй, хэнтэй ч уулзуулдаггүй байна.

Тухайн хохирогч нь ажил хийдэггүй гэртээ хүүхэдээ хардаг. Нөхөр нь түүнийг харддаг байсан ба гэрээс нь ч гаргадгүй байжээ. Эмэгтэй нөхрөөсөө салсан. Уг эмэгтэй 3 хүүхэдтэй бөгөөд одоо 2 хүүхдийн хамт түр хамгаалах байранд байгаа ба 1 хүүхэд нь сувилалд байгаа юм.

News.mn 2019 оны 1сарын 28²

Кэйс 3:

Аав нь есөн настай охиныхоо өмд рүү гараа хийж өөрийн төрсөн охиндоо бэлгийн зүй бус үйлдлийг хоёр жил тасралтгүй хийж, айлган сүрдүүлж байжээ. Үүнийг ээж нь мэдээд цагдаад хандсанаар охиныг түр хамгаалах байранд байрлуулжээ

News.mn 2019 оны 1сарын 28³

Кэйс 4:

Төрсөн аав нь 15 настай охиноо хүчиндсэн хэрэг гарчээ

Бага насны хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар нийгмийг цочроосон жигшүүрт хэргийн мэдээлэл ар араасаа гарсаар байна. Эл төрлийн гэмт хэргийн хохирогч нь насанд хүрээгүй охид болж байна. Охид ихэвчлэн гэр бүлийн хамаарал бүхий этгээддээ хүчирхийлүүлдэг тоо баримт бий. Бэлгийн хүчирхийллийн 80 орчим хувь нь охидын итгэлийг олсон хамаатан садан болон эцэг нь үйлдсэн байдаг аж. Саяхан аав нь төрсөн охиноо хүчирхийлсэн жигшүүрт хэрэг бүртгэгджээ. Тус хэргийн талаар тодруулбал, 8 сарын 26-ны өдөр Хан-Уул дүүрэгт 34 настай Б нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ 15 настай төрсөн охиноо хүчиндсэн хэрэг бүртгэгдэж, цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлт нээж, шалгаж байгаа аж.

Энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн этгээдийг Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлд зааснаар 12-20 жил, эсвэл бүх насаар нь хорих ялаар шийтгэх хамгийн хүнд ялыг оноодог байна.

¹ <https://tsahiur.mn/n/s/418>

² <https://news.mn/r/2081181/>

³ <https://news.mn/r/2081181/>

Маш олон хүүхэд гэр бүлийн хүчирхийлэл тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртдөг. Хамгийн аймшигтай нь аав, ах, өвөө, хамаатан гээд ойр дотны хүмүүс үйлддэг нь аймшигтай. Энэ мэтчилэн согтуудаа эсвэл гаж хүслээсээ болсон олон нууц хэрэг их байдаг.

Itoim.mn 2020оны 8сарын 28¹

Кэйс 5:

Хохирогч Б нь 4настай хойд эцэг болох М-д орондоо шээсний улмаас удаа дараа зодуулан амь насаа алджээ. Хойд эцгийн гар харсан 4хөн настай хүү орондоо шээснээс болоод удаа дараа зодуулж явсаар харамсалтайгаар нас баржээ. Энэ мэтчилэн маш олон хүүхэд хаалттай хаалганы цаана хүчирхийлэлд өртөж шаналж байгаа юм.

Монгол ТВ 2019 оны 5 сарын 28²

Кэйс 6:

Хохирогч А нь 6 настай нагац ах болох Б-д англиар асуусан асуултанд хариулж чадаагүйн улмаас гарынхаа хуруунуудыг эрэмдэглүүлсэн аймшигтай хэрэг гарчээ.

6-хан настай охиныг асуусан зүйлд нь хариулж чадаагүйн улмаас нагац ах нь охины гарынх нь хурууг эрэмдгэлжээ. Ойр дотны хүмүүсийнх нь хүчирхийлэл хүүхдэд маш хүндээр тусдаг юм

Монгол ТВ 2019 оны 5 сарын 28³

Цахим сүлжээнд байгаа кейс нь бодитоор үйлдэгдэж хууль хяналтын байгууллагын тусламжтай ил болж гарсан мэдээлэл, гэвч хэн ч мэдээгүй мэдэх боломжгүй гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж түүнд хохирч байгаа хэргүүд олон байх боломж харагдаж байна..

Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэнхдээ нууц, далд үйлдэгддэг мөн бусдад хэлэх, цагдаад мэдэгдвэл амь насыг нь хорооно хэмээн айлган сүрдүүлдэг нь байнгын үзэгдэл. Тиймээс зарим иргэд хууль хяналтын байгууллагын танил, найз нөхөд, багш өөр бусад иргэдээр дамжуулан зөвлөгөө, заавар, арга хайж хандах нь цөөнгүй байна.

Хохирогчид хууль, эрх зүйн мэдлэг дутмаг, хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд гарчих вий гэсэн айдастай, өөрийгөө хамгаалж чадахгүй, мөн өөр очих газаргүй нь улмаас байнгын гэр бүлийн хүчирхийлэлд өртсөөр л байна.

Хохирогч хуулийн байгууллагад хүчирхийлэл үйлдсэн талаар мэдэгдсэн ч хүчирхийлэгч, түүний хамаатан садны хэл ам, заналхийлэл, өсөрхөлөөс айхдаа эсвэл засарч хүмүүжинэ гэж итгэж найдсандаа гомдолгүй, эвлэрсэн гэж мэдүүлэх нь олон бөгөөд хүчирхийлэгч хэргээс мултарсаны дараа өсөрхөн улам харгис хэрцгийгээр хүчирхийлж улмаар амь насанд хүрсэн байх нь социал мэдээлэлээс харагдана.

¹ <http://itoim.mn/article/lvMbO/23302>

² <https://www.youtube.com/watch?v=bOTalXoO5mU&fbclid=IwAR1Exy0QDprO0nCl1zvCbchbMLtWSINxBtVuxsuV4384mijoXx2iVxnyUD8>

³ <https://www.youtube.com/watch?v=bOTalXoO5mU&fbclid=IwAR1Exy0QDprO0nCl1zvCbchbMLtWSINxBtVuxsuV4384mijoXx2iVxnyUD8>

Цахим орчин дахь гэр бүлийн хүчирхийллийн талаар тавигдсан мэдээллийн талаарх сэтгэгдэл

Цахим сүлжээнд мэдээ мэдээлэл нь иргэд олон нийтэд илт нөлөөлж байна. Чухамдаа цахим орчиноос л иргэд эрх зүйн боловсрол олж, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй гэдгээ ойлгон гарах арга замыг хайж, асууж зөвлөгөө хүсэж байхад нөгөө хэсэг нь энэ тал дээр өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, зөвлөгөө өгөх зэргээр хариу сэтгэгдэл бичиж байгаа нь цахим орчин дахь мэдээлэл богино хугацаанд хүртээмжтэй тархаж байгааг харж болохоор байна. Цахимд бичсэн иргэдийн сэтгэгдэл мэдээлэлийн тоо баримтыг хүснэгтээр харвал:

Хүснэгт 2.15.

№	Иргэдийн сэтгэгдэлийн төрөл	тоо
1	Сурвалжлага, нийтлэл	158
2	Ердийн контент	221
3	бичлэг	716
4	Ярилцлага, подкаст	15

Иргэдэд гэр бүлийн хүчирхийллийн талаархи сэтгэгдэлүүд нь бүгд эерэг байсан бөгөөд гарах арга замын талаар зөвлөгөө өгсөн, хаана, хэнд, хандах талаар бичсэн сэтгэгдэл, хэнд хаана хандах талаар ойлгож талархсан сэтгэгдэл их байлаа.

График 2.21. Иргэдийн сэтгэгдлийн тоо



Эндээс үзэхэд хамгийн их хандалттай байгаа нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой албаны болон албан бус шинжтэй бичлэгүүд хамгийн их хандалттай байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэлд хандалт их байгаа нь нэг талаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогч тандалт хийж, өөрт хэрэгтэй мэдээллээ олж авах гэсэн байж болох талтай бөгөөд нөгөө талаасаа энэ төрлийн гэмт хэрэг нь нуугдмал шинжтэй байсаар байна.

Цахим сүлжээ хөгжижийн хирээр хүмүүс түүнийг өргөн хэрэглэдэг болсон үүнийг дагаж цахим орчинд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх контент, мэдээ сурвалжлага, нэвтрүүлэг хийгдэх болсон бөгөөд энэ нь иргэдэд маш сайн хүрч байгаа нь судалгаанаас анзаарагдаж байна.

Мөн хүчирхийллийг хэрхэн бууруулах вэ, хүчирхийллийн шалтгаан нөхцөл түүнээс сэргийлэх, гэмт хэргийг бууруулах зэргээр холбогдох мэргэжилтнүүд, салбар бүрийн хүмүүстэй ярилцлага өрнүүлж, санал дэвшүүлэх подкаст хэмээх шинэ төрөл орж ирж байгаа нь цахим сүлжээнд томоохон байр суурийг эзэлж байна.

Манай улс гэр бүлийн хүчирхийллийн талаар нилээдгүй арга хэмжээ авч ажиллаж гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг буурсан гэсэн үзүүлэлтэй байгаа

ч энэ төрлийн гэмт хэрэг нь шийдвэрлэхэд зөрчлийн эрх зүй, мөн эцэг эх байх эрх хасах зэрэг аргаар шийдвэрлэж байгаа нь улам хэргийг даамжруулах мэт харагдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь нуугдмал хэлбэрээр, удаа дараа улам хүндрэн давтагдаж байна мөн одоогийн нөхцөл байдал дээр цар тахал дэгдсэн эцэг үед хохирол улам нэмэгдэж, нийгмийн болон сэтгэл зүйд хүндээр тусаж гэртээ байх нь стресс бухимдал болж энэ нь эргээд хүчирхийлэл илүү үйлдэх гол нөхцөл болон илэрч байна.

Хүчирхийлэл үйлдсэн хүн тусламж хүсэж холбогдох байгууллагуудтай ярих зөвлөгөө авах энэ талын байгууллагын утас цахим хаягыг нийтэд ил болгох мөн олон мэдээллийн сайтуудад байрлуулах нь чухал юм.

Хохирогчийн амь нас эрүүл мэндээс илүү гэр бүлийн бүрэн бүтэн байдлыг илүүд тооцдог учир хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй эвлэрэх шаардлага тавьдаг байна. Энэ нэг талаараа сайн нөгөө талаараа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхэд дахин давтагдах арга барил болж байна.

Уг судалгааны ажлыг зарим статистиктэй харьцуулан үзэхэд Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэгт 2020 оны эхний 3 сард 259 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 36.3 (69) хувиар өссөн байна. Эдгээр шалгагдсан иргэдийн 61.8 (160) хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 48.4 хувь ажилгүй, 51.6 хувь нь ажил эрхэлдэг байна. Мөн шалгагдсан иргэдийн 95.8 хувь боловсролтой, үүнээс 46.7 хувь нь бүрэн дунд, 20.8 хувь нь дээд, 17.0 хувь нь суурь боловсролтой байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой контент асуулгын хүрээнд 86 контент, ярилцлага, зохиомжийг судлан үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл нь орон сууцны хороололд, гэр хороололд их үйлдэгдэж байна. Үүнээс үзэхэд цоожтой хаалганы цаана гэр бүлийн хүчирхийлэл хамгийн их үйлдэгдэж байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нь ихэнх нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байгаа бөгөөд тэднийг биеэ хамгаалж чадахгүй байдлаасаа улбаалан гэртээ хүчирхийлэлд автсаар байна.

Контентын судалгаанаас гадна 2018, 2019 оны гэмт хэргийн статистикийн судалгаанаас харьцуулан үзэхэд 2018 онд Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 210 бүртгэгдсэнээс 195 буюу 92.9 хувь нь, 2019 онд 207 бүртгэгдсэнээс 182 буюу 89.9 хувь нь гэр хороолол, орон сууцанд үйлдэгдсэн байна. Мөн 2020 онд Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 гэмт хэргийн²

- 91.0% (254) нь хөнгөн, 9% (25) нь хүнд ангилалтай,
- 48.1% нь Улаанбаатар, 51.9% нь орон нутагт,
- 41.9% (117) нь согтуугаар,
- 8.2% (23) нь эмэгтэй хүнээр,
- 86.4% (241) нь гэр орон сууцанд үйлдэгжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл нь улс эх орны нийгэм эдийн засгийн байдал, соёл, боловсрол, эрх зүйн орчинтой шууд холбоо хамааралтай байна.

Контент судалгаанаас дүгнэхэд Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх хүчин зүйлсэд эрх зүйн орчин дутмаг байгаа нь судалгааны явцад харагдаж байна. Монгол Улсад Хүүхэд, гэр бүлийг хамгаалсан маш олон хууль байдаг хэдий ч тэдний хэрэгжилт муу байна. Учир нь гэр бүлийн хүчирхийллийг байдаг л зүйл мэтээр нийгэм хүлээж авдаг болсон байна.

Цагдаагийн байгууллагын оролцоо муу байгаа гэж харж байгаа бөгөөд яагаад гэвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг цагдаад хандан дуудлага өгсөн ч маргааш нь гомдолгүй гэж салгаж авдаг жишиг аль хэдийнээ тогтсон байна.

Энэ нь эргээд хуулийн биелэлтэд муугаар нөлөөлөх цаашлаад хохирогч нь гэмт хэрэгтнийг өмгөөлж хамгаалсаар эцэст нь амиа алдах эрсдэлд хүрч байна. Энэ нь хохирогч нь хууль, эрх зүйн мэдлэггүйн улмаас, мөн хохирогчийг хамгаалах хууль эрх зүйн орчин дутмагаас, тэднийг хамгаалах байр гэх зэргээс үүдэн энэ хэрэг нь даамжирсаар, хамгаалагдсаар, хүчирхийлэл давтагдсаар байгаа юм.

Контентийн судалгаа болон гэмт хэргийн статистикийн судалгааг харьцуулан үзэхэд 2018, 2019, 2020 онуудад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг нь өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь нийтийг хамарсан цар тахал дэгдсэн үед олон нийтийн дунд бухимдал бий болж стресс нэмэгдсэний улмаас гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг өсөж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч нь охид, эмэгтэйчүүд мөн хүүхдүүд байна. Эмэгтэй хүн байгалиас заяагдсан үүргийнхээ дагуу үр хүүхэд төрүүлэх, түүнийгээ өсгөн хүмүүжүүлэх мөн жам ёсны хэмээн бараг хуульчилсан эмэгтэй хүн гэр орноо цэвэр цэмцгэр байлгах, ар гэрээ сайн авч явах гэсэн буруу тогтсон зан үйлээс болж боловсрол эзэмшиж чадаагүй, өөрийн гэсэн мэргэжилгүй, ажил хийхэд шаардлага хангахгүй олон хүчин зүйлс тэднийг хүчирхийллийн хохирогч болоход нөлөөлж байна.

Мөн хүчирхийллийг яагаад эрэгтэйчүүд их үйлдээд байна вэ гэвэл дээр үеэс Монголчууд бид эрэгтэй хүүхдээ эр хүн уйлж болдоггүй юм, эр хүний нулимс цаанаа гэдэг гэх мэтээр эрэгтэй хүүхдээ хатуу чанга өсгөснөөс үүдэн хүүхэд багаасаа л эр хүн шиг бие даасан байдаг, гэрийн бүх эрх мэдлийг эр хүн л мэддэг байх ёстой гэсэн дарангуйллын зан араншинтай болж хүмүүжсэнээс үүдэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болж хувирч байна.

Эмэгтэй хүн нөхрөөсөө эдийн засгийн хараат байсаар эцэстээ гэртээ суудаг, ажилгүй нэгэн хэмээн ад үзэгдсэнээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсоор байна

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа шалтгаан нөхцөл нь ажилгүйдэл, архидалт, боловсролын доголдолтой шууд холбоотой. Судалгаанд ашигласан контентээс харахад хүний Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхийг зөрчиж байгаа нь хамгийн түгээмэл бөгөөд жигшмээр үйлдэл юм. Улмаар цаашлаад эмэгтэйчүүд болон хүүхдүүд хамгийн их хохирч байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хүчирхийллийг мэдээлэхдээ үүнийг эмгэнэлт явдал, нийгэмд байдаг л нэг зүйл мэтээр харуулдаг.

Эмэгтэйчүүд өөрийн гэр орноос өөр аюул багатай газар өөр хаана ч байхгүй гэтэл тэд өөрийн хамгийн ойр дотны хүнийхээ гарт хүчирхийлүүлсээр л байна. Эдгээр эмэгтэйчүүдэд тохиолдож байгаа энгийн юм шиг мөртлөө хамгийн голлох хүчин зүйл нь гэр бүлийн түүх, эрт гэрлэлт, ах дүү, хамаатнууд, өндөр настай аав, ээжүүд, мөн нөхөр нь архины хамааралтай болох зэрэг нийгмийн хүчин зүйлүүд нөлөөлсөөр байна. Үүнээс хамгаалах гол арга нь боловсрол эзэмших, ажилтай байх явдал юм. Дотны хүмүүсийн хүчирхийллийн муу үр дагавар нь гэр бүлийн эдийн засгийн түвшинд хамгийн их илэрч байна.

Судлагдсан контентээс үзэхэд шалтгаан нөхцөлийн хамгийн ихийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил дутмаг, боловсролын гажуудал, архидалт, ажилгүйдэл гэсэн шалтгаан нөхцөлүүд илэрсэн. Хүчирхийлэл үйлдэгч нь ёс суртахууны доголдолтой, хүндлэлгүй харьцаа, бага насны амьдрал болон гэр бүлийн хүмүүжил болон нийгмийн хүчин зүйлсийг гол шалтгаан гэж үзэж байна. Нөгөө талаас хохирогчид хардалт, зан араншин болон согтууруулах ундаанаас хамааралтай байна. Эрчүүд эмэгтэйчүүдийг маргааны явцад зүгээр л дуугуй байх, хүлцэнгүй байхыг тулгадаг бөгөөд тэр шаардлагаас нь зөрхөд л тэднийг айлган сүрдүүл, дарамталж , эрхшээлдээ байлгадаг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь далд явагдахын зэрэгцээ давтагддаг, давтагдах бүрдээ улам нуугдмал болж байна. Үйлдэгдэх хэлбэр нь хурц, харгис хэлбэрт шилжиж байна.

Гэхдээ гэр бүлийн хүчирхийлэлд дан ганц эмэгтэйчүүд өртдөггүй. Өндөр настан, Эрэгтэй хүмүүс ч гэсэн өртсөн тохиолдлууд амьдрал дээр ч мөн контентын нэг хэсэгт ч гарсан байдаг.

Нийгэм, эдийн засгийн байдлаас үүдэн эрт тэтгэвэрт суусан болон гэртээ ажилгүй байдаг эрэгтэйчүүдийг тэжээж байгаа, гэр орноо авч явж бйагаа гэдэг үндэслэлээр байнгын дарамтлан сэтгэл санааны болон бие махбодын дарамтанд оруулсанаас болоод эрчүүд амиа хорлох явдал ихэссэн байна. Мөн өндөр настай аавь ээжийнхээ тэтгвэрийг зээлээр авч хэрэглээд гэртээ байлгахдаа хэрэгцээтэй зүйлсийг нь шийдэж өгдөггүй, хажуудаа байлгаж халамлах нэрээр хүний эрхийг зөрчиж хүчирхийлж байгаа нь контент болон бодит амьдрал дээр энэ судалгааны явцад ажиглагдлаа.

Гэр бүлийн хүчирхийллээс нийтэд түгээн дэлгэрүүлэх энэ талаар хийсэн контент, бичлэгийн зөвхөн мэдээллийн сайтад бус хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулвал илүү өргөн хүртээмжтэй байна. Иргэн болгон ухаалаг утасны хэрэглээ болон, дата нэгжний боломж хомс байх тул Үндэсний телевиз болон Малчин телевизээр гаргавал “Өрх бүрт хүрэх” магадлал өндөр хэмээн үзэж байна.

Мөн хүчирхийлэл үйлдэж буй иргэн бүртэй ойр ажиллахын тулд анхан шатны нэгжүүдэд мэргэжсэн боловсон хүчинг хангалттай бэлтгэх, сургалт семинарт хамруулах нь зүйтэй байна.

§2.3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх зарим асуудал

2.3.1. Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг тооцоолох, барагдуулах асуудал

Гэмт хэргийн улмаас үүсэх сөрөг үр дагаврыг хууль зүйн шинжлэх ухаанд хохирол, гэм хор гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг. Хэл зүйн талаасаа “хохирол” гэдэг нь алдагдал, “гэм” гэдэг нь ёс зүйгээс ангид үйл явдлын уршиг, нөлөө, “хор” нь хөнөөл, аюул зовлон, “уршиг” гэдгийг чирэгдэл, уршиг удах¹ хэмээн тайлбарлажээ.

Хууль зүйн шинжлэх ухаанд тэр дундаа эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэм хорын илэрхийлэгдэх хэлбэр нь хохирол² гэх үзэл хандлага нэгэнт тогтсон байна. Харин гэмт хэргийн улмаас гэм хор учруулах хэлбэрийн тухайд эдийн ба эдийн бус гэм хор гэж ангилдаг төдийгүй эдийн гэм хор нь материаллаг, эдийн бус нь материаллаг бус шинж чанартай хор уршгийг илэрхийлдэг байна.

Гэм хор нь гэм хор учруулсан гэм буруутай этгээдийн хувьд хохирол төлөх үндэслэл буюу үүргийг, гэмт явдлын хохирогчийн хувьд хохирол нэхэмжлэх эрх үүсэх үндэслэлийг бий болгодог.

Эдийн бус гэм хорын нэгэн төрөл гэмт хэргийн улмаас үүсэн бий болсон сэтгэл санааны гэм хорыг арилгах асуудлыг манай улсын 1994 оны Иргэний хууль, 2002 оны шинэчлэн найруулсан Иргэний хуульд эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах гэсэн бие даасан зүйл заалт орсон нь иргэний эдийн бус хохирлыг арилгах, эд хөрөнгийн бус эрх ашгийг хамгаалах чухал заалт болсон юм.

Гэм хорын илэрхийлэгдэх хэлбэр болох хохирол нөхөн төлөх асуудал нь үнэлгээний албатай салшгүй холбоотой. Манай улсад үнэлгээний алба үүсч хөгжөөд 20 гаран жилийн хугацаа өнгөрч байна. Хувийн хэвшлийн төлөвшил, өмчийн харилцааны өөрчлөлт шинэчлэлийг даган үнэлгээний үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж, 2010 онд Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол Улсын хууль батлагдаж, үнэлгээний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм. Гэсэн хэдий ч өнөө хүртэл гэмт хэргийн уршгаар үүсэн бий болсон эдийн бус хохирлын нэгэн төрөл болох сэтгэл санааны хохирлыг хэрхэн үнэлэх, тооцох нь тодорхойгүй нэгдсэн нэг шийдэлд хүрээгүй байна.

Судалгаанаас харахад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч нь хүчирхийллийн улмаас бие мах бодийн төдийгүй сэтгэл санааны хувьд давхар хохирдог гэдэг нь тодорхой ч, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах торгох, баривчлах шийтгэл нь тухайн гэр бүлд санхүүгийн дарамт учруулах, шийтгэл хүлээснийхээ төлөө өсөрхөн ялархаж дахин хүчирхийлэл үйлдэгдэх шалтгаан болж байгаа нь мөн л хохирогчид сэтгэц зүйн дарамт болдог байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэгт: “гэр бүлийн хүчирхийлэл” гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний **сэтгэл санаанд дарамт учруулах**, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг; мөн хуулийн 6 зүйлийн 6. Дахь хэсэгт: “Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх,

¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966. 699, 355, 693, 600 дахь тал

² Ш.Ариунбилэг. ЭБШ ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. 2011, 15 ахь тал

мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр **сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ**” гэж тодорхойсон юм.

Эрүүгийн хуулийн гол үзэл санаа болох хохирогчийн эрхийг хамгаалах, хор уршгийг арилгах, хохирол нөхөн барагдуулахад гэм хорыг тооцон гаргах үнэлгээ нь чухал үүрэгтэй. Гэмт хэргийн улмаас учирсан эдийн ба эдийн бус хохирлыг хохирогчид нэхэмжилдэг ч, хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг сэтгэл зүйн үйлчилгээний төрөл нөхөн сэргээх сэтгэл заслын эмчилгээ хийлгэхэд гарсан зардлын хэмжээгээр тооцон гаргуулах, зарим тохиолдолд 2016 онд Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос гаргасан “Сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцох” аргачлалыг ашиглах төдийгээр энэхүү ажиллагаа хягаарлагдаж гэмт хэргийн хохирогчдын сэтгэл санааны хохирлыг тооцох, үнэлэх албан ёсны стандарт, аргачлал, журам байхгүйгээс шүүгч хохирогчийн нэхэмжлэхийн шаардлагын ихэнхийг тодорхой үндэслэлгүй хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байна.

Өнөөгийн байдлаар гэмт хэрэг зөрчлийн торгууль, хүүгийн орлого нь орон нутгийн төсвийн бус орлогод төвлөрч байгааг өөрчилж сан бий болгох энэ сангаар дамжуулан гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох тухай зохицуулалт хийх шаардлагатай бөгөөд энэ нь “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулах сангийн тухай хууль” хэлбэртэй байх боломжтой.

Манай улсын зарим хууль тогтоомжуудад сэтгэл санааны хохиролыг нөхөн төлөх асуудлыг хэрхэн тусгасан байдлыг авч үзвэл:

Иргэний хууль: Эдийн бус гэм хорыг арилгах хэмээх 511 дүгээр зүйлийн 511.2 дахь хэсэгт: “Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн **сэтгэл санаанд учирсан үр дагавар** зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно” .

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль: Хохирол арилгуулах эрх хэмээх . 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг: Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, **сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах** болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй. Мөн хуулийн сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах хэмээх 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэгт: **Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх** тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана.

Зөрчлийн тухай хууль: Бэлгийн дарамт учруулах хэмээх 6.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, **сэтгэл санааны** /сөрөг гэдэг үг орхигдсон бололтой/ үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр ... илэрхийлсэн бол хариуцлага хүлээлгэхээр заажээ. Хэдийгээр шүүх чиг үүргийн дагуу хүний эрх, ашгийг хамгаалахыг хүссэн ч гэмт хэргийн улмаас учирсан гэм хор ын нэгэн төрөл сэтгэл санааны хохирлыг үнэлэх тооцох аргачлал, тогтсон стандарт байгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэнд хүндрэл бэршээл учруулж, хохирогч хохирогчоороо үлдэх нэг нөхцөл болж байна.

Ийнхүү сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх ба хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар, хохирол учруулсан нөхцөл

байдал зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоож байхаар хуульчилсан байна.

2016 онд Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцох аргачлалыг боловсруулжээ. Гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэл санааны хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох зардлыг тооцоолохдоо:

- Алдагдсан боломжийн үнэлгээ,
- Шууд зардал буюу баримтаар нотлогдох хохирлуудыг багтаан эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлын үнэлгээ,
- Сэтгэл санааны хохирлын үнэлгээг тооцоолохоор тогтоосон байна.

Алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ (АБХУ):

Статистик мэдээнээс Монгол хүний дундаж наслалтын мэдээллийг авч, тэтгэвэрт гарах нас, ажил эрхлэх насны зөрүүгээр идэвхтэй ажиллах жилийг тооцоолох ба тухайн хохирогчийн ажлаас гарсан өдрөөс тэтгэвэрт гарах өдрийг хүртэл тооцоолж, нийт хэдэн өдөр ажиллах боломжоо алдсаныг сард (АБА) шилжүүлж сарын цалингаар (СЦ) үржүүлэн нийт цалингийн алдагдлыг гаргана.

$$\text{АБХУ} = \text{АБА сарын тоо} * \text{СЦ}$$

Шууд зардал буюу шууд хохирлын үнэлгээ (ШЗХУ):

Шууд зардлыг тухайн хохиролтой холбогдон гарсан зардал буюу эмчилгээний зардал (ЭЗ) болон бусад зардлуудын (ББНЗ) баримтаар нотлогдох нийлбэрээр тооцоолно.

$$\text{ШЗХУ} = \text{ЭЗ} + \text{ББНЗ}$$

Сэтгэл санааны хохиролын үнэлгээ (ССХУ):

Сэтгэл санааны хохирол тооцооллыг мөнгөн дүнгээр илэрхийлэхэд дотоодын нийт бүтээгдэхүүнийг (ДНБ) хүн амын тоонд харьцуулан нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг (НХНДНБ) гаргаж үржүүлэгчээр (МХҮХ-ноос гаргасан 5.5) үржүүлэн хүний амь насны үнэлгээг гарна. Гарсан тоог хуанлийн хоногт (ХХ) харьцуулахад нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэлгээ (НӨССХСҮ) гарна.

Хохирлоос үүссэн үйлдэл байдал	Итгэлцүүр
Сэхээн амьдруулах	5.0
Мэс засал, хагалгаа	4.0
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн	2.0
Зовиуртай байсан	2.0
Энгийн зовиур	1.0
Хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар	0-1.0

Сэтгэл санааны хохирлын нийт үнэлгээг гаргахад эмнэлэгт хэвтсэн хоногийг (ЭХХ) дээр тооцоолон гаргасан сэтгэл санааны хохирол тооцох нэг өдрийн суурь үнэлгээг холбогдох итгэлцүүрээр үржүүлэн гаргана. Бусад дээрх итгэлцүүрт хамаарах хохирол үүссэн байвал энэ аргачлалаар тооцоолон гаргах боломжтой байна. Энэхүү үржүүлэгч болон итгэлцүүрийг МХҮХ-ноос боловсруулан гаргасан болно.

$$\text{ССХҮ}=(\text{НХНДНБ}*\text{Үржүүлэгч})/\text{ХХ})*\text{ЭХХ}*\text{итгэлцүүр}$$

Дээрх алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ, сэтгэл санааны хохирлын үнэлгээ, шууд зардлуудын хохирлын үнэлгээний нийлбэр нь эрүүл мэнд, сэтгэл санааны нийт хохирлыг (ЭМССХҮ) тооцоолох үнэлгээ болж байна.

$$\text{ЭМССХҮ}=\text{АБХҮ}+\text{ШЗХҮ}+\text{ССХҮ}$$

Энэхүү аргачлалыг үндэслэн шүүх хохирогчийн сэтгэл санааны хохиролын үнэлгээг хийсэн тохиолдол хэд хэд гарсан байна.

Тиймээс гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны гэм хорын үнэлгээг бодитой тогтоох, шийдвэрлэх, нөхөн төлүүлэх нь хууль зүйн болон нийгмийн тулгамдсан асуудлын нэг мөн бөгөөд энэ талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймд:

1. Монгол Улс дэлхий нийтийн жишгийг дагаж хүний амь нас эрүүл мэнд сэтгэл санааны гэм хорыг үнэлэх тооцох стандарт аргачлалыг боловсруулахдаа сэтгэц гэм судлалын шинжлэх ухаанд суурилан боловсруулах;
2. Монгол Улсад гэмт хэргийн хохирол нөхөн барагдуулах үндэсний тогтолцоог бий болгох.
3. Монголын хохирол үнэлгэгчдийн холбооноос гаргасан аргачлалыг суурь болгон хөгжүүлэн ашиглах, түүнийг боловсронгуй болгоход мэргэжлийн холбооны судалгааны баг ажиллуулах саналтай байна.

2.3.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчид хийсэн шинжилгээ, өнөөгийн нөхцөл байдал

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь эрх бүхий байгууллагаас томилсон тогтоол, захирамжийн дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн холбоотой үзлэг шинжилгээг, Тусгай шинжилгээний газрын Биологийн шинжилгээний лабораторид бэлгийн холбогдолтой шинжилгээг хийж дүгнэлт гаргаж байна. Харин хөдөө орон нутаг тухайн аймгийн шүүхийн шинжилгээний албаны шинжээч эмч нар Шүүхийн шинжилгээний тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/216 422 тоот тушаалаар батлагдсан “Гэмтлийн зэрэг тогтоох” журмыг үндэслэл болгон үзлэг шинжилгээг хийж холбогдох дүгнэлтийг гарган ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2019 онд гэр хүчирхийллийн шинжтэй зөрчлийн 470, эрүүгийн 769 хохирогчид гэмтлийн зэрэг тогтоох 1239 үзлэг хийжээ.

Үүнээс хөнгөн гэмтэл учирсан 727, хүндэвтэр гэмтэл учирсан 42, хүнд гэмтэл учирсан 10, гэмтэлгүй 131, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 329 дүгнэлт гаргасан байна. Мөн онд гэр бүлийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой 65 үзлэг хийж дүгнэлт гаргасан ба үзлэг орсон иргэдийн хүйсээр нь авч үзвэл эмэгтэй 60, эрэгтэй 5, насны хувьд хүүхэд /18 наснаас доош/ 55, насанд хүрсэн-10 хүнд үзлэг хийж холбогдох дүгнэлтийг гаргасан байна.

2020 онд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй зөрчлийн 216, эрүүгийн 1006 нийт гэмтлийн зэрэг тогтоох 1222 үзлэг хийсэн ба үүнээс хөнгөн гэмтэл учирсан 695, хүндэвтэр гэмтэл учирсан 56, хүнд гэмтэл учирсан 5, гэмтэлгүй 117, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 349 дүгнэлт гаргасан байна. Мөн гэр бүлийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой 69 үзлэг хийж дүгнэлт гаргасан ба үүнийг хүйсээр нь авч үзвэл эмэгтэй 55, эрэгтэй 14, насны хувьд хүүхэд /18 наснаас доош/ 52, насанд хүрсэн-17 хүнд үзлэг хийж холбогдох дүгнэлтийг гаргасан байна.

График-1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үзлэг шинжилгээ.





График-2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой учирсан гэмтлийн зэрэг



Одоогийн байдлаар Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт зөвхөн бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой үзлэг шинжилгээг хийж байгаа тул цаашид гэмт хэрэг, зөрчлийн улмаас үүссэн сэтгэл санааны гэм хор, хохирол тогтоож дүгнэлт гаргах нэгж болон орон нутгийн шүүхийн шинжилгээний албанд сэтгэл санааны хохирол тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий шинжээч байх асуудал зайлшгүй байна.

Хүний эрхийн хуульч М.Ичинноров нэгэн илтгэлдээ “Хүний алтан амийг мөнгөөр үнэлэх боломжгүй ч мөнгөн дүнгээр илэрхийлдэг систем байдаг. Хүний амь насны эдийн засгийн үнийг тооцохдоо дундаж наслалтаас насыг нь хасаж, дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хүнд ногдох тоогоор үржүүлж гаргадаг жишиг бий. Үүгээр бодоход монгол хүний эдийн засгийн үнэ цэнэ 150-300 сая орчим төгрөг болохоор байна. Гадаадын зарим оронд 50, 125 мянган ам.доллараас эхлээд 7 сая ам.доллараар тооцож байна” хэмээн дурджээ. Харин гадаад улсын туршлагыг судлан үзэхэд гэмт хэрэгт өртсөн хэн боловч сэтгэл санааны хохирол учирдаг гэж үзэж сэтгэл санааны хохирлыг гэмт хэргийн төрөл бүрээр тооцсон тарифийн үнэлгээг үндэслэдэг байна. Тухайлбал, Германы хувьд сэтгэл санааны гэм хорыг арилгахад тусгай аргачлал боловсруулсан бөгөөд үүнийг шүүх шийдвэр гаргахдаа мөрдлөг болгодог. Хохирлын хэмжээг тодорхойлохдоо хариуцагчийн гэм буруу, хохирогчид бий болсон сөрөг үр дагавар, хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үздэг байна. Өмнөд Солонгосын хувьд сэтгэл санааны хохирлын суурь төлбөрийг 80 сая вонноор үнэлдэг нь манай улсын мөнгөн тэмдэгтээр илэрхийлбэл 176.000.000 сая төгрөг болно.

Урд хөршийн хувьд эдийн бус гэм хорыг тооцох аргачлалгүй ч тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүхээс тогтоодог аж.

ОХУ-ын шүүхийн практикт сэтгэл санааны хохирлыг тогтоохдоо А.М.Эрделевскийн зохиосон хүснэгтийг үндэслэн тооцож байна. Мөн гэмт хэргийн улмаас бие эрхтэндээ гэмтэл авч хохирсон этгээдэд өвдөж шаналсныхан төлөө нөхөн төлбөр олгох зохицуулалт, мөн нэр төр, алдар хүндийн хохирол хүлээсэн этгээдэд ч мөн тарифт суурилсан нөхөн төлбөр авах зохицуулалт байна.

АНУ-ын Холбооны улсуудын хэмжээнд 1984 онд батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хууль өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Мөн хуулиар гэмт хэргийн хохирогчийн сан байгуулах, санг бүрдүүлэх, санхүүжүүлэх, хуваарилах, нөхөн төлбөр олгох зардал нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэслэл, олгох журам, зохион байгуулах зэрэг асуудлыг хуульчилсан байна.

Англи улс Гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөрийн тухай хуулийг 1995 онд батлан гаргасан бөгөөд хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг байна. Хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн нөхөн төлбөр олгодог ажээ.

Япон улсад 1980 онд Гэмт хэргийн хохирогчид төлбөр олгох тухай хууль батлагдсан бөгөөд харин одоо мөн хуулийг Санхүүгийн болон бусад туслалцаа үзүүлэх хууль гэж нэрлэх болсон байна.

§ 2.4. КОВИД-19 цар тахлын үеэр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж буй олон улсын зарим туршлага

2.4.1. Олон улс хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж буй байдал

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Байгууллагын мэдээлснээр дэлхий дээр өмнөх 12 сарын хугацаанд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр, хамтрагчийн зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.

4 улсын 1 нь эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тусгайлсан хуультайгаас харахад ихэнх улс оронд хууль эмэгтэйчүүдийн талд байдаггүйг харуулж байна¹.

Аливаа хүчирхийлэл далд хэлбэртэй байдгаас хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авахад ихээхэн бэрхшээлтэй. Тухайлбал, хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн 10 хүрэхгүй хувь нь цагдаад ханддаг аж. Олон улс оронд хөл хорионы дэглэм тогтоогоод байгаа энэ нөхцөлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогчдын хувьд тусламж хүсэх, авах боломж хязгаарлаж байна.

Дэлхий даяар тархаад буй КОВИД-19 шинэ халдвараас сэргийлэхийн тулд улс орнууд тусгаарлах, хөл хорионы дэглэм тогтоох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай зэрэгцэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчил нэгэдэж тэдгээрийн талаар дуудлага, мэдээлэл өсөж, тусламж үйлчилгээний хэрэгцээ нэмэгджээ. Энэ байдал сүүлийн хэдэн сарын хугацаанд дэлхийн олон улс орнуудад тэр дундаа Хятад, Их Британи, АНУ, Бразил, Франц, Австралиас зэрэг улс орнуудад эрс нэмэгдсэн байна.

Дэлхийн хэмжээнд 15-49 насны 243 сая эмэгтэйчүүд, охидууд 2020 онд хамтран амьдрагчийнхаа бэлгийн болон бие махбодийн хүчирхийлэлд өртсөн. Энэтхэг улсын Эмэгтэйчүүдийн үндэсний комиссоос хөл хорионы үеэр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гомдлын тохиолдол 94 хувиар өссөн гэж мэдээлсэн бол, Аргентинд хийгдсэн судалгаагаар хохирогчдын шууд дуудлага 127 хувиар өссөн байна. Энэхүү судалгаагаар хамтран амьдрагчийн хүчирхийлэл ба хөл хорио хоёр хоорондоо эерэг хамааралтай болохыг тогтоожээ. Гэр бүлийн хүчирхийлэл нь аюулгүй байдал, эрүүл мэнд, мөнгөний асуудал, дарамт шахалт, амьдралын хязгаарлагдмал нөхцөл байдлаас шалтгаалан нэмэгддэг тул КОВИД-19 тахлын улмаас энэ тоо нэмэгдэх магадлалтай. Учир нь хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн хамт гэрийн хөл хорионд байгаа явдал нь гэр бүлийн хүчирхийллийг нэмэгдүүлж, тэдэнд тусалж чадах хүмүүс, боломжоос нь холдуулж байна.

КОВИД-19 цар тахлын үед хүн хооронд зай барих шаардлага, ажиллах зөвшөөрлийн асуудлын улмаас хамгаалах байр, нийгмийн үйлчилгээний газрууд хаагдах эсхүл өдөрт хүлээн авах хүний тоо, нэг хүнд зарцуулах цаг хугацаа зэрэг нь илт багасгасан юм. Үүнээс гадна КОВИД-19 халдварын тархалтын улмаас эрүүл мэндийн байгууллагын яаралтай бэлэн байдлыг хангахад түр хоргодуулах байрыг нэмэлтээр ашиглах нь энэ чиглэлийн үйлчилгээ авах боломж, хүртээмжийг бууруулж байгаа тухай мэдээллүүлд цацагдаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас тусламжийн утасны үйлчилгээ, хоргодох байраар хангах хэрэгцээ нэмэгдэж байгаа талаар Аргентин, Канад, Франц, Герман, Испани, Нэгдсэн Вант Улс, АНУ-ын засгийн газрын эрх баригчид, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид, иргэний нийгмийн байгууллагууд тайландаа тэмдэглэсэн байна.

Дуудлага мэдээлэл нэмэгдсэнтэй холбоотой хамгаалах байрнууд үйл ажиллагаа явуулах бүхий л арга замыг эрэлхийлж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг

¹ <https://www.unwomen.org/en/news/stories/2020/4/statement-ed-phumzile-violence-against-women-during-pandemic?fbclid=IwAR3rg5vkv8lOJLQIPpWKdtV91nlzXI-U33Ek6Y8jXDV4lJKW81oPtZ-1Jcw>

ашиглан гэр бүлийн хүчирхийллийн талаарх ард иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, хандив цуглуулж, засгийн газраас дэмжлэг үзүүлэхийг шаардсаар байна. Улс орнууд хүчирхийлэлд нэрвэгдсэн хүнд туслах онлайн дэмжлэг, вэб зөвлөгөө, Whats App лавлах утас, гар утсаар өгөх үйлчилгээг нэмэгдүүлж эхэлжээ. Энэ нь эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй сэтгэл түгшээх, стресс, сэтгэлийн хямрал, гэмтлийн дараах стресс, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ, төлөвлөөгүй эрсдэлтэй бэлгийн зан үйл зэрэг эрсдлийн хор уршгийг даван туулахад цаг үеэ олсон сайн арга хэмжээ юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ, Америкийн Сэтгэл судлалын холбоо болон бусад агентлагууд цар тахал гэр бүлийн хүчирхийллийг нэмэгдүүлж магадгүй гэж таамаглаж, Засгийн газруудаас тахлын эсрэг хариу үйлдэл үзүүлэхдээ эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг нэгдүгээрт тавихыг хүсч, тусалж чадах нөөцийг санал болгов (НҮБ, 2020; ДЭМБ, 2020а).

Гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэж байгаатай холбогдуулан төр засгуудын авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээ, санаачлагууд нь талархуштай. Энэ нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, хүний эрхийг хамгаалах, цар тахлын сөрөг үр дагаварыг багасгахад нөлөө үзүүлнэ. Гэсэн хэдий ч дан засгийн газрын хариу арга хэмжээ, түүний үр нөлөө нь хязгаарлагдмал бөгөөд эмэгтэй хүн бүрийг хамарч чадахгүй. Мэдээллийн суваг, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх сурталчлах үндэсний хэмжээний хүчтэй компанит ажлууд дутагдсаар байна. Иймд ТББ, иргэний нийгэм, нийгмийн эрүүл мэндийн газар, сэтгэл зүйч, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, Их сургуулиудын сэтгэл судлалын тэнхимүүдийг татан оролцуулах шаардлагатай байна. Ялангуяа КОВИД-19 цар тахлын үеэр гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх нь хор хөнөөлийг бууруулахад туслах юм.

2.4.2 КОВИД-19 цар тахлын үеийн гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

Цар тахлын улмаас хүмүүсийн дунд айдас, санхүүгийн асуудал, аюулгүй байдал алдагдах, ажилгүй болох гэх мэт сэтгэлийн түгшүүр бий болсон бөгөөд үүнтэй холбоотой зан үйлээ хянаж чадахгүйгээр стресс, маргаан, зодоон, зөрчилдөөн, уур уцаар, хүчирхийлэл үйлдэх замаар илэрхийлж байж болно. Мөн карентилагдах нь эмэгтэйчүүдэд гэртээ хоол хийх, гэрийн ажил, гэр бүлийн гишүүддээ тавих анхаарал халамж ихэссэнээр өөрт авах ачааллыг нэмэгдүүлжээ. Сургуулиудыг хааснаар энэ ачааллыг улам даамжруулж, илүү их стресст оруулав. Ийм нөхцөлд гэр орондоо өөрийн хүслийн эсрэг амьдрахаас өөр аргагүй байдалд байгаа хүмүүс гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа бөгөөд хүчирхийлэлд өртөж байгаа арга хэлбэрүүд нь өөр өөр байна. Ерөнхийдөө цар тахлын үеийн хөл хорио нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод гэр бүл эсвэл нийгмийн халамж үйлчилгээнээс туслалцаа дэмжлэг авахад саад болж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь албадан хяналтаар (Coercive control) эхэлдэг. Энэ нь хүчирхийлэл үйлдэгч нь (ихэвчлэн эрэгтэй) хохирогчдыг (ихэвчлэн эмэгтэйчүүдэд) айлган сүрдүүлэх, заналхийлэх, тусгаарлах, хянах тактик хэрэглэдэг бөгөөд энэ нь хохирогчид урт хугацааны туршид сөрөг нөлөө үзүүлдэг. Энэ төрлийн хүчирхийлэл нь ихэвчлэн гэрийн ажил, хүүхэд асрахтай холбоотой тандалт, мөрдөн мөшгих, жендэрийн “өдөр тутмын зан үйлийн бичил зохицуулалтыг” хамардаг. Канад дахь эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эсрэг хүчирхийллийн талаар хийгдсэн судалгаанд КОВИД-19 цар тахлын үед албадлага, хяналтыг эрчимжүүлэх, үүнд хохирогчдын найз нөхөд, гэр бүлийнхэнтэй нь харилцах харилцааг багасгах эсвэл хянах; хохирогчдийн суурь хэрэгцээнээс нь хасах; вирус, нийгмийн эрүүл мэндийн талаархи мэдээллийг нууцлах; маск, бээлий, цэвэрлэгээний

хэрэгсэл, гарын саван, ариутгагч гэх мэт интернет, эм, хувийн ариун цэврийн хэрэгслийн хандалтыг хязгаарлах зэргээр хүчирхийллүүд ихээр бүртгэгдэж байгаа аж.

Өөр нэгэн чухал асуудал бол цар тахлын үеэр технологи нь хохирогчид албан ба албан бус дэмжлэг, туслалцаа авах боломжийг нэмэгдүүлдэг. Гэсэн хэдий ч гэр бүлийн хүчирхийлэгч хохирогчийн хэрэглэдэг төхөөрөмжинд хяналтын программ суулгах зэргээр техник технологийн хөгжил дэвшлийг ашиглан хохирогчдыг хянах хандлагатай болсон. Энэ тохиолдолд хохирогчид гар утас, компьютер ашиглан туслалцаа авах боломж хязгаарладаг. Цар тахлын үеэр гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээллэж байгаа эмэгтэйчүүд өөрийнхөө утасны дуудлагыг мэдэгдэх вий гэсэн айдастай ярьж байсан бөгөөд цаашлаад ярьж байхдаа гэнэт утсаа таслах, эсвэл ярианы сэдвийг өөрчлөх нь их ажиглагддаг байна. Тиймээс КОВИД-19 цар тахалын болон үүнээс хойшхи эрин үед хохирогчдод зориулагдсан технологи ашиглах аюулгүй орон зайг бий болгоход анхаарах, төхөөрөмж оролцуулан хүчирхийлж байгаа бодит нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой болж байна.

Энэ төрлийн туслалцаа, дэмжлэгийг үзүүлдэг хувь хүн, албан байгууллагууд зайны үйлчилгээ санал болгож эхэлсэн нь хохирогчдод тулгарч буй бэрхшээл, стрессийг улам нэмэгдүүлж байна. Судлаачдийн үзэж байгаагаар цар тахлын дараа нийгмийн, халамж үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, албан байгууллагуудын эрэлт огцом өсөх тухай таамаглал дэвшүүлж байна. Иймд одоогийн хөл хориог цуцалсны дараа гэр бүлийн хүчирхийллийн нэмэгдэх хандлагатай нөхцөл байдалд засгийн газрууд болон цагдаагийн газар хэрхэн хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг нягталж үзэх шаардлагатай.

2.4.3 КОВИД-19 цар тахал, түүний дараа гэр бүлийн хүчирхийлэлд авах хариу арга хэмжээ

Нэг. Хөл хорионы үеэр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг дэмжихэд нийгмийн халамж, үйлчилгээ. КОВИД-19 цар тахлын үеэр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хөл хорионоос үүдэлтэй хүчирхийлэгчтэй байнга гэртээ байх шаардлагатай болсноос тэдний алхам бүр хяналттай болж, хувийн ухаалаг утас, төхөөрөмжийг хүртэл хянах явдал ихэссэнээс хүчирхийллийн эсрэг байгууллагуудтай холбоо тогтоох боломж хязгаарлагдах болжээ. Иймд хөл хорионы үеэр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг дэмжихэд нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэгчид, технологичид, хэвлэл мэдээллийн ажилтнуудын авч хэрэгжүүлсэн шилдэг арга, туршлагуудаас авч үзье.

Онцгой нөхцөл байдлын үетэй холбогдуулан нийгмийн халамж үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнуудын үйл ажиллагаанд гарсан өөрчлөт, шинэчлэлтүүдийг 4 үндсэн чиглэлийн хүрээнд авч үзнэ. Эдгээр нь (1) Гэр бүлийн хүчирхийллийн гэмт явдлаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах буюу протокол боловсруулах; (2) албадлагын хяналт; (3) урьдчилан сэргийлэх, хөндлөнгөөс оролцох; (4) албан бус дэмжлэгийн боловсрол бөгөөд шинэ хандлагууд нь цар тахлын үед ч түүний дараа нь ч аль алинд нь ашигтай.

1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт явдлаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг (протокол) боловсруулах: Эдгээр протоколууд нь үйлчлүүлэгчид нэн шаардлагатай амин чухал мэдээллийг (жишээлбэл, зайнаас ажиллаж байгаа ажлын цагийн хуваарь, онлайн болон утсаар авах боломжтой дэмжлэгийн хэлбэрүүд) багтаасан харилцан ойлголцох практик зөвлөмжийг агуулсан ажлын баримт бичиг юм. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага, ажилтнууд КОВИД-19 цар тахлын үед хохирогчдод тодорхой бөгөөд тууштай дэмжлэг үзүүлэхэд туслах зорилгоор ажилтнуудад зориулж бичсэн гарын авлагуудыг үргэлжлүүлэн шинэчлэн, боловсронгуй болгох ёстой. Өнөөдрийг хүртэл улс орнууд, олон улсын байгууллагууд өөр өөрсдийн стандартчилсан протоколуудыг боловсруулж байгаа

бөгөөд гарсан даруйд нь салбарын мэргэжилтнүүд авч ашиглах, мэдээллийг түгээх талаар сонор сэрэмжтэй байх ёстой. Жишээлбэл:

1) Цар тахалтын дэгдэлт эхэлснээс хойш удалгүй Алберта Эмэгтэйчүүдийн Хоргодох байрны Зөвлөлөөс (Alberta Council of Woman's Shelters) хоргодох байрны үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан түр удирдамж боловсруулж, нийгмийн эрүүл мэндийн талаарх зөвлөмж болон хохирогч аюулгүй байдлаа хангах стратеги зэргийг багтаасан зөвлөмжийг гаргаж цахим хуудсандаа байршуулсан байна.

https://acws.ca/wp-content/uploads/2020/04/2020-04-08_How-you-can-respond-to-DV-DURING_COVID.pdf

2) Дэлхийн эрүүл мэндийн байгууллага цар тахлын үед хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд хандсан зөвлөмжийг цахим хуудсандаа байршуулсан болно.

https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/85240/9789241548595_eng.pdf;jsessionid=8128E32EF615E343C442771B27383514?sequence=1

3) Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сангийн Гэр бүлийн хүчирхийллийн талаарх үндэсний эрүүл мэндийн мэдээллийн төвөөс гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдийг таних, тэдгээрт үйлчилгээ үзүүлэх Үндэсний удирдамж боловсруулсан,

(The Family Violence Prevention Fund's National Health Resource Center on Domestic Violence) <https://www.futureswithoutviolence.org/userfiles/file/Consensus.pdf>

4) IMPACT – Канадын Алберта даяар үйлчилгээ үзүүлэгчдийн сүлжээнээс олон нийтэд зориулж гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зориулсан зөвлөмжийг боловсруулж нийтэлсэн байна.

<https://www.sagesse.org/wp-content/uploads/2020/03/Domestic-Violence-Community-Protocol-COVID.pdf> зэрэг.

2. Албадан хяналт: КОВИД-19 цар тахлын өмнө нь гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцдэг байгууллагууд гэр бүлийн хүчирхийлэл гэдгийг дахин тодорхойлж, үүнд албадлагын шинжтэй хянах зан үйлийг тооцож тусгах талаар оролдож байсан гэдгийг хэлэх нь зүйтэй. Цаашлаад нийгмийн халамж үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, тэдгээрийн ажилтнууд хохирогчдын хүчирхийлэлд өртдөг төрөл, хэлбэрүүдийг өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэй. Цар тахлын үед хүчирхийллийн туслалцаа дэмжлэг авах гол арга хэрэгсэл интернет, утас байгаа тохиолдолд болон тэдгээрийг ашиглах боломжгүй, эсвэл санхүүгийн боломжгүй хохирогчид хэрхэх вэ гэдэг нь тодорхойгүй байна. IMPACT гэх Канадын Алберта даяар үйлчилгээ үзүүлэгчдийн сүлжээнээс 2020 албадан хяналтын талаарх тусгайлан авч хэлэлцсэн семинаруудыг зохион байгуулсан байдаг.

Иймд, нийгмийн халамж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, ажилтнуудаас хамгийн наад тал нь энэ төрлийн хяналтад хөндлөнгөөс оролцох, хохирогчид тусламж үзүүлэхээс урьтаж утас, интернетэд холбогдох арга хэрэгслийг зааж өгөх, боломж нөхцлийг бүрдүүлэх ёстой.

3. Урьдчилан сэргийлэлт ба хөндлөнгөөс оролцох: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөсөнөөр нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнууд КОВИД-19 цар тахлын үеийн нөхцөл байдлын талаарх мэдлэгийг олгох ёстой бөгөөд ингэсэнээр хүчирхийлэгч этгээд вирусын тархалтын талаарх ташаа мэдээлэл ашиглан хяналтаа тогтоон ашиглаж байгаа эсэхийг мэдэж болно. Үүнээс гадна хохирогчийн нөхцөл байдал өөр өөр байх тул интернет, утас, мессэж зэргийг ашиглан тогтмол тусламж үйлчилгээ санал болгож байх хэрэгтэй. Нэгэнт хөл хорио,

цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хохирогч хүчирхийлэгчтэй хамт тусгаарлагдаж байгаа учраас албан болон албан бус дэмжлэг авах боломж хумигдаж байна. Хүчирхийлэгчээс үзүүлж буй хяналтын арга хэлбэр, хэмжээнээс хамаараад хохирогч мэдээлэл, үйлчилгээг харилцан адилгүй авч байна. Зарим тохиолдолд нэг зэрэг олон хүчирхийлэгчтэй хамтран амьдарч байх бөгөөд эдгээр нь хойд эцэг эх/ ах эгч гэх мэт байгаа нь хохирогчид албан туслалцаа хүсэх асуудлыг ярвигтай, төвөгтэй болгож байдаг.

Нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, ажилтнууд албан дэмжлэг үзүүлж байгаагийн хувьд хохирогчдийн аюулгүй байдлын талаарх асуудлыг анхааран авч үзэх ёстой бөгөөд тэд эрсдлийн үнэлгээ хийх, хохирогчийг тусгаарлахад дэмжлэг үзүүлэх аюулгүй төлөвлөгөөг боловсруулахад голлох үүрэгтэй оролцдог. Аюулгүй байдлын төлөвлөгөөний стандартад хүчирхийлэл даамжирвал хэнтэй холбоо барих, гэр доторх хамгийн аюулгүй өрөө, хурдан гарах гарц, шаардлагатай тохиолдолд хувийн эд зүйлээ ойр байлгах зэрэг нь тусгагдсан байх ёстой.

Аюулгүй байдлын төлөвлөгөөнд технологийг хэрхэн аюулгүй ашиглах, аль байгууллагын вэбсайтууд хурдан зугтах арга хэлбэрүүд байгаа гэх мэтчилэн мэдээллүүдийг өгсөн байх ёстой. Мөн хохирогчид гэр бүл, ойр дотны хүмүүс, хөршүүддээ хүнд байдалд байгаагаа мэдэгдэх код үгнүүд болон биеийн хэлэмжийг бий болгосон эсэхийг асууж, нягтлах ёстой.

Нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс хохирогчийг мэдээгүй байхад түүний гар утас, компьютер зэрэг төхөөрөмжүүдэд ажиглалт, хяналтын хэрэгсэл, програм хангамжуудыг суулгасан эсэхийг анхаарч үзэх ёстой. Энэ төрлийн хяналт нь маш ярвигтай. Нэгэнт хохирогч холбогдсон л бол аль болох хурдан нийгмийн туслалцаа, дэмжлэгийг авах арга хэрэгслийг боловсруулах ёстой. Учир нь хүчирхийлэгч төхөөрөмжийг хянаад, туслалцаа авахаар холбогдсоныг мэдсэн бол хохирогч төхөөрөмж дахин ашиглахыг хориглож болзошгүй нөхцөл байдлыг тооцох ёстой.

Өөр нэгэн анхаарал татсан асуудал бол аюулгүй хоргодох байрны хомсдлыг хэрхэн арилгах вэ? гэдэг асуудал юм. Америк, Канад зэрэг зарим улс орнуудад зочид буудлын өрөөнүүдийг хамгаалах байр болгон ашиглаж байгаа тохиолдлууд гарсан. Хэдий тийм боловч энэ нь өртөг өндөр бөгөөд цөөн тооны нийгмийн халамж, үйлчилгээ эрхлэгчид засгийн газрын оролцоо, тусламж дэмжлэггүйгээр санхүүгийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй. Жишээ нь Канад улсын Саскачеваны хотын Нийгмийн үйлчилгээний яам КОВИД-19 тахлын үеэр тусламж хэрэгтэй байгаа хүмүүст үйлчилдэг зарим яаралтай тусламжийн байруудад 171,000 долларын нэмэлт санхүүжилтийг хувиарласан бөгөөд үүндээ зочид буудлуудыг татан оролцуулсан байна. Ингэхдээ хохирогчид КОВИД-19 вирусын шинжилгээ авч хариу нь гартал зочид буудалд тусгаарлагдаж байгаа мэтээр байлгаж байсан байна.

4. **Албан бус тусламж, дэмжлэгийн талаарх боловсрол:** 2020 онд хийсэн судалгаануудаас харахад хохирогч нэн түрүүнд албан гэхээсээ илүүтэй албан бус дэмжлэг туслалцаа авахыг эрэлхийлэх хандлагатай байна. Нийгмийн халамж үйлчилгээ үзүүлж байгаа хувь хүн, албан байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлж, албан дэмжлэгийг /хаанаас, хэнээс, яаж авах/ талаарх мэдээллээр хангаж чаддаг байх хэрэгцээ үүсч байна. Ялангуяа цар тахлын үед ч гэсэн аюулгүй хоргодох байр ажиллаж байгаа, түүний ажиллах цагийн хувиар, холбоо барих арга хэрэгслийн талаарх мэдээллийг байнга түгээж байх шаардлагатай.

Sagesse болон Calgary Women's Emergency Shelter Program and Services зэрэг нийгмийн халамж үйлчилгээний нэгжүүд КОВИД-19 хөл хорионы үеэр гэр бүлийн хүчирхийллийн эсрэг авах хариу арга хэмжээний талаар онлайн сургалтыг явуулсаар байна. Энэ сургалтаар албадан хяналт гэж юу болох, энэ төрлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдтэй хэрхэн харилцах, дэмжлэг үзүүлэх талаар сургалтуудыг зохион байгуулж байна. Sagesse болон үүнтэй ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хүчирхийллийн хохирогчдоос дэмжлэг авахаар ирүүлж буй дохио, зангаг (гэрэл анивчуулах, хөшиг нээж хаах, цонхоороо даллах) хэрхэн таних тухай сургалтыг ч мөн зохион байгуулахаар төлөвлөж байна. Канадын эмэгтэйчүүдийн аюулгүй хорогдох байрнаас зохион байгуулдаг цахим сургалтуудад оролцож байгаа хохирогчид эрхий хуруугаар хөдөлгөх, гараа зангидах зэрэг дохио зангаагаар хүчирхийлэгч ойрхон байгааг сануулж болох юм. Мөн тус төвөөс олон нийтэд хандаж гаргасан мэдээлэлдээ хохирогч тодорхой үгийг жишээ нь “Манай сүү дууссан” гэдэг үгийг хэлбэл, энэ нь уг хүнд тусламж дэмжлэг хэрэгтэй байгааг илэрхийлж байгаа гэх мэтчилэн ард иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх ажлуудыг зохион байгуулж байна.

Хоёр. Технологийн мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж. КОВИД-19 цар тахлын эрин үед бүх төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд утас болон интернетэд суурилсан үйлчилгээ голлох үүрэгтэй оролцдог болохыг харгалзан үзэж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид туслах аюулгүй технологийг бий болгох шаардлага чухал болох нь харагдаж байна.

- 1) **Өмгөөлөгч болон хохирогчдийн технологийн боловсрол:** Технологийн байгууллагууд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтран ажиллаж дижитал төхөөрөмжүүдийн талаарх мэдээллээр хангаж, хохирогчийн цахим орчинд аюулгүй байдлаа хангах боловсролыг дээшлүүлэх хэрэгцээтэй байна. Жишээлбэл, технологийн салбарынхан технологийн ахиц дэвшлийн талаарх мэдлэг олгох, түүнийг аюулгүй ашиглан гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэх тухай мэдээлэл олж авах сургалтыг зохион байгуулах, хохирогчдод зориулсан тусгай техник хэрэгслийг зохион бүтээж ашиглалтанд оруулах хэрэгцээ байна. Энэ төрлийн төхөөрөмж, үйлчилгээ нь дараах аюулгүй байдалд багтаасан байх ёстой.
 - 1) **Нууцлалын горим:** Интернет хөтчийн тохиргоог түүх хадгалахаас урьдчилан сэргийлэх, бусад төрлийн цахим хуудас, зураг, мэдээлэл цуглуулдаг арга, хэрэгслүүд компьютерт хадгалагдахаас урьдчилан сэргийлэх,
 - 2) **The Circle of 6 аппликэйшин**-ийг утсаа нээгээд хоёр удаа хурдан товшиход урьдчилан програмчлагдсан текст бүхий мессежийг, хаяг байршлийн талаарх мэдээлэл тусламж хэсэг бүлэг хүмүүс рүү явуулах боломжтой болдог. Мөн уг аппликэйшин нь ярих шаардлагатай хүнийхээ дуудлагыг тасалдуулан залгахыг хүссэн текст илгээдэг үйлдлийн системтэй,
 - 3) **The One Love аппликэйшин** нь аюул зэргийг үнэлдэг асуулга бүхий үнэлгээний систем бөгөөд хүчирхийлэлд өртөж байгаа эсэхээ энэхүү асуулгуудад хариулаад мэдэж болох юм. Хэрвээ асуулгын хариулт нь “Тиймээ энэ бол хүчирхийлэл” гэж гарсан бол хүчирхийлэлд өртөж байгааг заадаг. Энэ аппликэйшинийг хохирогчид, амьд үлдэгсэд, болон тэдгээрийн найз, гэр бүлийнхэн нь ашиглахад тустай.
 - 4) **Тоглоом бүхий аппликэйшинд байрлуулсан чат:** Хохирогч туслалцаа эрэлхийлэхдээ мессеж бус тоглоомонд дотор чаталж, аюулгүйн төлөвлөгөөг найз болон гэр бүлийнхэнтэйгээ хэлэлцэж болох юм. Зарим хүчирхийлэгчид утасны мессеж шалгадаг ч тоглоомыг анхаардаггүй байдалд суурилжээ.

- 5) **Gruveo үйлчилгээ:** Авсрали улсын Викториа хотын зарим байгууллагууд вэбэд суурилсан видео чат үйлчилгээ болох Gruveo гэх мэт үйлчилгээг ашиглан хөл хорионы үеэр хохирогчидтой холбогддог. Энэ төрлийн дижитал харилцааны хэлбэр нь ямар нэгэн программ хангамж, аппликэйшин татаж авах шаардлагагүйгээрээ онцлог.

2. Шинэ дижитал тусламжийн хэрэгсэл: цар тахалын хөл хорионы үеэр улс орнууд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа эмэгтэйчүүдэд туслах зорилготой олон төрлийн арга хэмжээг санаачлан зохион байгуулж, янз бүрийн төслүүдийг хэрэгжүүлж байна. Эдгээр санаачлагууд нь уламжлалт албан болон албан бус дэмжлэгийг авч чадахгүй байгаа үед туслах бөгөөд хямралын дараа ч ашиг тустай байх юм. Тухайлбал, “Shielded website” буюу “Бамбар Вэбсайт” төслийг Шинэ Зеландын эмэгтэйчүүдийн дүрвэгсэдийн дараа загварчлан бий болгосон байна. Энэхүү вэбсайт нь доод хэсэгтээ тодорхой тэмдэглэгээ, дүрс бүхий жижиг зураг байрлах бөгөөд дарах төдийд тухайн хуудсанд тухайн цонхыг орхихгүйгээр мэдээлэл дамжуулдаг. Энэ мэдээлэлд шууд чатлах сонголт болон бусад дэмжлэгийн төрлүүд, аюулгүйн төлөвлөгөө, мэргэжлийн байгууллагуудыг залгах, и-мэйлээр холбогдохыг хүссэн хүсэлтийн төрлүүд гарч ирдэг байна. Энэ төрлийн вэбүүдийг их сургуулиуд болон бизнесийн байгууллагын вэбүүдэд байршуулсан байдаг. Модаль цонх ашиглах нь хөтөчийн түүхэнд зөвхөн үндсэн вэбсайт гарч ирнэ гэсэн үг бөгөөд ингэснээр интернетийн хэрэглээг хянаж байгаа хүчирхийлэгчид тухайн боловсролын эсвэл бизнесийн байгууллагын цонхноос өөр зүйл олж харахгүй юм.

Америкийн зарим мужуудад Массачусетсийн Технологийн Дээд Сургууль, UC Davis хуулийн сургуулиудын оюутнууд өөрсдийн зохион бүтээсэн дижитал хэрэгслүүдээ тухайн муждаа ашиглаж байна. Жишээлбэл, Snapchat нь тун удахгүй хохирогчидод зориулсан үйлчилгээ санал болгохоор ажиллаж байгаа. Энэ тохиолдолд хүмүүс тухайн агуулгыг чимээгүй, аюулгүйгээр үзэх боломжийг нээж өгөх болно.

Ийнхүү хүчирхийллийг бууруулах чиглэлээр ажилладаг хувь хүмүүс, албан байгууллагууд хохирогчидтой харилцах, тэдэнд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ хохирогчдын аюулгүй байдлыг хангахад технологийн дэвшлийг нэвтрүүлэх, ашиглах нь тэдгээрийн ажлыг хөнгөвчлөх, зардлыг бууруулах гэх мэт чухал ач холбогдолтой юм.

3. “quick-escape” хурдан зугтах товчлуур: Хүчирхийлэгч, хохирогчийн цахим хэрэгсэлд хяналт тавьж байгаа тохиолдолд эрсдэлд оруулж болзошгүй агуулгатай цахим хаягаас аль болох хурдан гарах шаардлагатай тохиолдолд “quick-escape” буюу “Хурдан-зугт” товчлуурыг ашиглах боломжтой. Хүмүүст аюулгүй, хууль ёсны үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлдэг энэхүү технилогийг 2019 онд технологич Гу зохиосон юм. Түүний зохиосон “хурдан зугтах” товчлуурын зураг төслийг боловсруулах зөвлөмжид тухайн товчлуурыг сайтын хаана ч, хэзээ ч ашиглах боломжтой гэдгийг онцолсон байна. Хурдан зугтах товчлуур нь тогтмол нүднээ ил, дарахад ойр байх ёстой бөгөөд товчлуурыг дарснаар одоогийн вэбсайтыг хааж, шинэ вэбсайт нээх боломжтой бөгөөд тухайн хүчирхийлэгчийн сэжиг төрүүлэхгүй байх энгийн сайтууд байх юм. Тухайлбал Google –ийн зураг хайлтын системээс тодорхой амьтныг хайж олж хайж байгаа дүр зураглал харагдана.

Гурав. Хэвлэл мэдээллийн байгууллагын тусламж: Хэвлэл, мэдээлийн хэрэгсэл нь хүмүүсийн ямар асуудлуудын талаар бодох, өөрдсийгээ хэрхэн мэдрэхэд нь хүчтэй нөлөөлдөг бөгөөд хэвлэл мэдээллээр нэвтрүүлж байгаа зүйлийг хохирогч, хүчирхийлэгч аль аль нь үздэг учраас тэдний мэдлэг ухамсрыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэр бүлийн хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах талаар хөл хорионы дэглэм тогтоосон үеийн онцлог байдалтай уялдуулан стратеги

төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, албан ба албан бус тусламж дэмжлэгийн талаарх мэдээллийг нийтэд тасралтгүй түгээх хэрэгтэй байна.

Хүснэгт 2.16. Хүснэгтээр олон улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагуудын зорилтот бүлгүүдэд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ:

№	Хэн	Олон нийтэд	Гэр бүлийн хохирогчдод	Хүчирхийлэгчийг хянах
1	<p>Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг ажилладаг олон нийтийн байгууллага, ажилтнууд /Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа, туршлага солилцох/</p>	<ul style="list-style-type: none"> • Хүчирхийлэлт зан үйл, уламжлал, соёлыг өөрчлөх • Гэр бүлийн хүчирхийллийг таних арга хэлбэрүүдийн талаар олон нийтийг мэдлэгтэй болгох • Хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудад хандсан мэдлэг олгох • Олон нийтийг хүчирхийллийн хохирогчдоос үзүүлэх үг, хэллэг, биеийн хэлэмжийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээх • Хүчирхийллийн эсрэг ажилладаг байгууллагуудын мэдээллийг байнга шинэчлэн түгээх • Албан ба албан бус дэмжлэг үзүүлэх хувь хүн, албан байгууллагуудын мэдээллийг нийтэд таниулах 	<ul style="list-style-type: none"> • Хүчирхийлэл гэж юу болох, түүнийг таних талаар мэдлэг олгох • Хүчирхийлэлд өртсөн үед авах арга хэмжээний протокол, зөвлөмжүүдийг цаг үеийн нөхцөл байдалд тохируулан шинэчилж байх • Нөхцөл байдлын талаарх үнэн, зөв мэдээллээр тогтмол хангах • Хохирогчтой холбогдоход хялбар шууд утас, олон нийтийн платформуудыг бэлэн байлгах, тэдгээрийн ард мэргэжлийн туслалцаа үзүүлж чадах сэтгэл зүйч, эмч зэрэг мэргэжлийн хүмүүсийг ажиллуулах • Туслалцаа авахад шаардлагатай техник, технологийн орчин нөхцөл бүрдсэн эсэхийг үнэлэх • Тусламж дэмжлэг үзүүлэх байгууллагуудтай холбогдох аюулгүй арга, хэрэгслийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байх • Хүчирхийлэлд өртөж байгаагаа илэрхийлэх нууц үг, хэллэг, биеийн хэлэмжид сургах, ашиглахийг зөвлөх • хохирогчид туслалцаа үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Хохирогчид нууцаар үйлчилгээ үзүүлж байхдаа хүчирхийлэгч ойрхон байгаа эсэхийг таних арга, тусгай дохиог хөгжүүлэх • Хүчирхийлэгч ямар нэгэн буруу, ташаа мэдээллийг ашиглан хохирогчийг хууран мэхлэж байгаа эсэхийг шалгах

			<p>аппликейшиныг ашиглах арга техникт сургах</p> <ul style="list-style-type: none"> Хамгийн ойрын үйлчилгээний байгууллагаар дамжуулан хүчирхийллийг мэдээллэх аргад сургах 	
2	<p>Хууль сахиулах байгууллага /Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага /ЕАБХАБ/, Олон улсын цагдаагийн дарга нарын холбоо (IACP) зэрэг байгууллагуудаас арга зүйн, зөвлөмж зэргийг авах /</p>	<ul style="list-style-type: none"> Хүчирхийллийн аль хэлбэр бүрт хариу арга хэмжээ авах Хохирогч болон олон нийтэд хүчирхийллийн гэмт хэрэг шийдвэрлэгддэг гэдэг итгэл найдварыг бий болгох Эрүүгийн шүүх тогтолцоонд итгэх итгэлийг бий болгох 	<ul style="list-style-type: none"> Хохирогчдын нөхцөл байдлыг зөвөөр үнэлэх Хохирогчийг хүчирхийлэгчээс тусгаарлан, нээлттэй ярилцах боломжийг бүрдүүлэх Хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн дуудлагын үед цагдаагийн алба хаагчийн авах арга хэмжээний протоколуудыг баримтлах Хохирогчид үйлчилдэг байгууллагуудын талаар мэдээлэлтэй байх, холбож өгөх 	<ul style="list-style-type: none"> Хүчирхийлэл үйлдсэн үйлдэл бүрт тохирсон хариуцлага тооцдог байх
3	<p>Технологийн компаниуд</p>		<ul style="list-style-type: none"> Хохирогчид албан бус мэдээллийг түгээх амар, хялбар аргуудыг бий болгох Нийгмийн сүлжээний платоформууд, түгээмэл байдаг боловсрол, бизнесийн байгууллагуудын вэб хуудсуудад мэдээлэл, линк, холбоос байршуулах нууцлалыг хангах 	<ul style="list-style-type: none"> Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл солилцож байгаа хохирогчийн төхөөрөмжийн нууцлалыг хангах Хохирогчид тусламж дэмжлэг үзүүлдэг байгууллагуудад хандсан мэдээлэл, цахим сүлжээний хуудсанд хандсан мессеж, чатын түүхийг хадгалахгүй, хүчирхийлэгчид харуулахгүй байх нөхцлийг бүрдүүлэх
4	<p>Хэвлэл мэдээллийн компаниуд</p>	<ul style="list-style-type: none"> Хүчирхийллийн эсрэг тэмцдэг байгууллагуудтай хамтран ажиллаж, зөв мэдээллээр иргэдийг тогтмол хангах 		

		<ul style="list-style-type: none"> • КОВИД-19 цар тахлын үеэр хүчирхийлэлт зан үйл, хандлага нь хувь хүний хувийн зан чанар, нийгмээс сурсан зан үйл, сэтгэцийн эмгэгийн гаралтай асуудал болохоос биш вирус өөрөө хүчирхийлэл үүсгээд байгаа хэрэг биш гэдгийг олон нийтэд тайлбарлаж, ойлгуулах
--	--	--


2.4.4 КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан хөл хорионы үеийн гэр бүлийн хүчирхийллийн эсрэг авч хэрэгжүүлсэн арга, замын талаар зарим улс орны туршлага

1. 2014 онд Их Британий засгийн газраас эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийг таслан зогсоох “Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” стратеги 2016-2017 (VAWG) гэх стандартыг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Лондон хотын Цагдаагийн газраас уг төслийн шинэчлэн (MOPAC) “Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн стратеги 2018-2021 гэдгийг боловсруулсан байна <https://www.london.gov.uk/mopac-publications/mayors-violence-against-women-and-girls-strategy-2018-2021>. Энэ стратеги нь урьдчилан сэргийлэлт, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулдаг байх, хохирогчдийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд цогц, нарийвчилсан зөвлөмжүүдийг гаргажээ.

Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхэд, залуучуудыг ирээдүйд хохирогч эсвэл хүчирхийлэгч болохоос урьдчилан сэргийлэх зорилго бүхий арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тухайлбал, 10 жилийн сургуулиудад охидуудад хүчирхийлэл, аюул заналхийллээс хэрхэн зугтаах, хөвгүүдэд охид, эмэгтэйчүүдтэй харилцахдаа юуг хийж болох, юуг хийж болохгүй вэ гэдгийг заааж өгөх ёстой гэдгийг зааж сургах үйл ажиллагаа зохион байгуулдаг байна. Түүнчилэн охид бүсгүйчүүд рүү шүгэлдэхээс авхуулаад биед нь халдах хүртэл “аюул заналхийлэл” учруулсан тохиолдол бүрийг орон нутгийн эрх бүхий байгууллагууд, цагдаа, аюулгүй хөршийн зөвлөл, хохирогчдыг хамгаалах байгууллагууд, хохирогчдод дэмжлэг үзүүлэх байгууллагууд, орон нутгийн эмэгтэйчүүдийн байгууллага зэрэгт мэдээллэж байх хэрэгтэй гэж зөвлөдөг байна. Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн этгээдэд оногдуулах шийтгэл, хуулийн хариу арга хэмжээ нь галт зэвсэг, хутга гэх мэт зэвсэг ашигласан гэмт хэрэгтэй адилхан шийдвэрлэгдэх ёстой гэж үзэж байгаа юм.

Англи улс нь цар тахлын үеийн онцлогт тохируулан гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах төсөл боловсруулан дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 2020 оны 11 дүгээр сард хотын захиргаанаас нэмэлт 3.7 сая фунтийг уг төсөлд хувиарлан төсвийг нэмэгдүүлснээс гадна бизнесийн болон сайн дурын байгууллагуудаас хандив тусламж орж ирсээр байна. Энэ оны онцлог хөл хориотой холбоотойгоор төслийн олон үйл ажиллагаа хумигдаж байгаа боловч, цахим хэрэгслүүдийг (Zoom) ашиглан зайнаас сургуулийн ажилтнууд, тусламжийн баг, нийгмийн ажилтнуудыг сургах уулзалт зохион байгуулах зэргээр маш завгүй ажилласаар байгаа юм.

Сургалтанд хамрагдсан мэргэжилтнүүд нь хүчирхийллийн асуудалтай гэр бүл, хохирогчтой ажиллахдаа илүү итгэлтэй болж, авч хэрэгжүүлэх арга замын талаар мэдлэгтэй маш сайн бэлтгэгдэж байгаа тухай ч тэмдэглэсэн байна. Энэ мэтчилэн дэлхийн олон улс орнууд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх стандарт, журмыг гаргаж түүнийг байнга засаж сайжруулж, алдаа дутагдлыг арилгахад тогтмол анхааралаа хандуулдаг байна.



2. Ковид-19 өвчний дэгдэлтээс болж **Киргизийн** хэд хэдэн хотод онц байдал тогтоосноор гэр бүлийн хүчирхийлэл бүртгэгдсэн тохиолдол 62% -иар өссөн. Үүнээс хохирогчдын 95% нь 21-50 насны эмэгтэйчүүд байжээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдал нь ялангуяа Бишкек хотод улам хурцдаж байв. Бишкек хотын комендантын газраас өгсөн мэдээллээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65% -иар өссөн ажээ. Шалтгаан нь хорио цээрийн дэглэмийн үед эмэгтэйчүүдэд гэр бүлийн хүчирхийллээс зайлсхийх нь улам бүр хэцүү болж, олон эмэгтэйчүүд цагдаа, тусламж үйлчилгээний байгууллага руу залгах боломж нь хумигджээ. Тагнуулын ерөнхий газрын мэдээллийн технологийн ерөнхий хэлтсээс ирүүлсэн мэдээллээр 2020 оны 1-р сараас 3-р сар хүртэл хууль сахиулах байгууллагууд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 2319 гомдол, мэдээллийг бүртгэсэн байна.

Тус улсад онцгой байдлын журам хэрэгжиж эхэлснээр улс орон даяар хямралын төвүүд элсэлтийг түр зогсоож, үйл ажиллагаагаа онлайн хэлбэрт шилжүүлсэн, и-мэйлээр болон Facebook, Instagram зэрэг нийгмийн мэдээллийн платформоор дамжуулан сэтгэлзүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өгч байна. Мөн утсаар гэр бүлийн хүчирхийлэлд нэрвэгдсэн хүмүүст анхны тусламж үзүүлдэг утасны шугамууд бүс нутаг бүрт ажилласаар байна. Одоогоор 111, 112, 117 дугаарын утсыг ажиллуулж байгаа бөгөөд энэ нь сэтгэлзүйч, өрхийн эмч нартай холбогддог байна. Хорио цээр тогтоосон нэг сарын хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсээс 700 орчим дуудлага ирсэн байна. Үүний зэрэгцээ, дөрөвдүгээр сард хүний эрхийг хамгаалагчдын "Хамтдаа" хөдөлгөөнөөс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалахын тулд яаралтай арга хэмжээ авахыг шаардсан уриалга гаргаж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зориулсан яаралтай үед туслалцаа авах стандарт тогтоосон протоколыг батлажээ.

Киргизийн парламентын (Жогорку Кенешийн) нэгэн депутат гэр бүлийн хүчирхийллийн хохирогч амь насанд нь аюул учирвал гэрээсээ гарахыг зөвшөөрсөн эрх зүйн акт боловсруулж, хүчирхийлэгчдийг 15 хоног захиргааны журмаар баривчлах арга хэмжээ авах санаачлага гаргасан байна. 2020 оны 5-р сарын эхээр Киргизийн парламент Киргиз улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг 48 цаг саатуулах эрх олгосон хэм хэмжээг хуульчилжээ.

2.3. Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага /ЕАБХАБ/.

Цагдаагийн байгууллагын үндсэн бөгөөд эрхэм зорилго нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах явдал юм. Үүний зэрэгцээ цагдаагийн алба хаагчид иргэдийн хувийн орон зайг хүндэтгэх ёстой бөгөөд хууль ёсны зөвшөөрөлгүйгээр хувийн орон сууцанд нэвтрэх боломжгүй. Энэ асуудал нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй

тэмцэхэд хүндрэл бэрхшээл болдог байна. Тиймээс цагдаагийн байгууллага цар тахлын үеэр ч түүний дараа ч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, үйлдэгдэж байгаа болон үйлдэгдэх гэж байгаа талаар мэдээлэх, хариу арга хэмжээ авах аюулгүй нөхцөл боломжийг бүрдүүлэх шинэ шийдлүүдийг бий болгох хэрэгтэй байна.

Цагдаагийн байгууллага хүчирхийллийн гэмт хэргийг мөрдөн шалгах аас гадна энэ төрлийн гэмт хэргийг урьдчилан сэргийлж, таслан зогсоох нь хамгийн чухал юм.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг Цагдаагийн байгууллага бусад байгууллага, иргэдийн дэмжлэг туслалцаанд тулгуурлахгүйгээр хийх боломжгүй юм. Иймд олон нийт, цагдаагийн байгууллагын хоорондох итгэлцэл, түншлэл, харилцан уялдаа холбоог бэхжүүлэх нь нэн чухал ач холбогдолтой. Мөн хохирогчдод (хүчирхийллийн бүр эхний үе шатанд) нөхцөл байдлын талаар мэдээлэх аюулгүй арга, нөхцөлүүдийг бүрдүүлсэн байх ёстой. Зарим гишүүн улс орнуудад хүчирхийллийн хохирогчдийг мэдээллийг өгөх аюулгүй хэд хэдэнд арга, хэрэгслийг нэвтрүүлсэн байна. Үүнд дуудлагын түүхгүй шууд утас, онлайнаар мэдээлэх, худалдааны төв эсвэл эмийн санд байрлуулсан холбоо барих цэгүүд, олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх компанит ажлууд зэрэг багтаж байна.

Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага /ЕАБХАБ/ нь шаардлагатай байгаа бүх талуудад мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг. Энэхүү бэрхшээлтэй асуудлын чиглэлээр Үндэстэн дамнасан аюул заналын газрын Цагдаагийн Стратегийн асуудал эрхэлсэн хэлтэсээс өргөн цар хүрээтэй туршлага, мэдээлэл, мэдлэгийг хуримтлуулсан байдаг. ЕАБХАБ нь гишүүн орнуудад ба хамтран ажилладаг түншүүддээ хууль сахиулах болон шүүхийн байгууллагад хүрэх мэдээллийн компанит ажлаас авхуулаад мэдээлэл цуглуулах, тайлагнах арга хэрэгслийн талаарх гарц, гаргалгааг санал болгож, шийдвэрлэх арга замыг бий болгодог.

Саяхан Жендерийн асуудал эрхэлсэн хамтран ажиллагчид ЕАБХАБ-ын даргатай хамтран зохион байгуулсан Вебинар цахим хуралд засгийн газар, олон улсын байгууллагууд болон төрийн бус байгууллагуудаас олон тооны хүмүүс оролцжээ. Энэ хурлаар гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлдэг хувь хүн, албан байгууллагуудын үр нөлөөг дээшлүүлэхэд харилцан мэдээлэл, туршлага солилцлох хэрэгцээ байгааг онцолсон байна.

Дэлхийн олон улс орнууд болон олон улсын байгууллагууд КОВИД-19 цар тахлын өмнөх үеийг хүртэл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга хэлбэрээ үргэлж анхаарч, түүнийг бууруулахад чиглэсэн стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн ч КОВИД-19 цар тахлын үеийн хөл хорио тогтоосонтой холбоотойгоор дэлхий даяар хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил эрс нэмэгдсэн нь гадаад улс орнуудад болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудад томоохон сорилт болж байна. Үүнтэй холбоотойгоор олон улс орны төр засгийн болон мэргэжлийн байгууллагуудын зүгээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх, хариу арга хэмжээ авах арга хэлбэрээ өөрчлөх, хүчин чадал, төсөв хөрөнгөө нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээг авч ажиллаж байна. Хөл хорионы үеийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны онцлог нь туслалцаа үзүүлэх байгууллага, албан ажилтнууд болон хамгаалах байрууд зарим тохиолдолд ажиллах боломжгүй, ажилласан ч халдвар хамгааллын аюулгүй байдлыг хангах үүднээс үйлчлэх хүний тоог эрс багасгагсан, аюулгүй тусгаарлах байрны хүрэлцээ муу зэрэг нь хүндрэл учруулж байна. Энэ нь мэргэжлийн байгууллагуудад шинэ сорилт болж байгаа бөгөөд хохирогчдийг аюулгүй арга хэрэгслээр туслалцаа авах боломж, нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах шаардлага үүсч байна.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ.
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АНХААРАХ АСУУДАЛ**

§ 3.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нөхцөл байдал

Гэр бүлийн хүчирхийлэл нь далд үйлдэхийн зэрэгцээ, давтагдан даамжирдаг, үр дагавар нь улам ноцтой хэлбэрт шилждэг өвөрмөц шинж бүхий гэмт хэрэг юм. Гэр бүлийн хүчирхийлэл нь газар зүйн байршил, соёл иргэншил, шашин шүтлэг, нийгэм, эдийн засгийн байдлаас үл хамааран нийгмийн бүхий л давхрага, хүрээг хамарсан хүний жам ёсны эрхийг хамгийн ноцтой зөрчиж байгаа үзэгдлийн хэмжээнд хүрээд байна.

Монгол улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар гэр бүл хүчирхийлэлд өртсөн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байр 16, нэг цэгийн үйлчилгээний 18 төв үйл ажиллагаа явуулж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд 486 хохирогчид үйлчилгээ үзүүлж, 51 эмэгтэй, 435 хүүхдийн аюулгүй байдлыг хангажээ.¹

Цагдаагийн байгууллага 2011 оноос гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэргийн статистикийг тусгайлан бүртгэж эхэлсэн юм. 2019 оны байдлаар Цагдаагийн байгууллагад **31524** гэмт хэрэг бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг **985** бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 85 хэргээр буюу 7.9 % -иар буурч, бүх хэрэгт эзлэх хувийн жин **3.0** хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгжээр буурсан байна.

Улсын хэмжээнд 2020 оны эхний 11 сард 22506 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7505 хэргээр буюу 25.0 хувиар буурч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг **1044** бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 74 хэргээр буюу 7.6 хувиар өсч, бүх хэрэгт эзлэх хувийн жин 4.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.4 нэгжээр өссөн үзүүлэлтэй байна.

График 3.1. Монгол Улсын хэмжээнд 2018, 2019, 2020 онуудад бүртгэгдсэн нийт гэмт хэргээс “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”, “гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг”, тэдгээрийн улмаас хохирсон хүнийг харуулав.

Д/д	Дүн	2018	2019	2020 оны эхний 11 сарын байдлаар
1	Улсын хэмжээнд нийт бүртгэсэн гэмт хэрэг	36220	31524	22506
2	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг ²	210	207	100
3	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг ³	1070	985	1044
4	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүн	796	894	988

¹ Гэр бүл хүүхэд залуучуудын газраас гаргасан статистик мэдээлэл

²

http://information.police.gov.mn/resource/information/File/2020/12/04/8nqjonzvucu9v2zq1/gemt%20hereg.pdf?fbclid=IwAR3I6c12cAnWMy4dcDHmby2ICGcQM4yr4_sPvatlauF7lltZ-tCnmH006HU

³

<http://information.police.gov.mn/resource/information/File/2020/12/04/bhkgam02ig3oxqm5/2020.11%20sar%20Baidal.pdf?fbclid=IwAR25UcDvRlw2zjHHIJ3uhSU5jWLeoJedoBJjN7WoXelj4Ytk7eHraXjOr5s>


Дээрх тоо баримтыг дүгнэн үзвэл, 2020 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг буурсан, харин гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн гэмт хэрэг өсөх хандлагатай байна. Эндээс харахад цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэрэгт ямар гэмт хэргүүд хамрагдаж байгаа тухай бүртгэлээ эргэн харж, бодитой бүртгэхэд анхаарах шаардлага байна.

2020 оны эхний 11 сарын байдлаар:

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас бүртгэсэн хэргийг Эрүүгийн хуульд заасан бүлгээр авч үзвэл:


Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт ГБХ-ийн хэрэгт эзлэх хувь
	2019.XI	2020.XI		
Хүний амьд явах эрхийн эсрэг	12	21	75.0	2.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	908	959	5.6	91.9
Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	280	100	-64.3	9.6
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	47	53	12.8	5.1
Үүнээс: Хүчиндэх	47	43	-8.5	4.1
Үүнээс: Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	1	1	0.0	0.1
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	2	2	0.0	0.2
Бусад	1	9	9.0 дах	0.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гараг, цаг, газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 34 буюу 21.8, мягмар гарагт 6 буюу 3.8, лхагва гарагт 2 буюу 1.5, пүрэв гарагт 16 буюу 10.3, баасан гарагт 7 буюу 4.6, бямба гарагт 1 буюу 0.8, ням гарагт 8 буюу 4.8 хувиар тус тус өссөн байна.


Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд 13 буюу 7.9, 14-19 цагийн хооронд 34 буюу 13.1, 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 48 буюу 12.2 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 21 буюу 9.4 хувиар буурсан байна.



Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 55 буюу 9.9, гудамж талбайд 12 буюу 16.9, бусад газарт 7 буюу 12.7 хувиар, аж ахуйн нэгжид 6 буюу 3.0 дахин өсч, олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 10 буюу 35.7 хувиар буурч, нийтийн тээвэрт 2, төрийн байгууллагад 4 тус тус бүртгэгдсэн байна.


2020 оны эхний 11 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн улмаас **22292** иргэн өртөж хохирсноос гэр бүлийн хүчирхийллийн улмаас **988** иргэн хохирсон, үүнээс 886 буюу 89.6 хувь нь эмэгтэй, 87 буюу 8.8 хувь нь хүүхэд эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өртөж хохирсон эмэгтэй хүний тоо 52 буюу 6.2 хувиар, хохирсон иргэн 70 буюу 7.6 хувиар, хүүхэд 62 буюу 40.3 хувиар тус тус өсчээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн нас, хүйс, нийгмийн байдлаар авч үзвэл:



Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 522, хамтран амьдрагч 215, нөхөр 40, төрсөн хүүхэд 39, дагавар хүүхэд 35, төрсөн эцэг, эх 21, төрсөн ах, эгч 6, төрсөн дүү 6, хадам эцэг, эх 7, өвөг эцэг, эмэг эх 2, үрчилж авсан хүүхэд 1, бусад 94 хүн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчид




Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас **16 хүн нас барж, 874 хүн гэмтэж, иргэдэд 796.9 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол** учирсан нь өмнөх оны

мөн үетэй харьцуулбал нас барсан хүн 9 буюу 2.3 дахин, гэмтсэн хүн 170 буюу 24.1, учирсан хохирол 203.2 сая буюу 32.2 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн бүх гэмт хэрэгт 15450 хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсаны **1037** буюу 6.7 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний учир холбогдон шалгагдсаны 679 буюу 65.5 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлджээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал холбогдон шалгагдсан хүн 109 буюу 11.7 хувиар өссөн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд холбогдогчдыг нас, хүйс, нийгмийн байдал, боловсролоор нь ангилж үзвэл:



Боловсрол:

Боловсролын түвшин	Тоо		Өсөлт, бууралтын хувь	Эзлэх хувь
	2019.XI	2020.XI		
Боловсролгүй	49	54	10.2	5.2
Бага	97	78	-19.6	7.5
Суурь	182	179	-1.6	17.3
Бүрэн дунд	418	495	18.4	47.7
Тусгай мэргэжлийн дунд	34	36	5.9	3.5
Дээд	148	195	31.8	18.8

Нийгмийн байдал:

Нийгмийн байдал	Тоо		Өсөлт, бууралтын хувь	Эзлэх хувь
	2019.XI	2020.XI		
Оюутан	4	5	25.0	0.5
Сурагч	0	3		0.3
Төрийн бус байгууллагын ажилтан	22	17	-22.7	1.6
Төрийн албан хаагч	39	45	15.4	4.3
Хувийн хэвшлийн байгууллагын ажилтан	83	98	18.1	9.5
Малчин	112	130	16.1	12.5
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	206	261	26.7	25.2
Ажилгүй	460	478	3.9	46.1
Хоригдол	1			
Тэнэмэл	1			


Зөрчлийн шийдвэрлэлт: Цагдаагийн байгууллагад 2020 оны эхний 11 сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас **9786** зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1557 буюу 18.9 хувиар, 7882 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2153 буюу 37.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн зөрчлийн тоо





Гэр бүлийн хүчирхийллийн улмаас бүртгэгдсэн зөрчлийн хуульд заасан зүйлээр авч үзвэл:

5.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн заалт	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралт		Нийт ГБХ-ийн зөрчилд эзлэх хувь
	2019.XI	2020.XI	Тоо	Хувь	
5.4.1.	134	110	-24	-17.9	1.1
5.4.2	6	2	-4	-66.7	
5.4.3	1	1	0	0.0	0.1
5.4.4.	8088	9673	1585	19.6	98.8
5.4.4.1	5515	7474	1959	35.5	77.3
5.4.4.2	2326	1836	-490	-21.1	19.0
5.4.4.3	31	33	2	6.5	0.3
5.4.4.4	213	330	117	54.9	3.4



Зөрчил гаргасан 311 иргэнийг 40920.0 мянган төгрөгөөр торгох, 7571 хүнийг баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс иргэнийг торгосон шийтгэл 105 буюу 51.0 хувь, баривчилсан шийтгэл 2034 буюу 36.9 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн зөрчлийн үйлдэгдсэн гараг, цаг:





Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн 9020 буюу 92.2 хувь нь гэр орон сууцанд, 322 буюу 3.3 гудамж талбайд, 281 буюу 2.6 хувь нь бусад газарт, 109 буюу 1.2 хувь нь олон нийтийн газарт, 38 буюу 0.4 хувийг аж ахуйн нэгжид, 9 буюу 0.1 хувийг

төрийн байгууллагад, 2 буюу 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 5 буюу 0.1 хувь нь төрийн бус байгууллагад тус тус бүртгэгджээ.

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчилд **7882** иргэн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2153 буюу 37.6 хувиар өссөн байна.

Тэдний 7632 буюу 96.8 хувь эрэгтэй, 250 буюу 3.2 хувь нь эмэгтэй хүн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн насны ангилал



4430 буюу 56.2 хувь нь нөхөр, 1421 буюу 18.0 хувь нь хамтран амьдрагч, 305 буюу 3.9 хувь нь төрсөн эцэг, 130 буюу 1.6 хувь нь төрсөн ах, 89 буюу 1.1 хувь нь хойд эцэг, 31 буюу 0.3 хувь нь төрөл садангийн хүн, 8 буюу 0.1 хувь нь хүргэн ах, 15 буюу 0.2 хувь нь төрсөн эгч, хойд эх, хүргэн дүү, 1453 буюу 18.6 хувь нь бусад хүн байна.

2.4 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчилд 6764 иргэн өртөж, хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2024 буюу 42.7

хувиар өссөн байна.

Тэдний 542 буюу 8.0 хувь эрэгтэй, 6222 буюу 92.0 хувь нь эмэгтэй хүн байна.

2019 онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт **30782** иргэн өртөж хохирсноос гэр бүлийн хүчирхийлэлд **894** иргэн өртөж хохирсны 803 буюу 89.8 хувь нь эмэгтэй хүн, 62 буюу 7.7 хувь нь хүүхэд байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 484, хамтран амьдрагч 169, нөхөр 44, төрсөн хүүхэд 36, төрсөн ах, эгч 9, дагавар хүүхэд 27, төрсөн эцэг, эх 37, төрсөн дүү 10, хадам эцэг, эх 9, Үрчилж авсан хүүхэд 2, Өвөг эцэг, эмэг эх 1, бусад 66 хүн байна. **Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 732 хүн гэмтэж, иргэдэд 599.7 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан байна.**

Статистикийн мэдээнээс харахад хохирсон иргэдийн тоо өссөөр байх гэр бүлийн хүчирхийллийн хохирогч дийлэнхидээ эмэгтэйчүүд болон бага насны хүүхдүүд өртсөн байгаа нь доорх хүснэгтээс тодорхой харагдана.

Хүснэгт 3.2. Хохирсон иргэдийг дараах байдлаар ангилан харуулав.

Д/д	он	Эхнэр	Нөхөр	Хамтран амьдрагч	Өвөг эцэг, эмэг эх	Төрсөн эцэг, эх	Хадам эцэг эх	Төрсөн ах, эгч	Төрсөн дүү	Төрсөн хүүхэд	Үрчилсэн хүүхэд	Дагавар хүүхэд	бусад
1	2018	401	62	177	1	19	5	3	5	28	1	18	78
2	2019	484	44	169	1	37	9	9	10	36	2	27	66
3	2020	522	40	215	2	21	7	6	6	39	1	35	94

Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр:





График 3.3. Сүүлийн 3 жилийн хугацаанд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн хэлбэрээр нь авч үзвэл ихэвчлэн бие махбодын хүчирхийлэл үйлддэг байна.



Иргэд төдийгүй гэр бүлийн хүчирхийлэл нь ихэвчлэн далд хэлбэртэй байдгаас хариу арга хэмжээ авахад бэрхшээлтэй тулгардаг. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж

буй эмэгтэйчүүдийн 40 хүрэхгүй хувь нь аливаа төрлийн байгууллага, иргэдээс тусламж хүсдэг бол, 10 хүрэхгүй хувь нь цагдаагийн байгууллагад дуудлага, мэдээлэл өгдөг байна.

Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, түүнтэй холбоотойгоор үйлдэхбусад гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд огцом өссөн /2020 оны байдлаар/ байх ба мөрдөн шалгах ажиллагааны хувьд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тухай гомдол мэдээллийн ихэнхи хувийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, зөрчлийн шинжгүй үндэслэлээр хааж байгаа нь дахин гэмт хэрэг үйлдэх өөрөөр хэлбэл, гэмт явдал даамжрах нөхцлийг бүрдүүлж байна. Энэ байдалтай холбоотойгоор гэмт хэрэг, зөрчлийн нотлох баримт устаж үгүй болох, хохирогч мэдүүлгээсээ буцах, ятгалгад өртөх, хохирогчийн амь нас, эрүүл мэндээрээ хохирох аюул тулгарч байна.

Гэмт хэрэг үйлдэгч нь хохирогчийг цагдаагийн байгууллагад мэдээлсэнтэй холбогдуулан дарамтлах, заналхийлэх, айлгаж сүрдүүлснээр хохирогч дахин цагдаагийн байгууллагад хандахаас айх, мэдүүлгээсээ буцах, худал мэдүүлэг өгөх зэрэг асуудал гарсаар байна.

2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахал дэгдсэн энэ цаг үед олон нийтийн дунд бухимдал стресс ихсэж байгаатай холбоотой гэр бүлийн хүчирхийлэл өсөх зүй тогтолтой гэдгийг гаднын судлаачид судлан тогтоожээ. Учир нь цар тахлын улмаас олон хүн ажилгүйдэлд өртөж, мөн хөл хорионы дэглэм хэрэгжиж байгаагаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогч хамт тусгаарлагдсанаар хохирогчийн хувьд тусламж дэмжлэг авах, хүсэх боломж хязгаарлагдаж байгаа нь нэн тулгамдсан асуудал болоод байгаа юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үндсэн суурь шалтгааныг нийгэм даяар архидалт, ажилгүйдэл, ядууралтай холбож хардаг. Тэгвэл эдгээр шалтгааныг арилгах замаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг таслан зогсоохын тулд согтууруулах ундаа борлуулахыг хориглох, гэр бүл салалт, гэр бүлээс гадуур харилцааг эрх зүйн зохицуулалтаар хамгаалах, өрхийн эдийн засгийг төр засгаас шууд дэмжлэг үзүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Учир нь эдгээр асуудал нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан биш, харин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй хүчин зүйл юм.

Хүчирхийллийн гэмт хэргийн 60-70 хувь нь согтуугаар үйлдэгддэг. Архинд донтолт гэдэг олон улсын ангиллаараа F10 гэж оношлогддог нэг төрлийн өвчин юм. Өвчнийг нь эмчлэхгүйгээр баривчлах, хорих зэрэг ял шийтгэл оногдуулах нь хүчирхийллийн гэмт хэргийг бууруулахад нөлөө үзүүлэхгүй байна. 1993 онд “ЖИ-СИ–ЭС” олон улсын байгууллагын оролцоотойгоор Монгол Улсад архинд донтох өвчнийг эмчлэх “Минесота загвар эмчилгээ” буюу “Архинаас гаргах 12 шатлал” эмчилгээг нэвтрүүлж эхэлжээ. Бүлгийн сэтгэл засал эмчилгээний хэлбэрээр зохион байгуулагддаг хордлого тайлах, сэтгэл засах, нийгэмшүүлэх цогц үйлчилгээтэй сэтгэл зүйн эмчилгээний арга нь манай оронд ихээхэн үр дүнтэй болох нь нэгэнт батлагдсан юм.

Иймд баг, хороо хариуцсан хэсгийн мөрдөгчид хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа архинаас хамааралтай хүний судалгаа гарган, тухайн хүний архины эмгэгийн түвшинг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож албан журмаар эмийн болон сэтгэл зүйн эмчилгээ арга хэмжээ авах тухай заалтыг Зөрчлийн тухай хуульд оруулах шаардлагатай.

Хувь хүний төлөвшил, хүмүүжил, нийгэмшил, соёл, ёс суртахуун, зан ааш, дадал зуршил, үзэл хандлагын 70% нь төрөлх гэр бүлийн орчиндоо бүрэлдэн боловсордог гэсэн судалгаа байдаг бөгөөд хүний хөгжлийн анхдагч хамгийн чухал орчин бол гэр бүл юм. Гэр бүлийн харилцаа нь хүүхдийн төлөвшил, хүний хөгжлийн үндэс төдийгүй цаашлаад улс үндэстний аюулгүй байдал, ураг удмын үнэт зүйл, улс нийгмийн харилцааны суурь болдог.

Хүнийг хайрлан хүндлэх, энэрэх хүлээн зөвшөөрөх, ойлгон уучлах, асран халамжлах, итгэн туслах зэргээр хүнийг “хүн” болгож хүмүүжүүлдэг, нийгмийг соён гэгээрүүлэхэд гэр бүлийн үүргийг үнэлээд ч баршгүй.

Эрдэмтдийн гаргасан тоо баримтаас үзэхэд хүний оюуны чадварын 50 хувь нь 0-4 нас, 30 хувь нь 5-8 нас, үлдсэн 20 хувь нь 9-18 насанд суусан байдаг гэж үзсэн байна. Хүчирхийлэгчийн хажууд өссөн хүүхдийн хүмүүжил эцэг, эхийг даган дуурай инстинктээрээ хүнийг хайрлах, энэрэх сэтгэлгүй болгодог байна.

График 3.4.



Иймээс гэр бүлийн хүчирхийллийн гол шалтгаан нөхцлийг хувь хүний хүмүүжил, зан чанарын төлөвшил, гэр бүлийн төлөвлөлт зэрэгтэй холбож үзэх нь зүйтэй юм.

Хувь хүний хүмүүжил, зан төлөвт нөлөөлөхгүйгээр гэр бүлийн хүчирхийлэл болон хохирогч хүчирхийллийг тэвчдэг, дуугүй өнгөрөөдөг байдал ч буурахгүй. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж өссөн хүүхэд гэр орноосоо дайжих, сургууль соёлоос завсардах, хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэн амьдардаг гэсэн ойлголт авч ёс зүйгүй, дээрэнгүй, хүнийг өрөвдөн хайрлан нинжин сэтгэлгүй хүн болон төлөвших, гэмт хэрэг, зөрчилд уруу татагдах, аливаа асуудлыг хүчирхийллийн аргаар шийдэх буюу хүчирхийлэгч болох үндэс нь тавигддаг.

Хүүхэд даган дуурайх байдлаар гэр бүлийн хүмүүжлээс төлөвшил нь тогтдог онцлогтой бөгөөд зөвхөн гэр бүлийн орчинд зөв хүмүүжил олох, зөв хүн болж төлөвших үндэс суурь нь тавигддаг учир бүх нийтэд гэр бүлийн харилцааны боловсрол олгох, хүүхдэд цэцэрлэг, сургуулиас нь гэр бүлийн харилцааны соёл, ёс зүй, уламжлал зэргийг заан сургах үйл ажиллагааг тасралтгүй явуулах шаардлага өнөө цагийн нэн тэргүүний тулгамдса асуудал болж байгааг хаа хаанаа ойлгох шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар 10 жилийн сургууль бүрт сэтгэл зүйч ажиллах нөхцөл нь бүрдсэн сайн талтай. Сургуулийн орчинд хүүхдийн сэтгэл зүйч ажиллах нь хамгийн оновчтой шийдэл гэж үзэж байна. Учир нь хүчирхийлэлд өртсөн хүн, хүүхэд тэр бүр сэтгэл зүйчид хандах боломж, нөхцөл нь хомс. Сэтгэл зүйч мэргэжлийн үүднээс эсвэл ангийн багшийн санаачлага, эцэг эхийн хүсэлтээр хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажилласнаар хүүхэд сэтгэл зүйчид итгэн болсон асуудлын талаар ярилцаж чадсанаар хүүхэд шаардлагатай тусламж дэмжлэг авах, сэтгэл зүйн хэвийн байдалд эргэн орох давуу талтайн дээр боловсролын байгууллагын зүгээс холбогдох байгуулагад болсон үйл явдлыг мэдэгдэх, тэмжлэг тусламж хүсэх, нийгмийн үйлчилгээнд хамруулах зэрэг шат дараалсан арга хэмжээг цаг алдалгүй авах боломж нөхцөл нь бүрдэнэ.

Орчин цагт цахим орчноос бүхий л мэдээллийг авч болдог давуу талтай боловч сул тал бас байгаа гэдгийг бид бүгд мэдэж байгаа юм. Гэмт хэргийн талаар мэдээ, мэдээллийг цензургүй тавьснаар иргэд хууль, хяналтын байгууллагад итгэх итгэл, хандлага буурч нөгөөтэйгүүр энэ төрлийн гэмт хэрэг далд хэлбэрээр оршсоор байх болно.

Иймээс цахим орчинд гэр бүлийн харилцааны ёс заншил, ёс зүй, соёлын талаар эерэг мэдээлэл түгээх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирсон тохиолдолд хаана хэнд хандах /хаяг байршил, утас/, ямар тусламж дэмжлэг авч болох талаар зөвлөмж, мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр түгээх нь хүүхэд гэр бүлийн харилцааны зөв хандлага төлөвшүүлж, насанд хүрэгчдийн хувьд гэр бүлийн харилцааны болон түүнтэй холбоотой эрх зүйн мэдлэг олох боломж нээгдэнэ.

Гэхдээ дээрх ажиллагаа амжилттай болсон ч зөвлөмж мэдээллийн дагуу хандах байгууллага, албан тушаалтан иргэдийг ойлгож, зөв харьцдаг, хүмүүст чин сэтгэлээсээ хандан итгэл төрүүлж ойлголцож чадахгүй бол бидний зохион байгуулсан урьдчилан сэргийлэх ажил маань үр дүнгүй болох нь ойлгомжтой.

Нэгэн хүүхэд зөв хүмүүжвээс нэгэн өрх дэгжихэд тусаа өгч, нэгэн өрх дэгжвэл нэгэн аймаг, хот хөгжихөд дэм болж, нэгэн аймаг, хот хөгжвөл нийт улс мандахад хүч болох учиртай.

Тиймээс аливаа хүчирхийллийн золиос болон хохирсон иргэдтэй уулзан харилцах нийгмийн ажилтан, эмч сувилагч, багш сурган хүмүүжүүлэг, цагдаагийн ажилтан, сэтгэл зүйч хэн боловч хүнлэг, ажилдаа дуртай, ёс зүйтэй, харилцааны соёлтой, нууцыг хадгалах чадвартай, аливаа удирдан зохион байгуулах, гардан гүйцэтгэх чадвартай байх хэдий тэднийг хохирогчтой харилцах, хохирогчтой хамт хүндрэл бэрхшээлийг даван туулах арга барилд тусгайлан сургах шаардлагатай.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх шалтгааны нэг нь жендерийн тэгш бус байдал юм. Монголчуудын хувьд эрт цагаас эр хүнийг “гэрийн эзэн”, “өрхийн тэргүүн” гэж хүндлэн дээдэлдэг уламжлалтай, агуулга, мөн чанарын хувьд энэхүү хэлц нь хүнийг хүндлэх, үүрэг хариуцлагаа ухамсарлах хандлагыг төлөвшүүлэх эерэг утгатай ч, нөгөө талаасаа хүүхэд, эмэгтэйчүүдийг дорд үзэх сөрөг хандлагыг бий болгожээ.

Тиймээс гэрийн суурь хүмүүжил зөв олж төлөвшөөгүй иргэдийн хувьд сөрөг талаас нь ойлгож аливаад тэр ойлголт, тогтсон төлөвлөөрөө ханддаг байна.

Жендерт суурилсан хүчирхийллийн судалгааг манай орон бусад орнуудын нэгэн адил судалж эхэлсэн ба 2017 онд 21 аймгийн хүрээнд 7860 өрхийн 7319 эмэгтэйгээс ярилцлагын аргаар судалгаа хийсэн юм. Энэхүү судалгаанаас харахад нөхөртэй байсан болон нөхөрт гарсан эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (55.4 хувь) гэр бүлд нөхөр нь илүү шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх буюу “сайн эхнэр нөхөртэйгөө санал нийлэхгүй байсан ч үгийг нь дагадаг” байх гэсэн үзэл хандлагатай байна. Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагүй дөрвөн эмэгтэй тутмын нэг нь буюу 22.2 хувь нь хэрэв эхнэр нь үнэнч бус байвал нөхөр нь шийтгэж болно гэж үзсэн, хүчирхийлэлд өртөж байсан эмэгтэйчүүдийн 35.5 хувь нь мөн л хүлээн зөвшөөрсөн байхад эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь хүлээн зөвшөөрөхгүй гэж хариулсан байна.¹ Үүнээс харахад Монгол орны хувьд жендерийн дүр төрх өөрчлөгдөж байгаа нь харагдаж байна.

Манай орны хувьд гэр бүлийн боловсролоор хүүхдийн хүмүүжилд нөлөөлж чадваас гэр бүлийн хүчирхийллийг багасгах төдийгүй нийгмийг эрүүл болгоход нөлөөлөх том алхам болох юм.

⁴ Жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан 2017 он 16-р тал

Гадаадын ихэнх улс орнууд сургалтын системдээ дунд сургуулийн сурагчдад 4 үе шаттайгаар “Гэр бүлийн боловсрол” олгох хичээлийг “**ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХОЛБОО**”-ноос нь ордог байна. Үүнд:

1 үе шат: 7-11 насны хүүхдүүдэд хүмүүсийн хоорондын ялгаатай болон адил төстэй зүйлүүдийг ойлгуулах, ялгаж салгах, гэр бүл, найз нөхөдтэйгээ харилцах, өөрийгээ бусдад ойлгуулах, бусдыг ойлгох, хамгаалах аргуудыг тайлбарлах, гэр бүлдээ санаа тавих, туслах ёстойг мэдүүлж дадлага хийлгэдэг.

2 үе шат: 11-13 насны хүүхэд шилжилтийн насанд очих үед бие махбод болон сэтгэл зүйд ямар өөрчлөлт гардаг, эрүүл амьдрах аргыг сонгох, сэтгэл зүйн аюулгүй байдалд нөлөөлдөг хүчин зүйлүүдийн талаар мэдлэг олгодог.

3 үе шат: 14-16 насныханд хүнд дурлах, үерхэх болон өөрийн бодол сэтгэлээ бусдад нээх, харилцах аргыг зааж өгөх, сэтгэл зүйн хувьд ямар эерэг арга хэмжээ авч болохыг таньж мэдүүлнэ.

4 үе шат: 16-18 насны сурагчдын дунд “харилцаа,” сэтгэл хөдлөл”, “мэдрэмж” гэхчилэн тодорхой сэдвүүдээр ярилцлага зохион байгуулж гэрлэлт, эцэг эх болох, гэр бүлийн амьдрал, хүмүүсийн харилцаа, үүрэг хариуцлагын чухал чанарын талаар таньж мэдүүлдэг байна.

Гэр бүлийн судалгаа боловсролын үндэсний хүрээлэнгээс гаргасан Монгол Улс дахь гэр бүлийн боловсролын өнөөгийн байдлыг бусад улс орнуудтай харьцуулан хийсэн судалгаанаас харахад дараахь ялгааг харж болох юм. ³

Хүснэгт 3.1.

Гадаад улс орнуудын хувьд	Монгол Улсын хувьд
Гэр бүлийн олон талт үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс судлах ажил эрчимтэй хөгжиж нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн. Барууны орнуудад 1800 – гаад оны үеэс гэр бүлийн гол онолууд боловсрогдсон байдаг.	Манай улсад гэр бүлийн асуудалд шинжлэх ухаанчаар хандах эхлэл тавигдаад 10 орчим жил болж байна.
Гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагаа нь төрийн бодлогоор хэрэгждэг. Үе шат бүхий батлагдсан хөтөлбөр стандартаар суурь боловсролын нэг хэсэг болж хэлбэршиж тогтсон.	Суурь боловсролын агуулгад тусгайлсан хичээл болж ордоггүй. Зарим нэг хичээлийн агуулгад маш бага сэдэв багтсан байдаг нь энэ талаар хангалттай мэдлэг олгох хэмжээнд байдаггүй.
Нийгмийн тогтвортой байдал, хүний хөгжлийн суурь орчин нь гэр бүл гэж үздэг учир гэр бүлийн асуудал хариуцсан төрийн байгууллага тусдаа яамтай байдаг. Жишээ нь БНСУ: Гэр бүлийн яамтай.	Манай улс 2003 онд төрөөс гэр бүлийн талаар баримтлах бодлогыг батлан гаргасан ч түүнийг хэрэгжүүлэх механизм, тогтолцоо, арга зүйг шийдвэрлээгүй.
Суурь боловсролоос гадна гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудтай байдаг. Тэд нь сургалт зөвлөгөө явуулах албан ёсны зөвшөөрөлтэй, батлагдсан хөтөлбөрүүдтэй байдаг ба тодорхой чиглэлээр мэргэшсэн байх ба улсаас санхүүжилт авдаг.	Гэр бүлийн асуудлыг хариуцсан төрийн тогтолцоо байхгүй энэ чиглэлээр мэргэшсэн байгууллага цөөн бөгөөд төрөөс дэмжлэг байдаггүй.

Гэрлэлтэнд бэлтгэх хөтөлбөрүүд болон хосын харилцааг сайжруулах хөтөлбөрөөрөө дамжуулан гэр бүлд гарч буй сөрөг асуудлуудыг үр дүнтэй бууруулж чадаж байгаа.

Манай улсад энэ чиглэлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төрийн дэмжлэг байхгүй байгаа нь үр дүнтэй өргөн хүрээг хамарч чадахгүй байгаа ба мэргэшсэн байгууллагууд байхгүй байна.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийн талаар: Хохирогчдын ядуу, зүдүү амьдралтай нь холбоотойгоор ямар нэг шалтаг шалтгаангүйгээр байнга дарамтлах, амжиргаатай холбоотой буюу ажил хөдөлмөргүй, мөнгө төгрөгтэй холбоотой хэрүүл, маргаан, хардалт, бие биедээ үл итгэх, үл хүндлэх, үл ойлголцол зэргээс гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотой хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын ихэнх нь хүчирхийлэлд өртөж байгаа тухайгаа бусад этгээдэд мэдэгдэж байгаагүй, харин гэр бүлийн хүчирхийллийг даамжирсаны дараа цагдаагийн байгууллагад хандах явдал нийтлэг байна.

Хохирогчид хүчирхийлэл ийнхүү даамжирсаныг: Цагдаагийн байгууллагад хандсан иргэдийн хувьд, цагдаагийн байгууллага хүчирхийлэгчийг согтуу байвал эрүүлжүүлээд явуулдаг, эсвэл хэд хоног баривчлагдаад гэртээ буцаад ирдэг төдийгүй эрүүлжигдсэн болон торгуулийн мөнгийг хохирогч төлөх болдогтой холбоотойгоор хүчирхийллийг тэвчин амьдардаг гэсэн бол, зарим иргэдийн хувьд “ГЭР БҮЛИЙН НЭР ХҮНДИЙГ БОДОХ, ХҮҮХДҮҮДИЙНХЭЭ ЭЦЭГ НЬ ГЭЖ ХҮНДЭТГЭХИЙН ЗЭРЭГЦЭЭ ХҮҮХДЭЭ ӨНЧРҮҮЛЭХГҮЙ БАЙХ, ТЭЖЭЭГЧЭЭ АЛДАХААС АЙХ, ХҮЧИРХИЙЛЭГЧИЙГ УХААРАХ БАЙХ ГЭЖ ИТГЭХ” зэрэг шалтгааны улмаас цагдаагийн байгууллагад хандаагүй хэмээн шүүхийн болон мөрдөн байцаалтын шатанд мэдүүлжээ. Хохирогч ийнхүү гэр бүлийн хүний хүчирхийллийг “хэвийн үзэгдэл” мэт хүлээн авдаг хандлага нь хүчирхийлэл оршин байсаар байх нэг үндсэн шалтгаан болж үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хохирогчдын хувьд өөрийн нь гэх ах дүү муутай, эцэг, эх нь өндөр настай буюу өмгөөлөн хамгаалах чадваргүй, эдийн засгийн хувьд хүчирхийлэгчээс хараат /хохирогч эрхэлсэн тодорхой ажилгүй, цалин хөлсгүй буюу эдийн засгийн эрх чөлөөгүй/ өөрийн гэсэн орон байргүй зэрэг нь хүчирхийллийг тэвчин амьдрах гол хүчин зүйл болж байна.

Мөн хохирогчдийн бараг 90-д хувь нь шүүхийн шатанд гомдол, нэхэмжлэх зүйл байхгүй гэж мэдүүлсэн нь гэмт хэрэг үйлдэгчийн хэргийг хөнгөрүүлэх, хөнгөн шийтгэл оногдуулах нөхцөл болсон байна.

Ийнхүү нийгмийн тогтолцоо шинэчлэгдэн хэлбэршихэд хүмүүсийн аж төрөх арга ухаан, оюун санаа, ёс суртахуун, гэр бүлийн харилцааны өвөрмөц шинэ төрх бүрддэг бөгөөд энэ чанараараа гэр бүл нь нийгмийг бүрдүүлэгч анхдагч нэгж болохынхоо хувьд нийгмийн хувьсал, шинэчлэлийн үүр нь болж байдгийн¹ жишээ энэ байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-д заасан бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн зэрэг хүчирхийллийн аль нэгийг “байнга” үйлдсэн тохиолдолд дээрхи гэмт хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдэх тухай 2019.12.04-ний өдрийн УДШ-ийн 630 дугаар тогтоол гарсан.

Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл нь ямар тохиолдолд гэмт хэрэгт тооцохыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан” үйлдэл нь “**байнга**” буюу “байнгын

⁵А.Цэрэннадмид. Монгол гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэл//Монгол гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэлийн зарим асуудлууд. ЭШС-ны илтгэл өгүүлгүүд. 1998. х.19

шинжтэй” байхаар хуульчилсан нь тодорхой үйлдэл, эс үйлдэхүйн давтамжийг тодорхойлох эрүүгийн эрх зүйн онолын ойлголт бөгөөд харин тоон илэрхийллийн хувьд 3 ба түүнээс дээш удаа үйлдэгдсэн байхыг шаарддаг нь хууль хэрэглээний ойлголт юм.

Гэр бүлийн хамааралт байдлыг далимдуулан 3 ба түүнээс дээш удаагийн хуульд тоочин заасан бие даасан үйлдэл нь Эрүүгийн хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх шинжийг агуулах бөгөөд шүүхүүд ч УДШ-ийн дээрх тогтоолыг баримтлан хэргийг шийдвэрлэж байна.

Бодит байдлаас үзэхэд хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүд энэхүү байнгын шинжийг илэрхийлэх 3 ба түүнээс дээш удаа гэсэн тоог гүйцээхийн тулд зодуулах, харгис хэрцгий харьцаа, догшин авир, тарчлаасан үйлдлийг тэвчин тэсэхэд хялбар биш бөгөөд хор уршгийг урьдчилан таашгүй. Тиймээс эл хэм хэмжээг гэр бүлийн хүчирхийллийн “зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан” үйлдэл бүхий хэрэг дээр хэрэглэх нь хир зохимжтой талаар эргэн харууштай санагдана. Харин гэр бүлийн хамааралт байдлыг далимдуулан сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд “байнгын” шинжийг шаардах нь илүү зохимжтой гэж үзэж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж эхэлсэн цагаас хойш энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрөөс олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч гэмт хэрэг буурахгүй харин ч өссөн байна. Тухайлбал, 2015 онд хийсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн талаар хийсэн судалгаа, 2020 онд хийсэн судалгаатай харьцуулан үзэхэд гэмт хэргийн тоо өссөн, үйлдлий арга нь улам харгис хэрцгий шинжтэй болсон байна.

Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй эрх зүйн аргаар тэмцэх, гэр бүлийн боловсрол олгохоос гадна гол нь нийгэм, эдийн засгийн аргаар буюу гэр бүлийг ажилтай орлоготой /гэр бүл, амжиргаагаа аваад явах цалин хангамжтай/ болгохын тулд ажлын байр бий болгох, мөн зан заншил, ёс зүйг төлөвшүүлэх нь хамгийн үр дүнтэй арга байх болно.

Ийнхүү манай улс нийгмийн шинэ тогтолцоонд шилжиж, нийгэм, улс төр, эдийн засгийн шинэ нөхцөлд иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэр бүлийн харилцаанд хямрал үүсэх нь нийгэм болон улс оронд тулгарч буй хямрал, бэрхшээлийн илэрхийлэл, харин гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн харилцааны тогтворт байдал алдагдсаны шинж, гэр бүлийн дотоод хямралын илрэн гарах хэлбэр нь болж байна.¹

Энэ байдлаас харахад гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нь:

1. Нөхрийн эцгийн эрх ёсны хандлага;
2. Архидалт, архинаас хамааралтай байдал;
3. Улс орон нийгэм, эдийн засгийн байдал, эрэгтэйчүүдийн ажилгүйдэл, өрх гэр бүлийн амжиргааны дорой байдал, өр зээл;
4. Эхнэрийн эдийн засгийн байдал нөхрөөс хамааралтай байх;
5. Эмэгтэйчүүд үр хүүхдээ өнчрүүлэхгүй, гэр бүлээ бүтэн байлгах гэсэн үзлээр тэвчих хандлага;
6. Үнэнч бус байдал хэт богино хугацаанд гэрлэх;
7. Дагавар хүүхэдтэй гэрлэх;
8. Хосуудын гэр бүлийн суурь хүмүүжил төлөвшил, харилцааны чадвар, бусдыг хүндэтгэх хандлага, уур бухимдлаа зохицуулах, стрессээ зохицуулах, тайлах зэрэг (сэтгэл хөдлөлийн чадвар) чадварууд дутмаг байдал;
9. Гэр бүлийн гишүүдийн гэр бүлийн боловсрол, гэр бүлийн хүчирхийлэл гэж юу болох, хуулийн зохицуулалтыг мэдэхгүй байх;

¹ Г.Ганбаатар Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх арга зүйн тулгамдсан асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2016. 3 дахь тал

10. Эмэгтэйчүүдийн нөхрөө засарна зүгээр болно гэсэн итгэл хүлээлт зэргээс хамааран хүчирхийлэл даамжирч байна. Нийгэмд тогтсон жендерийн тэгш бус байдлыг халах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй.

§ 3.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүн, анхаарах асуудал

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн чиг үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл үй ажиллагаагаа жил бүр төлөвлөн, тодорхой ажлуудыг хэрэгжүүлж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтийг татан оролцуулах байдлаар зохион байгуулсан нь үйл ажиллагааны тайлангуудаас ажиглагдсан. Тухайлбал,

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийг 2020 оны 07 дугаар сарын 31-ны өдрөөр амжилттай хэрэгжүүлж дуусгасан байна. Төслийн хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийг шинээр байгуулж, 2020 оны 06 дугаар сард ашиглалтад оруулжээ. Ингэснээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр 2020 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 18 нэг цэгийн үйлчилгээний төв, 13 хамгаалах байр, нийт 31 байр байна. Үүнээс цагдаагийн байгууллагын дэргэд 6, эрүүл мэндийн байгууллагын дэргэд 3, шүүхийн шинжилгээний байгууллагын дэргэд 1, төрийн бус байгууллагын дэргэд 2, гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын дэргэд 19 тус тус ажиллаж байна.

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэдийн тоо нийт 1036, үүнээс насанд хүрсэн хүн 481, хүүхэд 555 байв.

Хүснэгт 1: Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, үйлчлүүлэгчдийн тоо

	2016 онд	2017 онд	2018 онд	2019 онд	2020 онд
Нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо	8	10	11	15	18
Хамгаалах байрны тоо	3	6	9	14	13
Үйлчлүүлэгчдийн тоо	1474	1488	1866	2537	1036

НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд нэг нэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны ажилтан, албан хаагчдад практик мэргэжил, арга зүйн туршлага олгох зорилгоор гэр бүлийг хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг 21 нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байрны ажилтнуудын дунд туршлага солилцох аяллыг 2020 оны 06 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулсан байна. Туршлага солилцох аяллын үеэр оролцогчид Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцаж, хүчирхийллийн хохирогч, даван туулагчдад шаардлагатай үйлчилгээг үзүүлэхэд тулгардаг асуудлуудыг хэрхэн оновчтой шийдвэрлэсэн туршлагаасаа хуваалцаж, цаашид дүүрэг болон аймгуудын хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах, тулгамдсан асуудлаар санал солилцжээ.

Мөн төслийн 35 сая төгрөгийн санхүүжилтээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа баривчлах төвд хүчирхийлэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаар 7-30 хоног баривчлагдсан 1003 хүнд сургалт орсон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны “А/55 дугаар тушаалаар батлагдсан Хүүхэд хамгаалагч төслийг хэрэгжүүлэх тухай” журмыг 21 аймаг, нийслэлийн

172 хороонд нийт 214 хүүхэд хамгаалагчийг ажиллуулахаар төлөвлөж, төсөл, төсвийг баталсан. Мөн төслийг хамтран хэрэгжүүлэх талаар Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтарсан санамж бичиг байгуулсан.

Улсын хэмжээнд 2020 оны эхний хагас жилийн байдлаар 215 хүүхэд хамгаалагч ажиллаж байна. Хүүхэд хамгаалагч нараар дамжуулан 31,692 иргэнд 2-5 төрлийн хүүхдийн эрхийн талаарх мэдээлэл түгээж, 51 гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээллийг хамтарсан баг болон аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэст мэдээлснээр 49 тохиолдлыг шийдвэрлэн ажилласан байна.

Гэвч Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын энэ оны 1/1101 дүгээр албан бичгээр “Хүүхэд хамгаалагч төсөл”-ийн санхүүжилтийг шийдвэрлэхэд үүссэн хүндрэлийн улмаас энэ оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоох болсон талаар мэдэгдсэн тул нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад мэдээллийг хүргүүлж, төслийг түр зогсоожээ.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан тусламж, үйлчилгээ үзүүлдэг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хамтарсан багуудын дунд улсын хэмжээний жижиг төслийн уралдаан зохион байгуулсан. Төслийн уралдаанд нийт 122 төсөл хүлээн авснаас, 2 түвшний сонгон шалгаруулалтаар нийт 383 сая төгрөгийн өртөг бүхий 30 төслийг шалгаруулж төслийг санхүүжилт олгохоор шийдвэрлэжээ.

Мөн Канадын Засгийн газрын санхүүжилтээр Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-ын хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэх чадавхыг дээшлүүлэх зорилгоор төрийн бус байгууллагуудын дунд дэд төслийн уралдаан зарлаж, нийт 43 төслийн санал хүлээн авч 2 шатны сонгон шалгаруулалтаар төслийн саналыг үнэлж, нийт 240 сая төгрөгийн санхүүжилттэй 12 төрийн бус байгууллагын төслийг шалгаруулсан.

НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлсэн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд Ковид-19 цах тахлын улмаас тогтоосон хөл хорионы үед гэр бүлийн хүчирхийлэл нэмэгддэг тул гэр бүлийн эерэг харилцаа, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хайр өвтгөдөггүй” нэгдсэн арга хэмжээг энэ оны 05 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай зохион байгуулсан. Нэгдсэн арга хэмжээний хугацаанд соён гэгээрүүлэх агуулга бүхий 35 контент бэлтгэн хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр түгээсэн нь 1,012,965 хүнд хүрсэн байна.

Хүүхдийг зодож шийтгэхгүй байх олон улсын өдрийг тохиолдуулан энэ оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аливаа хүчирхийллийн хор уршиг, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, хүүхдийг зодож шийтгэх нь шийдэлд хүрэх арга замыг дэлгэрүүлэх, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж “Хүүхдийн хүсэл, мөрөөдөл” сэдвээр хүүхдүүдийг оролцуулсан видео шторк, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтран тус тус зохион байгуулсан.

Ковид-19 халдварын цар тахлын нөхцөл байдалтай холбоотой Монгол Улсын Онцгой комиссоос өгсөн олон хүн хамарсан цугларалт, танхимын арга хэмжээ зохион байгуулахгүй байх үүрэг, зөвлөмжийн дагуу төлөвлөгөөт зарим сургалт, семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу чиг үүрэг хүлээсэн ажилтан,

албан хаагчдыг тасралтгүй сургах, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан байна.

Түүнчлэн, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээний алба, НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэргийн криминологи судалгааг гүйцэтгүүлсэн байна.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх чанарын судалгаа;
2. Зан үйл хандлагад нөлөөлөх мэдээлэл харилцааны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ хийх судалгааг тус тус хийлгүүлсэн байна.

Мөн Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-ын Канадын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ;
2. Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд үнэлгээг тус тус гүйцэтгүүлжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг дараах 4 гол асуудлын хүрээнд Архангай, Дорновь, Төв, Ховд аймаг болон Баянзүрх, Чингэлтэй, Налайх, Сонгинохайрхан дүүрэгт үндэсний зөвлөх, багийн ахлагч Б.Одонгэрэл, олон улсын зөвлөх, хуульч криминологич Мартин Шкотцманс, хохирогчтой хийх ярилцлагыг чиглүүлэгч, социологич Л.Болор, бүлгийн ярилцлагыг чиглүүлэгч, жендэрийн эксперт Ш.Солонго, хэргийн судалгааг хариуцах Сонгинохайрхан дүргийн Прокурорын газрын хяналтын прокурор Д.Нямбат, мэдээллийн санд дүн шинжилгээ хийх судлаач, хуульч Г.Түвшинжаргал нарын зөвлөх баг гүйцэтгэжээ. Үүнд:

1. Хууль тогтоомж, баримт бичиг, мэдээллийн санд дүн шинжилгээ хийх;
2. Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын алба хаагчидтай бүлгийн ярилцлага хийх;
3. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх;
4. Хүчирхийллийн хохирогчтой хийх ганцаарчилсан ярилцлага хийх замаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг тус тус үнэлсэн байгаа нь чухал ач холбогдолтой ажил болжээ.

НҮБ-ын Хүн амын сангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээг нээлттэй сонгон шалгаруулж, шалгарсан “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажилласаны дагуу зөвлөх нь Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартын төслийг боловсруулсан байна.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгааллын түр хамгаалах байрыг шинэчлэх, Монгол Улсын стандарт MNS 6040:2019 “Хохирогчийг түр хамгаалан

байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага”-д нийцсэн ажил үйлчилгээг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнд үзүүлэх, тэдний хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах ажлыг баталгаатай хүргэх үүргийг хангахад 1.5 сая долларын өртөг бүхий байшинг Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо Амгаланд байрлах цагдаагийн байгууллагын Хангалт үйлчилгээний төвийн хашаанд барьж, ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас НҮБ-ын Хүн амын сангийн “Жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийг шинээр байгуулж, ашиглалтад оруулжээ.


Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Гэр бүлийг дэмжих үйлчилгээний нэр төрлийг тодорхойлох зорилгоор “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, зорилтот бүлгийн 8100 өрхийг сонгон авч, 9412 хүнийг орон нутгийн үйлчилгээнд хамруулсан байна. Өрхийн төсөв санхүүгийн боловсрол олгох сургалтад зориулан практик хэрэглээний мэдлэг, дадал олгох Гэр бүлийн эдийн засгийн боловсрол, Гэр бүлийн харилцаа сургалтын модулийг “Гэр бүлийн судалгаа, боловсролын хүрээлэн” ТББ-тай хамтран боловсруулсан байна.

Цагдаагийн байгууллагын тухайд:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно” гэж заасны дагуу гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын үр дүнг сайжруулж, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/301 дүгээр тушаалаар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” хэлтсийг байгуулжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Тус хэлтэс нь:



Дээрх бүрэлдэхүүнээс гадна 21 аймаг болон нийслэл, сум дундын цагдаагийн хэлтсүүдэд тус бүр нэг, нэг албан хаагч Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн гэсэн нэршилтэйгээр батлагдсан орон тоонд ажиллаж байна.

Мөн 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт 680 хамтарсан баг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг явуулж байна.

Цагдаагийн байгууллагын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг:


1. **Цагдаагийн албаны тухай хуулийн** 46 дугаар зүйлд: цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох гэж заагаад таслан зогсоох ажиллагааг;

2. **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн** 25 дугаар зүйлд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үүргийг; /Энэ зүйлийн онцлог заалт нь хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаарх бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах; гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, холбон зуучлах утас 24 цагаар ажиллуулах, тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд **цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй** байж болно гэж заасан. Бусад заалт нь Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан чиг үүрэгтэй давхцаж байна/

3. **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн** 29 дүгээр зүйл цагдаагийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийг тус тус зааж өгсөн байдаг.

Дээрх заалтуудаас харахад Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой зүйл заалт байхгүй, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл, чиг үүргийг ерөнхийд нь тусгаж өгсөн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, алба хаагчдын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан сургалт.



Дээрх судалгаанаас үзвэл албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтууд хангалттай зохион байгуулагдаж буй нь харагдаж байна. Мөн эдгээр албан хаагчидтай ярилцлага хийхэд гэр бүлийн хүчирхийллийн талаарх тэдний ойлголт, хандлага өөрчлөгдөж, нэмэгдэж байгаа тухай хэлж байна.

Энэ чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдыг мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтуудыг шат дараатай зохион байгуулж буйгаас гадна Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн эчнээ болон 1+1 мэргэшүүлэх хөтөлбөрийн ангийн сонсогч, суралцагчдад 1 улирлын турш **“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа”** нэршилтэй 2кр хичээлийг зохион байгуулж байна. Ингэхдээ урьдчилан сэргийлэх бүлэг сэдвийн хүрээнд лекц, семинар, дасгалын хичээлийг тус бүр 2, 2 цаг буюу нийт 6 цагийн хичээл, сургалтыг зохион байгуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлөвийг өөрчлөх,

хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгуулага, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.



Дээрх урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээнүүдийг жилд 1 удаа 22-28 хоногийн хугацаатай улсын хэмжээнд зохион байгуулсан байна. Энэ арга хэмжээний үеэр тараах, хэвлэмэл материал /баннер, санамж, наалт, стикер зэрэг/-ыг 213.304 ширхэгийг хэвлэн тараасан байна.

Хүснэгт 3.2.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан:

2019 он					
Д/д	Төрөл	Тоо	Үзсэн хүний тоо	Хуваалцсан тоо	Таалагдсан байдал
1	Урьдчилан сэргийлэх видео контент	25	3.157.999	46.808	27.154
2	Нөлөөллийн видео контент	12	697.211	9300	2349
3	Зорилтот мэдээ, мэдээлэл	10	284.654	3012	978
4	Зурган постер	16	779.122	5316	1676
5	Блог хөтлөгч	8	213.707	1415	1116
Нийт		71	4.848.039	59.199	32.655
2020 он					
д/д	Төрөл	Тоо	Үзсэн хүний тоо	Хуваалцсан тоо	Таалагдсан байдал
1	Зорилтот видео контент	6	1.024.329	41.883	4.573
2	Нөлөөллийн видео контент	20	1.511.405	10.798	5.459
3	Зорилтот мэдээ, мэдээлэл	35	200.290	7.981	905
4	Зурган постер	51	990.651	75.497	6.294
Нийт		112	3.726.675	136.159	17.231

Анхаарах асуудал

Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудад гэр бүлийн хүчирхийллээс

урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрхэн ажиллах зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг дараах байдлаар заажээ.

- Ерөнхий;
- Тусгай;
- Нэг бүрчилсэн;
- Соён гэгээрүүлэх;
- Гэмт хэрэг зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх.

Практик дээр эдгээр чиглэлийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Тухайлбал, 2018-2020 онд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх чиглэлээр 3 удаагийн аяныг 22-28 хоногийн хугацаатай /1 жилд 1 удаа/ зохион байгуулсан. Аяны хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоон судалгаа олон ч нэгжүүд дээр төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор нэр төдий явагдах хандлага ажиглагдаж, мөн цагдаагийн алба хаагчдаас мэдэгдэж байв. Шалтгаан нь дүүрэг болон орон нутгийн цагдаагийн байгууллагын нэгжүүд дээр алба хаагчийн ажлын ачаалал их, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тусгайлсан орон тоо, мэргэшсэн алба хаагч хангалтгүй зэрэг нь урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнгүй, ор нэр төдий төлөвлөгөөний биелэлтийг хангасан байх үүднээс хийгдэж байна. **Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл хариуцсан ажилтныг үндсэн ажлыг нь хийлгэх, ажлын давхардлыг багасгах шаардлагатай.**

Цагдаагийн хэлтэс бүрт гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн байгаа хэдий ч эдгээр нь ЦЕГ-ын даргын 2020 оны “Эрх олгох тухай” зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудыг томилох тухай тушаалд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн орсон нь урьдчилан сэргийлэх ажлыг явуулах үндсэн чиг үүрэг нь алдагдах бас нэг шалтгаан болж байна.

Цагдаагийн ерөнхий газар болон гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээнүүдийг жил бүр зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр ажиллагаанд бусад байгууллага, иргэдийг татан оролцуулж байгаа нь сайшаалтай. Энэ ажлыг цаашид улам сайжруулахын тулд дараах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлийг хүний хүчин зүйлээр бус, эрх зүйн зохицуулалт, техник технологи гэх мэт өөр шийдлээр урьдчилан сэргийлэх гарцыг эрэлхийлэх,
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтний тоог нэмэгдүүлэх, үндсэн ажлыг хийлгүүлэх, ажлын давхардлыг багасгах,
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалтаас гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэнг хасах, зөрчил шалгах биш зөвхөн урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлдэг байх,
- ДХИС-ийн харъяа Цагдаагийн сургуулийн цагдаагийн ажил-эрх зүй хөтөлбөрийн 4 жилийн ангид “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа” хичээлийг оруулах, цаг сэдвийн төлөвлөгөөнд тусгагдсан урьдчилан сэргийлэх бүлгийн цагийг нэмэгдүүлэх,

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий албан хаагчдыг сэтгэл судлалын чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудад хамруулах,
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах /энэ чиглэлээр сургалтууд сайн явагддаг боловч бодит байдал дээр биелэлээ олдоггүй, шалтгааныг нь санхүүжилт болон ажлын ачаалалаар тайлбарладаг/.
- Шинээр гэр бүл батлуулж байгаа хосуудыг гэр бүлийн боловсролын чиглэлээр сургалтад хамруулдаг байх /сум, дүүргийн нийгмийн ажилтан/,
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй болон мөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн этгээдийг соён гэгээрүүлэх, ухааруулах, ярилцах зэрэг арга хэмжээг хэрэглэдэг байх.
- Албадан сургалтуудын сургалтын арга барилыг өөрчлөх.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Бид судалгааны зорилгоо хэрэгжүүлэхийн тулд судалгааны зорилтуудыг шийдвэрлэх хүрээнд хийсэн судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэх явцад дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин зохих хэмжээнд бүрджээ. 2016 оны 12 дугаар сард Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай шинэчилсэн найруулсан хууль батлагдаж, 2019 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэсэн 11.7 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт ялтай болгосон зэрэг эрх зүйн хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Мөн эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлд заасан “хүнийг алах” гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалд “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан бол хүндрүүлэхээр заасан зэрэг эрүүгийн шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой болсон.

2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг гэдгээ ялган бүртгэх, зөв танин тэмцэх асуудал дээр нэн анхаарах шаардлага харагдаж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2020 онд өсөх, харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг буурах хандлагатай байна. Эндээс харахад цагдаагийн байгууллага “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг”, “гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг” гэх бүртгэлээ эргэн харж, бодитой бүртгэхэд анхаарах шаардлага байна.

3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас 2019 онд 8, 2020 оны эхний 11 сарын байдлаар 16 хүн нас барж, мөн 2019 онд 732, 2020 оны эхний 11 сарын байдлаар 874 хүн гэмтэж, эрүүл мэндээрээ хохирчээ. Түүнээс үүдэн гарах хор уршиг, хохирол нэмэгджээ.

4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, түүний дэд зөвлөл, ХЗДХЯ, ХНХЯ, Жендэрийн үндэсний хороо, ЦЕГ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг төрийн байгууллагаас **улсын төсвөөр болон олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр үр дүнд хүрэхүйц олон талт арга хэмжээ, ажлуудыг зохион байгуулсан нь** үйл ажиллагааны тайлангаас харагдахаас гадна нийгмийн үйл явцаас ажиглагдаж байна. БШУЯ, Соёлын яам, нутгийн засаг захиргааны байгууллага, тэдгээрийн харьяа байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн дорвитой харагдахгүй, төдийлөн сайн тайлагнаагүй байх талтай байна.

5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж эхэлсэн цагаас хойш энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар төрөөс олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч гэмт хэрэг, хүчирхийлэл төдийлөн буурахгүй байна. **Абсолют тоон үзүүлэлтийн хувьд өссөн ч хүн амд ногдох, чанарын агуулгын хувьд ахиц гарсан байх үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг гаргаж ирэх шаардлага байгаа нь харагдаж байв.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгааг мэдсэн хэн боловч Цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүргийг хуулиар хүлээлгэсэн ч өнөөдөр гэртээ болон гудамжинд гэр бүлийн гишүүнийг хүчирхийлэх явдал байсаар байна. Хүчирхийлэлийг нэмэгдүүлэхгүй байх асуудалд иргэдийн оролцоо маш чухал байдаг ч нийгмийн ажилтан, хүүхдийг хамгаалах байгууллагын тоог хүрэлцээтэй хэмжээнд нэмэгдүүлэх энэ талаар сургалт, явуулах дагнасан мэргэшсэн боловсон хүчин бэлтгэж

төрийн оролцоог илүү өргөн хүрээнд хийх ажилууд явуулах нь зайлшгүй шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

6. Иргэдийн эдийн засгийн боломж нөхцөлтэй холбоотойгоор дийлэнх гэр бүлүүд эцэг эх, ахан дүүс болон хадмуудтайгаа нэг гэрт, эсвэл нэг хашаанд хамтран амьдардаг, хүчирхийлэгчээс салахад өөрийн гэсэн гэр оронгүй, тусалж дэмжих хүнгүй байдал нь хохирогчийг хүссэн, хүсээгүй гэмт этгээдтэй эвлэрэхээс аргагүй байдалд хүргэж байгаа бөгөөд төрийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн олговор өгөх зэрэгт эдийн засгийн чадавхгүй байдал нь хохирогч хохирогчоороо үлдэх, Үндсэн хуульд заасан **“аюулгүй орчинд амьдрах, халдашгүй дархан байх”** эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

7. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой учрах хууль, шүүхийн байгууллагынханы гэр бүлийн хүчирхийллийг зөрчил төдийгээр үздэг хандлага, хохирогчийг гэм бурууг тогтоон нотлох хэрэгсэл болгодог уламжлалт хандлагаас салж чадахгүй байгаатай холбоотойгоор иргэдийн амь насыг нь хамгаалж чадахгүй байна. Тухайлбал, 2015 онд иргэн Б гомдлыг нь шалгаж байсан хүнд хамтран амьдрагч нь алахаар заналхийлж байгаа тухай мэдэгдсэн боловч, хэрэг бүртгэгчийн хайхрамжгүй, хариуцлаггүйн уршгаар иргэн Б тухайн өдөртөө хамтран амьдрагчийнхаа гарт амиа алдсан¹ хэрэг гарч байсан билээ гэтэл энэ байдал мөн л 2020 онд давтагдсан харамсалтай хэрэг гарсан байна.

8. Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1. дэх хэсэгт: “Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцална” гэсэн заалтыг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч төдийгүй хүний эрх ашгийг хамгаалж байгаа байгууллага, иргэдийн санаачлагаар хэрэгжүүлэх боломжтой гэдгийг практик ажилтнууд нэг мөр ойлгож хэрэгжүүлэх нь шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

9. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг үнэн зөвөөр шуурхай шалган шийдвэрлэж, хуульд заасны дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн даруй нотлох баримтуудыг түргэн шуурхай цуглуулж, гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр завдаж буй этгээдийг заавал баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг байх, энэ гэмт хэрэгт өртсөн хохирогч, гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, гаргасан гомдлоо буцаан авсан эсэхийг үл харгалзан шүүхээр хэргийг шийдвэрлэхээс гадна хүчирхийлэгч этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг гарцаагүй болохыг олон нийтэд ойлгуулах нь нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чухал ач холбогдолтой төдийгүй, цагдаагийн байгууллагаас хохирогч иргэний аюулгүй байдлыг хангах тал дээр сайтар анхаарч ажиллах гэмт хэрэгт өртсөн хохирогч нараас бодитой судалгаа авч, аюулын зэргийн үнэлгээг үнэн зөвөөр гарган авч тэдэнд зайлшгүй шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрлээ.

10. Цагдаагийн байгууллагад ирж буй дуудлага мэдээллийг хүлээн авмагц гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт шуурхай бүрэлдэхүүнийг хэргийн газар ажилуулан тэр даруй эмэгтэй албан хаагчаар биед нь үзлэг хийлгэж тэмдэглэл хөтлөн баримтжуулах нь хэргийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

Мөн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг саатуулж зөрчилд 100.000 төгрөрөөр торгож байгаа нь тухайн зөрчил үйлдэгдсэн айл өрхөөс гарах мөнгө учир энэ талаар мэдсэн төлбөрийн чадамжгүй иргэд энэ шалтгаанаар дуудлага буцаах ихээхэн ажиглагдаж банья. **Иргэд 100.000 төгрөрөөр торгуульснаас худал дуудлага өгсөн гэж**

¹Эрүүгийн 2015 дугаартай хэрэг

Зөрчлийн тухай хуулийн 15.9 дүгээр зүйлд заасны дагуу 50.000 төгрөгөөр торгуульж дуудлагаа хаалгадаг. Энэ байдлыг таслан зогсоож гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлийг зайлшгүй бүртгэж авдаг байх утсаар ярьж буй хохирогчийн тухайн үеийн айж, сандарсан, хоолойны өнгө, яриа өгүүллийг бичлэг болгон хадгалж байх нь энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд томоохон ач холбогдолтой гэсэн дүгнэлтэд хүрлээ.

НЭГДСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны дэд бүлгүүдэд дурьдагдсан дүгнэлт, санал, зөвлөмжөөс гадна дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар:

1.1. Зөрчлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт:

5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

4. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

4.1. зодсон;

4.2. хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;

4.3. бусадтай харилцахыг хязгаарласан;

4.4. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийллийн 4 хэлбэрийг /бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн хүчирхийллийн/ тодорхойлсон бөгөөд дээрхи хуульд заасан “сэтгэл санааны” хүчирхийллийг Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.2, 4.3-т тус тусад нь тусгасныг нэг заалт болгон өөрчлөх саналтай байна.

Мөн энэ зүйлийн 4.2-т заасан “хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан” гэх шинжийг хуульд тайлбар оруулан тодорхой болгох саналтай байна.

5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

4. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

4.4. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Энэ зүйлийн 4 дэх заалтад заасан зөрчил гаргагчид зөвхөн баривчлах шийтгэл оногдуулах зохицуулалттай. Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч, зөрчилд холбогдогч хэн аль нь торгох шийтгэл оногдуулах хүсэлт гарган, давж заалдах шатны шүүхэд гомдол их гаргадаг.

Уг зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээг харгалзан сонгох санкцтай болгох буюу торгох шийтгэл оногдуулахаар өөрчлөлт оруулах саналтай байна.

1.2. Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар:

- Монгол улсын Эрүүгийн хуулийн 11.7 зүйлийн 1.3-т: хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд гэдэг үгийн дараа “байнга” гэдэг үгийг оруулан “хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд байнга халдсан бол ...” гэж өөрчлөх.

- Эрүүгийн хууль болон зөрчлийн тухай хууль дах гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үйлдлийг нэмэх, зарим үйлдлийн санкцыг нэмэгдүүлэх.

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн үндсэн шинжид байгаа “байнга” гэсэн шинжийг хүндрүүлэх шинжид оруулах.

- Уг гэмт хэрэгт оногдуулах ялын төрөлд “Зан үйл, нөлөөллийн сургалтад хамрагдах” албадлагын төрлийг шинээр оруулах.

- Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг үйлдсэн хүнд оногдуулж буй ялын хамгийн хөнгөн нь “Зорчих эрхийг хязгаарлах” бөгөөд уг ялын үр нөлөө нь амьдралд сөргөөр тусч байна.

“Зорчих эрхийг хязгаарлах” ял авсан хүн үр хүүхэдтэйгээ уулзаж цагийг хамт өнгөрүүлэх гэр бүлийн наад захын ердийн харилцаа алдагдахаас гадна, гэр бүлийн хүмүүсийн харьцаа эргэж хэвийн болох боломжгүй улмаар гэр бүл салах хэмжээнд хүргэнэ.

Хорих ялаар шийтгүүлсэн хүн хохирогчид гомдох, өшөрхөх улмаар өөр хүнд гэмт хэрэг үйлдэх аюул бий болох магадлалтай учир анх удаа энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнд алдаагаа засах боломж олгох, хүчирхийллийн эсрэг зан үйлийн, нөлөөллийн шинжтэй сургалт явуулах нь илүү үр дүнтэй болно.

Энэ ял шийтгэлийн бодлого нь мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж баривчлагдаж буй хүнд бас хамаарна.

1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд сэтгэл санааны хүчирхийлэл байна гэж тусгасан боловч Иргэний хуульд нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт байхгүй тул сэтгэл санааны хохиролыг нөхөн төлөх арга, эрх зүйн зохицуулалтыг тусгах.

Хоёр: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг сайжруулах криминологийн арга хэмжээний хүрээнд:

2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд “**дэд зөвлөлийн жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө**”-г боловсруулж, холбогдох байгууллагуудын үүрэг оролцоог тодорхой тусгаж, өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд анхаарах.

- “**Улсын төсөв, олон улсын дэмжлэг, санхүүгийн нөөц**”-ийг судалгаанд тулгуурлан, эрсдэлтэй, тодорхой зорилтод бүлэгт оновчтой зарцуулахад бодлогын түвшинд анхаарах.

- Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, тэмцэж буй үйл ажиллагаанд **жил бүр криминологи судалгаа хийлгүүлж**, түүнд үндэслэн дараагийн шатны ажлаа төлөвлөдөг байх. Энэ нь судалгаанд тулгуурлан ажлаа төлөвлөх, үүнээс үүдэн төлөвлөлт үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэх юм.

- Жил бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд **шинэлэг санал, санаачлага, инноваци нэвтрүүлэх чиглэлээр илтгэлийн уралдаан** зэрэг олон талт арга хэмжээ зохион байгуулагдаж байх.

- **Хөдөө, сум орон нутагт (ялангуяа малчны хотхонд) далд хэлбэрийн хүчирхийлэл, гэмт явдлыг** илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлийг онцгойлон анхаарч, өргөн далайцтай аян, арга хэмжээ, ажлыг хэрэгжүүлэх, үүнд **орон нутгийн телевиз, малчин зэрэг телевизүүдтэй** хамтран ажиллах.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхийн суурь үндэс нь гэр бүл, гэр бүлийн харилцаа, ёс зүйн боловсрол олгох явдал. Иймд сургалтын хөтөлбөрт энэ хичээлийг оруулснаар гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

- Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршиг, гэм хор, гэр бүлийн харилцаа, ёс зүй, гэр бүлийн болон жендэрийн соёл, ухамсарын талаар хүүхдийн ухамсар хандлагыг бага

наснаас нь бий болгох зорилготой, тусгай сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, үүнд БШУЯ, Соёлын яамны үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

- Мэргэжлийн сэтгэл зүйчийг мэргэшүүлэх, заах арга зүй, бүлгийн зөвлөгөөн зохион байгуулах арга зүйд сургах, утас болон интернэт орчинг ашиглан сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх.

- Мэдээллийн хэрэгслээр гэр бүлийн халуун дулаан уур амьсгал бүхий нэвтрүүлэг, шторк цацах, сайн сайханд уриалах, үүнд Соёлын яамны үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

- Эрэгтэйчүүдийн зан үйл, амьдралын зөв хэв маягийг таниулах, сурталчлах сургалт зохион байгуулах. Эрчүүдэд зориулсан төвийг нээн ажилуулж, тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг, сэтгэцийн хямрал, хардалт, архидах, мансуурахын хор уршиг, эдийн засгийн хүндрэл, бага, дунд бизнес эрхлэх болон бусад шаардлагатай сургалт явуулах, үүнд ЭМЯ, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

- Ахуйн хүрээний хүчирхийлэл, архидалтад тавих гэр бүлийн гишүүд, хөрш, ойрын төрөл төрөсөд, анд нөхдийн хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах багасгах арга хэмжээг авах, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоохын тулд иргэн бүр тусламж үзүүлэх, цагдаад мэдэгдэх үүрэгтэйг хүн бүрт сурталчилж таниулах.

- Гэмт хэргийн ихээхэн хувийг гэр хороололд үйлдэж байгаа тул хөршийн холбоог сайжруулах тал дээр анхаарах. Гадна гудамж тайлбайд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг. Хот төлөвлөлтөнд анхаарах, алслагдсан дүүргийн хороодын гудамжинд гэрэлтүүлэг, камержуулалт тавих зэрэг техникээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгтэй тэмцэх талаар:

- **Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн зөрчлийг** шалгаж шийдвэрлэх ажиллагаатай холбоотой, санал хүсэлт, өргөдөл, гомдол, түүнчлэн илэрсэн дутагдалд **мониторинг, дүн шинжилгээ** хийж, түүний үр дүнд тулгуурлан санамж, зөвлөмж, боловсруулж, цаашид авах арга хэмжээгээ төлөвлөн хэрэгжүүлдэг байх.

- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг үнэн зөвөөр шуурхай шалган шийдвэрлэж, хуульд заасны дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн даруй нотлох баримтуудыг түргэн шуурхай цуглуулж, гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр завдаж буй этгээдийг заавал баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг байх, энэ гэмт хэрэгт өртсөн хохирогч, гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, гаргасан гомдлоо буцаан авсан эсэхийг үл харгалзан шүүхээр хэргийг шийдвэрлэхээс гадна хүчирхийлэгч этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг гарцаагүй болохыг олон нийтэд ойлгуулах.

- Цагдаагийн байгууллагаас хохирогч иргэний аюулгүй байдлыг хангах тал дээр сайтар анхаарч ажиллах гэмт хэрэгт өртсөн хохирогч нараас бодитой судалгаа авч, аюулын зэргийн үнэлгээг үнэн зөвөөр гаргах, цахим бугуйвч ашиглах болон бусад зайлшгүй шаардлагатай хамгаалалтын болон аюулгүйн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох, мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг гардан хэрэгжүүлэх алба хаагчдыг сургаж, чадавхжуулах: 1) бүсчилсэн сургалтыг үе шаттай зохион байгуулах; 2) хууль зүйн их, дээд сургуулийн сургалтыг хөтөлбөрт энэ асуудлыг тусгуулах; 3) Дотоод хэргийн их сургуулийн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөрийг чанаржуулах, түүний дотор Цагдаагийн сургуулийн

цагдаагийн ажил-эрх зүй хөтөлбөрийн 4 жилийн ангид “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа” хичээлийг албан ёсоор оруулах.

- Шүүхээс гэр бүлийн хүчирхийллийн талаарх хэрэг, зөрчлийг оновчтой, бодитой шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх, шүүгч нарыг мэргэшүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах.

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтний тоог нэмэгдүүлэх, төлөвлөгөөнд тусгагдсан урьдчилан сэргийлэх бүлгийн цагийг нэмэгдүүлэх.

Гурав. Гэр бүлийн хүчирхийлээс хамгаалах виктимологийн арга хэмжээний хүрээнд:

Гэр бүлийн хүчирхийлэл гарсан тохиолдлыг дахин давтуулахгүй байх, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эмзэг бүлгийг хамгаалах ажлыг үе шаттай, уялдаатай, олон талын оролцоог хангаж, үр ашигтай ажлуудыг хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

3.1. Хүүхдийг гэр бүлийн хүчирхийлээс хамгаалах талаар:

-Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, эцэг, эхийн хариуцлага, үлгэр дуурайлал, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.

-Хүүхдийн эрхийн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үйл ажиллагааг хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулахад чиглүүлэх, ажлын үр дүнг тооцож, ажиллах.

- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх мэргэшсэн албан хаагчийг тусгайлан бэлтгэх.

-Садар самуун явдал, биеэ үнэлэх, хардалт, эцэг эхээ үл тоомсорлох зэрэг хүүхдийн сэтгэхүй, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх агуулга бүхий насанд хүрэгчдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, кино, ярилцлага, цэнгээт үзүүлбэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараахгүй байхад анхаарах, бага насны хүүхэд интернет орчинд чөлөөтэй нэвтрэх нь зохистой эсэх, хязгаарлалт тогтоох боломж нөхцөлийн талаар судлах.

3.2. Эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлээс хамгаалах талаар

- Хүчирхийлэлд нь ихэнх нь боловсрол мэдлэггүй улмаас ажилгүй гэртээ байдаг эмэгтэйчүүд өртөж байгаа учир Хөдөлмөрийн яам болон хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, төрийн бус байгууллагуудтай хамтран ажилгүй эмэгтэйчүүд болон эрчүүдийг сургалтанд хамруулж мэргэжил эзэмшүүлэх мөн төрөөс бодлогоор дэмжин тусгай хөнгөлөлттэй зээл хөтөлбөрөөр дэмжин их дээд сургуульд сургах зэргээр боловсролд нь анхаарах.

- Ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд сургууль төгсөөд хүүхэд төрүүлээд гэртээ суудаг учир мэргэжлээрээ ажлаагүй гэсэн үндэслэлээр ажилд авдаггүй зүйл нийгэмд зөндөө байгаа учир тэднийг ажилд зуучлах, ажлын байраар хангахад төрийн оролцоо маш чухал байна.

- Эмэгтэй хүн ажил хийхэд бас нэгэн бэрхшээлтэй зүйл нь бага насны хүүхэд асран хамгаалах асуудал гарч ирдэг тиймээс энэ асуудлыг улам бүр боловсронгуй болгож хүүхэд харах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

- Сум болон хороодод эрэгтэйчүүдэд зориулсан сэтгэлзүйн зөвлөгөө мэдээлэл өгөх сэтгэлзүйч ажилуулах, тэдэнд зориулсан нийгмийн үйлчилгээ уламжлал ёс зүй, зан заншил харилцаа, холбоо хамаарал бүхий сургалтууд зохион байгуулах хэрэгтэй.

3.3. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, өвчтөнийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах талаар:

- Өндөр настангуудыг улсын хяналтанд байлгах, тэтгэврийг тэдний орон байр, хоол, хувцасны асуудалд шийдэхээр тусдаа бие даасан бодлого авч хэрэгжүүлэх.

- Өндөр настанг нийгмийн ажилтан, эмч нь байнга эргэж тойрох, тэдний эрх, ашгийг хамгаалах.

3.4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод туслалцаа үзүүлэх түр хамгаалах байр, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх төвийг “бодит ачаалал, нөхцөл байдал”-д тулгуурлан байгуулахад анхаарах, тухайлбал, Сонгинохайрхан дүүрэгт байгуулах зэрэг болно.

**“ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН КРИМИНОЛОГИ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН”-ГИЙН ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН
ТЭМДЭГЛЭЛ, ТҮҮНЭЭС ГАРСАН САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД**

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ:

Зохион байгуулагч:

- ГХУСАЗЗ-ийн Ажлын алба
- Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн
- Хууль сахиулах, олон нийтийн эрүүл мэнд судлалын хүрээлэн

Хэзээ: 2020.12.22-ны 09.30-11.00

Оролцогчид:

- ГХУСАЗЗ-ийн Ажлын албаны дарга Л.Нямгэрэл, мэргэжилтэн Ч.Амарбаясгалан
- Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа О.Зоригт
- Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал Т.Очирбат
- Хууль сахиулах, олон нийтийн эрүүл мэнд судлалын хүрээлэнгийн захирал Ш.Доржханд
- Судалгааны багийн ахлагч:
Хууль зүйн доктор, профессор Ч.Нямсүрэн
- Судалгааны багийн зөвлөх:
Хууль зүйн доктор Т.Очирбат
- Судалгааны нарийн бичгийн дарга:
Хууль зүйн доктор Б.Мөнхдорж
- Судалгааны багийн гишүүд:
Хууль зүйн доктор, профессор Т.Оюунчимэг
Хууль зүйн магистр Б.Даяадан-Эрмэд
Сэтгэл судлалын докторант Ш.Доржханд
Докторант Н.Сайнбаяр
Докторант Ч.Отгонсүрэн
Докторант Д.Цэрэнлхам
Докторант Г.Балжмаа
Докторант Г.Ганхөлөг
Магистрант Б.Мөнхшүр
- Үндэсний статистикийн хороо
 - Б.Амарбал
- Шүүхийн ерөнхий зөвлөл
 - Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул
 - Э.Ганцэцэг
- Улсын ерөнхий прокурорын газар
 - Доктор Б.Өнөрмаа

Цагдаагийн ерөнхий газар

- Э.Баярбаясгалан
- Б.Цэнгэлбаяр

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

- Докторант Г.Балжмаа

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн

- Докторант Г.Ганхөлөг

Дотоод хэргийн их сургууль

- Доктор С.Гантулга
- Доктор М.Болор-Эрдэнэ

Улаанбаатар олон улсын их сургууль

- Докторант П.Анхмаа
- Докторант М.Болормаа
- Магистрант Н.Наранцэцэг

Монголын криминологичдын холбоо

- Г.Оюунболд

Хэлэлцэх асуудал

Чиглүүлэгч: Хууль зүйн доктор Б.Мөнхдорж

№	Хэлэлцэх асуудал	Цагийн хуваарь
1.	ГХУСАЗЗАА-ны дарга Л.Нямгэрэл	09:30-09:40
2.	Судалгааны тайлангийн товч танилцуулга - Судалгааны багийн ахлагч, хууль зүйн доктор, профессор Ч.Нямсүрэн	09:40- 10:00
3.	Судалгааны тайлан, үр дүнтэй холбоотой асуулт, хариулт	10:00-10:30
4.	Судалгааны үр дүнгээс гарах зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгах санал /Хүн бүр 5 минут/ - Судалгааны тайланг сайжруулах, зөвлөмжид тусгах санал - Цаашид 2021 онд хэрэгжүүлж ажиллах ажлын санал - Судалгааны асуудалд хамаарах асуудлаар нэмэлт, санал, шүүмжийг мэйл хаягаар авах боломжтой.	10:30:11:00
5.	Хэлэлцүүлгийг дүгнэж, үг хэлнэ - ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор Т.Очирбат - Хууль сахиулах, олон нийтийн эрүүл мэнд судлалын хүрээлэнгийн захирал Ш.Доржханд	11:00-11:10

Хэлэлцүүлэг zoom meeting ашиглан явагдсан.

ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН САНАЛ, ЗӨВЛӨМЖ, ШҮҮМЖҮҮД

Судалгааны багийн ахлагч, хууль зүйн доктор, профессор Ч.Нямсүрэн, нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор Б.Мөнхдорж нар судалгааны тайлангийн талаар танилцуулга хийв.

Хэлэлцүүлгийн явцад оролцогчид дараах санал, зөвлөмж, шүүмжийг гаргав.

УЕПГ, ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР Б.ӨНӨРМАА:

1. Хүчирхийллийг өдөөгч хүчин зүйлийн эсрэг эмчилгээний аргыг урьдчилан сэргийлэх ажилд нэвтрүүлэх

Хүчирхийллийн гэмт хэргийн 60-70 хувь нь согтуугаар үйлдэгддэг. Иймд баг, хорооны хэмжээнд архинаас хамааралтай хүний судалгааг гарган тухайн хүний архинаас хамаарах эмгэгийн түвшинг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож эмийн болон сэтгэл зүйн эмчилгээг хийлгэж хэвших.

Архинд донтолт гэдэг олон улсын ангиллаараа F10 гэж оношлогддог нэг төрлийн өвчин юм. Өвчнийг нь эмчлэхгүйгээр баривчлах, хорих зэрэг ял шийтгэл оногдуулах нь хүчирхийллийн гэмт хэргийг бууруулахад ямар ч нөлөө үзүүлэхгүй юм.

1993 онд “ЖИ-СИ–ЭС” олон улсын байгууллагын оролцоотойгоор Монгол Улсад архинд донтох өвчнийг эмчлэх “Минесота загвар эмчилгээ” буюу “Архинаас гаргах 12 шатлал” эмчилгээг нэвтрүүлж эхэлжээ. Бүлгийн сэтгэл засал эмчилгээний хэлбэрээр зохион байгуулагддаг хордлого тайлах, сэтгэл засах, нийгэмшүүлэх цогц үйлчилгээтэй сэтгэл зүйн эмчилгээний арга нь манай оронд ихээхэн үр дүнтэй болох нь нэгэнт батлагдсан юм.

2. Зөрчлийн болон Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.

Уг гэмт хэрэгт оногдуулах ялын төрөлд “Зан үйл, нөлөөллийн сургалтад хамрагдах” албадлагын төрлийг шинээр оруулах.

“Зорчих эрхийг хязгаарлах” ял авсан хүн үр хүүхэдтэйгээ уулзаж цагийг хамт өнгөрүүлэх гэр бүлийн наад захын ердийн харилцаа алдагдахаас гадна, гэр бүлийн хүмүүсийн харьцаа эргэж хэвийн болох боломжгүй улмаар гэр бүл салах хэмжээнд хүргэнэ.

Анх удаа энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнд алдаагаа засах боломж олгох, зан үйлд нөлөөллийн шинжтэй сургалт явуулах нь илүү үр дүнтэй болно.

3. Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулийн уялдаа холбоо зохицлыг анхаарч үзэх хэрэгтэй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг сурталчилгаа хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хангалттай явагдаж байгаа боловч уг сурталчилгааг үзэх техникийн боломжгүй хүн маш их байгаа мөн хүчирхийлэлд өртснөө мэдэгдэх чадамжгүй эсхүл энэ талаар мэдээлэл авах боломжгүй өндөр настан, бага насны хүүхэд, сонсгол, хэл яриа, хөгжлийн бэрхшээлтэй иргэн их байдаг тул тухайн сурталчилгаа зорилтот бүлэгт хүрэхгүй байна.

Иймд урьдчилан сэргийлэх ажлыг зорилтот бүлэгт очиж хүргэх ажлыг зохион байгуулахын тулд баг, хорооны хэмжээнд андройд гар утас, зурагтгүй, хжгжлийн бэрхшээлтэй өрхийн бүртгэлийг бий болгож тухайн өрхийг зорилтот бүлэгт оруулж урьдчилан сэргийлэх мэдээлэл, мэдлэгийг тодорхой давтамжтай өгдөг болох.

Тусгай хэрэгцээ шаардлаатай иргэдэд мэргэжлийн хүнээр мэдээлэл, мэдлэг олгох.

ГХУСАЗЗАА-ын дарга Л.НЯМГЭРЭЛ:

1. Н.Одонтуул шүүгчийн хэлсэн саналуудыг тодорхой тусгаад өгөөрэй. Энэ судалгааг сайдад танилцуулна. Одноо шүүгчээ та дүгнэлтийн төслийг нь үзээд нэр томъёоны хувьд сайн үзээд өгөөрэй. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой Зөрчлийн хууль, Эрүүгийн хуулийн давхардсан шинжийг оруулах хэрэгтэй.
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй үр дүнтэй тэмцэхэд зан үйл өөрчлөх сургалт чухал, үүнд анхаарах асуудлыг гаргах.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Н.ОДОНТУУЛ

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийллийн 4 хэлбэрийг /бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн хүчирхийллийн/ тодорхойлсон бөгөөд дээрхи хуульд заасан “сэтгэл санааны” хүчирхийллийг Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.2, 4.3-т тус тусад нь тусгасныг нэг заалт болгон өөрчлөх саналтай байна.
2. Мөн энэ зүйлийн 4.2-т заасан “хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан” гэх шинжийг хуульд тайлбар оруулан тодорхой болгох саналтай байна.

“5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

4. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

4.1. зодсон;

4.2. хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;

4.3. бусадтай харилцахыг хязгаарласан;

4.4. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.”

3. **Зөрчлийн хуулийн 5.4 дүгээр зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээг харгалзан **сонгох санкцтай болгох** буюу **торгох шийтгэл оногдуулахаар өөрчлөлт оруулах саналтай байна.**

Энэ зүйлийн 4 дэх заалтад заасан зөрчил гаргагчид зөвхөн баривчлах шийтгэл оногдуулах зохицуулалттай. Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч, зөрчилд холбогдогч хэн аль нь торгох шийтгэл оногдуулах хүсэлт гарган, давж заалдах шатны шүүхэд гомдол их гаргадаг.

ДХИС-ИЙН ӨДРИЙН ДОКТОРАНТ Н.САЙНБАЯР

1. **Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг дагнан шалгадаг нэгж байгуулах**

Энэ төрлийн гэмт хэргийг дагнан шалгадаг нэгж байгуулах. Уг нэгжид мөрдөн шалгах чиглэлээр болон урьдчилан сэргийлэх, хяналт шалтгалтын хэсгүүдийг байгуулж цогц байдлаар үйл ажиллагааг нь зохион байгуулах. Ингэснээр энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны үр дүн чанар сайжирна, мөн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа дээшилнэ.

2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг шалгах аргачлалыг боловсруулж стандарт байдлаар хэрэгжүүлэх

Энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн тохиолдолд шалгах аргачлалыг боловсруулж стандарт байдлаар хэрэгжүүлэх. Өөрөөр хэлбэл нэгдсэн нэг арга барил, шат дараатай, харилцан хамааралтай процессоор шалгадаг байх. Мөн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил бүртгэгдсэн тохиолдолд дуудлага авсан цагдаагийн алба хаагч, хороо хариуцсан байцаагч, хүүхдийн байцаагч, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн ажилтан, хорооны мэргэжилтэн зэрэг алба тушаалтнууд хэрхэн ажиллах, хэрхэн хамтарч ажиллах зэрэг бүхий л үйл ажиллагааг нарийн дэс дараалалтай стандартад оруулах.

3. Сэтгэл зүйчийг шинжээч, мэргэжилтнээр мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулж улмаар түүгээр дүгнэлтийг гаргуулах

Энэ төрлийн гэмт хэргийн нэг гол асуудал хор уршиг ба түүн дотроо сэтгэл санааны хохирлын асуудал байдаг. Одоогийн практикт энэ төрлийн гэмт хэргийн сэтгэл санааны хохирлыг тодорхойлсон үйл ажиллагаа байхгүй байгаатай холбоотойгоор сэтгэл зүйчийг шинжээч, мэргэжилтнээр мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулж улмаар түүгээр дүгнэлтийг гаргуулж мөрдөн шалгах ажиллагаанд ашиглаж хэвших.

4. Гэмт этгээд шийтгэгдсний дараа ч тодорхой хугацаанд хяналтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх

Цагдаагийн байгууллага нь энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн тохиолдолд шалгаад шийдвэрлээд зогсохгүй, шүүхээр тухайн этгээд шийтгэгдсний дараа ч тодорхой хугацаанд хяналтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

5. Тусгаарлах арга хэмжээг боловсронгуй, тодорхой болгох чиглэлээр хууль эрх зүйн орчин бүрдүүлэх энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад холбогдогч этгээдийг хохирогч нараас тусгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Тусгаарлах арга хэмжээг боловсронгуй, тодорхой болгох чиглэлээр хууль эрх зүйн орчинг сайжруулах. Тусгаарлаагүйн улмаас хохирогч нас барсан тохиолдол гарч байсныг анхаарах.

ДХИС-ИЙН ӨДРИЙН ДОКТОРАНТ Г.БАЛЖМАА

1. Орон нутаг болон нийслэлд Зан үйл өөрчлөх сургалтыг дагнан хариуцах мэргэжлийн ажилтаны орон тоог бий болгох нэн шаардлагатай байна.

Хорих ангийн нийгмийн ажилтан сэтгэл зүйч нарын ажлын ачаалал бодит байдал дээр байх ёстой хэмжээнээсээ 2-3 дахин их ачаалалтай ажилдаг, түүн дээр нэмээд албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд зан үйл засах сургалтыг хариуцуулсан нь тухайн этгээдтэй нэг бүрчлэн уулзаж нөлөөллийн ярилцлага хийх, сургалтыг давтамжтай хэсэг хэсгээр явуулах бололцоогүйгээс үр нөлөө муутай байгаа тул ачаалал ихтэй орон нутаг болон нийслэлд энэ төрлийн сургалтыг дагнан хариуцах мэргэжлийн ажилтаны орон тоог бий болгох нэн шаардлагатай байна.

2. Захиргааны, зөрчлийн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг газар, хэлтсийн төсөвт тусгаж

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.13-т “Албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг зөвшөөрөл бүхий төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болго” гэж заасан хэдийч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 299 дүгээр зүйлийн 299.5-д “Энэ хуулийн 169.1-д зааснаас бусад тохиолдолд захиргааны, зөрчлийн, эрүүгийн

шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг газар, хэлтсийн төсөвт тусгаж, олгохгүй байгаа нь ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

3. Иргэн бүрийн утсанд гэр бүлийн хүчирхийлийн хор уршиг, урьдчилан сэргийлэх хуулийн талын мэдээлэл хүргүүлэх.

Гэр бүлийн хүчирхийлийн улмаас гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдийн статистик тоо мэдээлэл бол шүүхээр шийдвэрлэгдсэн зөрчлийн хэргийн тоон үзүүлэлт болохоос цагдаагийн байгууллагад мэдэгдэхгүйгээр хэчнээн айлд гэр бүлийн хүчирхийлэл нуугдмал хэлбэрээр үйлдэгдэж байгааг илэрхийлэх боломжгүй юм. Тиймээс гэр бүлийн хүчирхийлийн эсрэг урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажлуудын нэг болох нүүр тулсан сургалтыг цар тахалын эрсдэл нүүрлэсэн энэ үед явуулах боломжгүй учраас үүрэн утасны оператор байгуулагуудтай /нийгмийн хариуцлагын хүрээнд/ хамтран ажиллаж иргэн бүрийн утсанд гэр бүлийн хүчирхийлийн хор уршиг, урьдчилан сэргийлэх хуулийн талын мэдээлэл хүргүүлэх.

ДХИС-ИЙН ДОКТОРАНТ П.АНХМАА

1. Хамтарсан багийн бүрэлдэхүүний эрх зүйн байдлын талаархи эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, шинээр тодорхойлох шаардлагатай байна.

Эрх зүйн алдаа, дутагдал нилээдгүй байгаа дээрхи хүмүүсийн саналтай санаа нийлж байна. Ганцхан жишээ дурьдая гэж бодлоо. Гэр бүлийн хүчирхийлэл холбоотой эрх зүйн орчныг судалсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд хамтарсан багийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон. Хамтарсан баг нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж үзүүлдэг хамгийн анхан шатны нэгж. Гэтэл уг хуулинд хамтарсан багийг сум хорооны засаг дарга ахална гэсэн байгаа. Гэр бүлийн хохирогчдод нийгмийн халамж, хүүхэд хамгаалал, сэтгэл зүйн үйлчилгээ, эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлнэ гэж заасан. Гэтэл практик дээр энэ багийг засаг дарга ахлаад явах нь ажлын ачаалал, газар нутгийн хэмжээ, орон зай зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Сум хорооны засаг дарга амьдрал дээр хамтарсан багийг ахлах боломж маш муу байна. Энэ нь хууль хэрэгжихгүй байна гэсэн үг юм. Хамтарсан багийн бүрэлдэхүүний эрх зүйн байдлын талаархи эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх, шинээр тодорхойлох шаардлагатай байна.

2. Сургуулийн өмнөх боловсролоос эхлээд ерөнхий боловсролын сургуульд ч ёс зүй, төлөвшилийн тусгай хөтөлбөр бүхий сургалтыг оруулж хэвших

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа нь хувь хүний хүмүүжил, төлөвшилтэй холбоотой байна.

ЦЕГ, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Б.ЦЭНГЭЛБАЯР

Агуулгад оруулах санал:

1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах талаар Гэрч, хохирогчиг хамгаалах тухай хуулийн зохицуулалтыг тусгахаас гадна Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа, хүндрэл бэрхшээл, алдаа, ололттой тал, тоон мэдээг тусгах.
2. Улсын Дээд Шүүхээр гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг /гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг алах, хүчиндэх г.м/-ийг шийдвэрлэсэн 13 шийтгэх тогтоолоор гэмт хэргийн шинжийг тайлбарласан тул энэ талаар оруулах.

3. Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн практик хэрэглээний алдаа, зөрчил, хийдлийг улам дэлгэрэнгүй болгох.

Зөвлөмжид оруулах санал:

1. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлийг хүний хүчээр биш хууль тогтоомж, техник технологи г.м өөр шийдлээр арилгах, бууруулах, саармагжуулах талаар санал оруулах
2. Гаргасан зөвлөмжийг аль байгууллага хийж хэрэгжүүлэх талаар тусгах.
3. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар саналын томъёолол бичих.
4. Гадаад улсын ямар сайн туршлагыг Монгол улсад нутагшуулах, хэрэгжүүлэх боломжтой талаар тусгах.

**“ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД
ИННОВАЦИ НЭВТРҮҮЛЭХ, ОНОВЧТОЙ САНАЛ ДЭВШҮҮЛЭХ” СЭДЭВТ
ИЛТГЭЛИЙН УРАЛДААНААС ГАРСАН ШИНЭЛЭГ САНАЛ, САНААЧЛАГЫН ТҮҮВЭР**

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Дотоод хэргийн их сургууль, Цагдаагийн ерөнхий газраас хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлийн инноваци” сэдэвт илтгэлийн уралдааныг улсын хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын 12 дугаар сард зохион байгуулсан.

Уралдаанд нийт 100 гаруй илтгэл ирүүлснээс тэргүүн байрт МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, доктор (Ph.D) Д.Бадам, Ч.Болормаа нарын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдал, зүйлчлэлийн асуудал, түүнийг боловсронгуй болгох нь” сэдэвт илтгэл шалгарсан. Дэд байранд Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын хяналтын прокурор Д.Нямбатын “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх хавтаст хэргийн судалгаа” сэдэвт илтгэл шалгарсан. Уралдааны гуравдугаар байрт Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хорих 413 дугаар ангийн хамгаалалтын ажилтан, Дотоод хэргийн их сургуулийн магистрант, дэд ахлагч Ү.Галмандахын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд инноваци нэвтрүүлэх, оновчтой санал дэвшүүлэх нь” сэдэвт илтгэл тус тус шалгарсан юм.

Энэхүү уралдаанд ирүүлсэн илтгэлүүд дурьдагдсан шинэлэг санал, санаачлагын түүврийг та бүхэн толиулж байна. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив талын үндсэн шинж болох “байнга” гэх шинжээрээ зөрчил болон бусал хүч хэрэглэсэн гэмт хэргээс ялгагдаж байгаа нь практикт энэ төрлийн гэмт хэргийг ялгамжтай зүйлчилж ял завших, эрх ашиг сонирхол хөндөгдөх зэрэг сөрөг үр дагавартай болох нь харагдаж байна;
2. Гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн бол хүндрүүлэн зүйлчлэх боломжтой юм. Ингэснээр ойролцоо төрлийн гэмт хэргийг ялгамжтай байдлаар зүйлчлэхгүй байх боломж бүрдэнэ;
3. Гэр бүлийн хүчирхийллийн бусад 2 хэлбэр болох сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийг хуульчлах, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт гэр бүлийн хамаарал бүхий этгээдйн өмчлөх эрхэд халдсан бол гэж хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчлах;
4. Хохирогч давхар хохирох ёсгүй бөгөөд зорчих эрхийг хязгаарлах ялын мөн чанар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хариуцлага тооцоход үр дүнтэй байж чадахгүй юм. Түүнчлэн торгох ялыг хэрэглэх нь хүчирхийлэгчээс эдийн засгийн хамаарал бүхий хохирогчийг давхар хохироох магадлалтай юм. Иймд гэмт хэргийн хор аюул, учирсан хохирол зэргийг харгалзан иргэний болон эрүүгийн шат дараатай арга хэмжээг авах нь чухал. Тухайлбал гэрлэлтийг хохирогчийн хүсэл зоригийн үндсэн дээр цуцлах, тэтгэмж тогтоолгох, харин эрүүгийн хариуцлагын хувьд нийтэд тустай ажил хийлгэх, албадлагын арга хэмжээ авах, хорих зэрэг ялыг хэрэглэх нь үр дүнтэй юм.
5. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдогчийг хэдэн цагийн хугацаатай албадан сургалтанд хамруулж хэд хоногийн хугацаатай баривчилсан

- талаарх мэдээллийг хохирогчид хэн ямар байдлаар хэзээ мэдэгдэж байх тухай нэмэлт өөрчлөлт оруулах;
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагчийн цагдан хорьсон болон хорихоос татгалзаж байгаа шүүхийн шийдвэр болон мөрдөгч, прокурор, шүүгч ямар таслан сэргийлэх арга хэмжээ авсан, прокуророос хэрэг бүртгэлтийн хэргийг хааж байгаа тохиолдолд хохирогчид хэн ямар байдлаар хэзээ мэдэгдэж байх талаарх нэмэлт өөрчлөлт оруулах;
 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ялын хугацаа дуусч суллагдаж байгаа ялтаны талаарх мэдээллийг хохирогчид хэн ямар байдлаар хэзээ мэдэгдэж байх тухай нэмэлт өөрчлөлт оруулах;
 8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээлэл, өргөдөл өгсөн цагаас хойш хохирогчийг өмгөөлүүлэх эрхийг хангах зорилгоор “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн нь төлбөрийн чадваргүй яллагдагч байна” гэсэн заалтад “хохирогч” гэж нэмж оруулах. Мөн Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт “Төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг Өмгөөлөгчдийн Холбоо эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулна” гэсэн заалтын дагуу хуулийн байгууллагаас Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран ажиллан үнэ төлбөргүй ажиллах өмгөөлөгч нарын жагсаалтыг хохирогчид танилцуулж мэдээллээр хангадаг байх тогтолцоог бий болгох;
 9. Хохирогчийг хамгаалах байранд аваачсан тохиолдолд түүний үр хүүхдийг хамтад нь хамгаалах бөгөөд тэдгээрийн Үндсэн хуульд заасан сурч боловсрох эрхийг зөрчихгүй байхад анхаарч ерөнхий боловсролын сургуулийн цахим, теле хичээлийг нэвтрүүлэх, хамгаалах байранд ерөнхий боловсролын багш авч ажиллуулах;
 10. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалт гэр бүлийн хамаарал бүхий хүнийг “байнга” гэх ойлголтыг нэг мөр болгож ойлгож хэрэгжүүлдэг байх;
 11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан гэр бүлийн хамаарал бүхий хүн гэдэгт нэг гэрт хамт амьдардаггүй хүнийг хамруулах ойлгох эсэхийг тодорхой болгож шаардлагатай бол тухайн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;
 12. Монгол Улсын зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн заалт байдаг боловч амьдрал дээр дээрх заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Иргэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгааг мэдсэн ч мэдээгүй юм шиг бидэнд хамаагүй гэсэн байдлаар хандах хандлага одоог хүртэл байсаар байгаа нь хүчирхийллийг өөгшүүлж байгаад анхаарч, иргэдийн эрх үүргийг таниулан сурталчлах хуулийг нэг мөр ойлгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах шаардлага байна;
 13. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчилд оногдуулж буй шийтгэлийн талаар прокурорын байгууллагаас бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
 14. Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд гэмтлийн зэрэг тогтоолгох төлбөрийг уян хатан болгож төлбөрийн чадваргүй хохирогч нараас авдаггүй болгох;
 15. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүрт “Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ”, “Аюулын зэргийн үнэлгээ”, “Хамтарсан багийн хурлын шийдвэр”, АСАП сангийн мэдээллийг заавал авч хэргийн бүрдэлийг хангаж байх.

16. Хууль эрх зүйн хүрээнд хийдэлгүй ажиллах боломжийг бүрдүүлэх. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил болон гэмт хэргийг зөв ялгах. Энэ талаар нэг мөр практик тогтоох;
17. Төрийн байгууллага бүрт сэтгэл зүйч ажиллуулах. Заавал орон тоо баталдаггүй юмаа гэхэд энэ төрлийн үйлчилгээг тогтмол авч байх гэрээний зохицуулалтыг хийж болох юм;
18. Сайн сайхан үлгэр жишээ гэр бүлийг урамшуулан дэмжих. Орон нутгийн удирдлагаас “шилдэг гэр бүл”-ийг тодруулж засаг даргын нэрэмжит шагнал олгодог. Үүнийг бүх орон нутагт адил хэрэгжүүлж, төрийн шагнал бий болгож болох юм;
19. Гэр бүлийн харилцаа, хамтын амьдрал, хамтран амьдрагчийн харилцааг хамгаалалтад авах. Үүнд баг хорооны засаг дарга, нийгмийн ажилтнууд голлох үүрэгтэй;
20. Хамтарсан багийг идэвхжүүлэх. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хууль зүй, дотоод хэргийн сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал 2017.10.04-ний өдрийн А/173, А/251, А/380;
21. Улсын бүртгэлтэй хамтарч ажиллах. Сүүлийн үед албан ёсны оршин суух хаяггүй тэр ч байтугай регистрийн дугаар бүртгэлгүй хүмүүс олширсон. Хөдөө суманд гэр бүлийн хүчирхийлэл үйлдлээ гээд хэрэг гарахад гэрлэлтийн баталгаа байхгүй, хамтран амьдрагч тэгсэн атлаа улсад ямар ч бүртгэлгүй, оноосон нэр ч байхгүй зүгээр л Төмрөө гэдэг гээд бичиг үсэг ч мэдэхгүй ёстой л нэг нийгмээс тасарсан бүдүүлэг хүмүүс байна. Хэрэг хянан шалгах явцад хэрхэн хариуцлага хүлээлгэх вэ? Хэрхэн мэдүүлэг авах вэ гээд маш олон асуудлууд гарч ирнэ. Тийм хүнийг алчихсан байсан ч хэн ч тоохгүй, хэн ч хариуцлага хүлээхгүй тийм эрх зүйн орчинтой. Гэтэл тийм хүн хүчирхийлэл үйлдвэл хэрхэн хариуцлага хүлээлгэх асуудал хөндөгддөг. Тиймээс аль болох хурдан хугацаанд Монгол улсын бүх иргэдийг дахин бүртгэлжүүлэх шаардлагатай;
22. Шүүхээс анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хойшлуулахдаа ЭХ-ийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Зан үйлээ засах, хөдөлмөрийн дадал олгох” гэдгийг тусд нь салган ялгаж оногдуулах;
23. Ял хойшлогдсон өсвөр насны этгээдийг батлан даалтанд авч хараа хяналтандаа байлгах хүсэлт гаргасан эцэг, эх, харгалзан дэмжигч, ойрын төрөл, садангийн хүмүүсийг үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалтанд хамрагдсан эсэх, амьдралын нөхцөл, ажил, хөдөлмөрийн цаг болон бусад мэдээллийг сайтар судалж, харгалзан үзсэний үндсэн дээр салсан эцэг, эхийг хоёуланг дуудан батлан даалтанд өгөх эсэхийг шийдвэрлэдэг байх;
24. Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 4 дахь хэсэгт “Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө” гэж заасныг өөрчлөн цаашид хорих ялыг хойшлуулсан хугацааг хорих ял эдэлсэнд тооцдог учир үлдсэн хорих ялыг шүүх хурлаар оруулж тэнсэн харгалздаг болгон өөрчилж хяналтанд байлгах;
25. ЭХ-ийн 7.6.4 болон 8.6.4 дахь хэсэгт заасан хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусгавар болгон ялаас чөлөөлдөг асуудлыг өөрчлөн үлдсэн ялыг ЭХ-ийн 6.12 дахь хэсэгт заасан хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох байдлаар өөрчлөх;
26. Компаниудаас татвар авах замаар улсын төсвөөс тусдаа гэр бүлийг хамгаалах сан байгуулах;

27. Гэр бүл болон хамтран амьдрагч нарт сургалт зөвлөгөөн, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх, гадаад улс шиг анхаарал тавьж хяналтандаа авч байх;
28. Иргэний хуулийн 32 дугаар зүйлд гэрлэгчид зөвхөн хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулахаар заасан тул хүүхдийн тэжээн тэтгэх эрхийн тухай асуудлыг орхигдуулсан байна. Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн практикт хосууд гэрлэлтээ батлуулахын өмнө гэрлэлтийн гэрээ байгуулж буй асуудал учир дутагдалтай, байхгүйтэй адил цөөн байна. Зүй нь гэрлэлтийн гэрээнд зөвхөн гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн асуудал бус гэр бүл цуцалсаны дараах үр хүүхдээ тэжээн тэтгэх асуудлыг тусгасан байдлаар хуульчилж, гэр бүл батлуулахад зайлшгүй гэрээг харгалзан үздэг байх нь хүүхдийн суурь эрхүүдийг хангахад чухал ач холбогдолтой;
29. Хүүхдийн тэтгэлэг төлөгч нь төлбөрийн чадваргүй, ажил хөдөлмөр эрхэлддэггүй, төлбөр төлөхөөс зайлсхийх асуудал шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад дийлэнхи байна. Иймд хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, тухайлбал, албадан сургалтад хамруулах, албадан хөдөлмөр эрхлүүлж хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх, жолоодох эрхийг түдгэлзүүлэх, нийтэд мэдээлэх зэрэг албадлагын шинжтэй арга хэмжээг авах шаардлагатай;
30. Гэр бүлийг хамгаалах субъектуудын нэгдсэн чуулганыг жил бүр зохион байгуулж байх. Чуулганы үр дүнгээр зөвлөмж гарган УИХ-д тайлагнаж авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хүргүүлж байх. /Манай улсад маш олон төрийн болон төрийн бус байгууллага, сан, олон улсын байгууллага, хувь хүмүүс, сэтгэл зүйчид байдаг боловч хамтарч ажиллаж чаддаггүй. Нэгдсэн зохион байгуулалт байдаггүй тул үр дүн багатай байдаг.
31. Тухайн тусламжийн хонхны эдийн засгийн үнэлгээг холбогдох байгууллагаар хийлгэж, Монгол Улсад ашиглах боломжийг эрх бүхий байгууллагад уламжлах;
32. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа этгээдийн “Зан үйлд нөлөөлөх сургалт”-ын хөтөлбөрийг сайжруулах, бусад албадан сургалтаас салган явуулах;
33. Цагдаагийн алба хаагчид болон “Зан үйлд нөлөөлөх сургалт” орж буй ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах, тэднийг сургалтын хэрэглэгдэхүүн, орчин нөхцлөөр хангах боломжийг олгох;
34. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зөвхөн цахим орчинд дуу хоолойгоо нэгтгэх бус сургууль, их, дээд сургуулиуд болон албан байгууллагад гэр бүлийн хүчирхийллийн хор уршигийн тухай сургалтыг тогтмол зохион байгуулах;
35. Аймгийн бүх сумдад “Хохирогчийг хамгаалах, сонсох төв”-ийг нээж үйл ажиллагаа явуулах;
36. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх, чанартай үр өгөөжтэй, хүн нэг бүртэй тулж ажиллах боломжтой байх үүднээс мэргэжлийн сургалт хариуцсан ажилтаны орон тоог нэмэгдүүлэх;
37. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг байгууллагын төсөвт тусгайлан тусгаж олгох асуудлыг шийдвэрлэх;
38. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг, зөрчил үйлдэж хариуцлага хүлээсэн этгээдүүдийн насны ангиллаас харахад 25-аас дээш насныхан буюу залуужсан, мөн боловсролын түвшингээс харахад бүрэн дунд боловсролтой этгээдүүд зонхилж байгаа нь суурь боловсролын анхан шатны байгууллага, гэр бүлийн суурь

- хүмүүжлийн орчинд чиглэсэн арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна;
39. Урьдчилан сэргийлэх ажлыг урт болон богино хугацааны хөтөлбөрт оруулан зохион байгуулах. Урт хугацааны хөтөлбөрт тухайлбал “Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлэх төслийн “Амар тайван, аюулгүй нийгэм” бүлэгт “гэр бүлийн хүчирхийлэл” нэр томъёогоор нэг бүрчлэн тусгуулан урт хугацаанд төлөвлөж ажилласнаар 10-20 жилийн дараа гэр бүлийн хүчирхийлийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг эрс багасна;
 40. Богино хугацааны урьдчилан сэргийлэх хөтөлбөрт ойрын хугацаанд хэрэгжүүлэх боломжтой соён гэгээрүүлэх, хууль сурталчилгаа, хор уршигийн талаарх мэдээ мэдээллийг иргэн бүрт хүргэж ажиллах тухайлбал үүрэн утасны сүлжээ компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэглэгч иргэн бүрт гэр бүлийн хүчирхийлийн эсрэг зүйл заалт бүрийг хүргэх ажлыг санаачилж сэдэлжүүлэх;
 41. Манай орны хувьд нийгмийн тогтолцоогоороо хүүхдийн суурь хүмүүжлээ орхигдуулснаас гадна нийгэм даяараа хүчирхийлэлд дасан зохицох хандлагатай болчихсон. Багаасаа хүчирхийлэлд дасан зохицсон хүүхдүүд одоо 25-30 настай, нийгмийн идэвхтэй хүн ам болж, хүчирхийллийг хэвийн үзэгдэл гэж үзэх бүхэл бүтэн үеийг бий болгочихсон, ахуйн хүрээнд далд хэлбэрээр үйлдэгддэг хор уршигтай тул хүчирхийлийн эсрэг урьдчилан сэргийлэх ажлыг “НЭГ ӨРХ-НЭГ ИРГЭН” ковид19 ажлын хүрээнд өрх бүрээс нэг иргэнийг шинжилгээнд хамруулж байгаа үйл ажиллагаатай утга ижил өрхийн тэргүүний бүрийг гэр бүлийн хүчирхийлийн эсрэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамруулах аян зохион байгуулах нэн шаардлагатай байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлийн улмаас гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдийн статистик тоо мэдээлэл бол шүүхээр шийдвэрлэгдсэн зөрчлийн хэргийн тоон үзүүлэлт болохоос цагдаагийн байгууллагад мэдэгдэхгүйгээр хэчнээн айлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгааг илэрхийлэхгүй юм.
 42. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардлыг улсын төсөвт тусгайлан суулгаж батлах, тухайлбал: Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамгаалах байруудын санхүүжилтийн асуудлыг шийдэх, дутагдалтай байгаа хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хангамжийн асуудлыг шийдэх;
 43. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн мэргэшсэн цагдаа, эмч, багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг мэргэжилтнүүдийг бэлтгэж, өөр ажил давхар гүйцэтгүүлэхгүй байхад анхаарах;
 44. Шатласан системээр гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт өгөх, өртсөн тохиолдолд хаана хандах хэрэгтэй гэх мэт агуулгыг багтаасан тодорхой мэдээллийг агуулсан сургалт зохион байгуулах. Учир нь ирээдүйн эздийг багаас нь энэ тухай мэдлэгжүүлэх шаардлагатай байна ингэснээр ирээдүйд гарах эрсдэлээс сэргийлэх боломжтой юм. Улсын хэмжээнд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 53 алба хаагч ажиллаж байна. Гэтэл Монгол Улс ерөнхий боловсролын 800 орчим сургууль, 1.2 сая хүүхэдтэй. Өөрөөр хэлбэл, нэг хүүхдийн байцаагчид 12-15 сургууль, 20-25 мянган хүүхэд ногдоно. Жилийн хугацаанд тухайн хүн 40 орчим хувьд нь л хүрч ажиллах боломжтой байдаг аж. Ажлын ачаалал их учраас энэ нь хүн, хүчийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Иймд хүүхдүүд нийгмийн ажилтан гэхээс илүү багш нар, найзуудтайгаа ойрхон байдаг. Иймээс мэргэжлийн нийгмийн ажилтангууд багш нарт сургалт зохион байгуулж үүнээсээ улбаалан бүх шатны ерөнхий боловсролын сургуульд гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэг олгох зорилготой хичээлийн төлөвлөгөөг боловсруулж хичээлийн жилийн улиралд 1-2 удаа хичээл болгон оруулж, сурагчдыг мэдлэгжүүлэх;

45. Зөвхөн нийгмийн ажилтан, багш гэлтгүй сурагчдын өөрөө удирдах байгууллага, сайн дурын бүлгэмүүдийг дайчлах, тэдний дунд сургууль дотроо гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар үйл ажиллагаа хэрэгжүүлэх уралдаан зарлах байдлаар /Монгол орон даяар, бүх ерөнхий боловсролын сургуулиудын хэмжээнд/ Мөн дээр дурдсанчлан мэргэшсэн нийгмийн ажилтан дутмаг байдаг тул бүх хүүхдэд хүрч ажиллаж чаддаггүй учир үе тэнгийнхэндээ нөлөөлдөг, нөлөөлөгч сурагчдыг бэлтгэж, тэднээр дамжуулан үеийнхэнд нь мэдлэг олгуулах, нөлөөллийн аян явуулах;
46. Гэр бүлийн хүчирхийллийн талаар иргэдийн дуудлага мэдээлэл өгдөггүй нийтлэг шалтгаан нь “Дараа намайг дуудлага өгсөн гэж дарамталвал яах вэ?” гэсэн айдастай холбоотой байдаг байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээллэсэн мэдээллэгчийн хувийн мэдээллийг нууцална хэмээн хуульчилсан байдаг бөгөөд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөршийн холбоог сайжруулж, хууль таниулах, сурталчлах арга хэмжээг харъяа баг, хороонд тогтмол зохион байгуулах шаардлагатай байна;
47. Дуудлага мэдээлэл өгсөн иргэнээс хэргийн талаар авах байцаалтыг олон дахин дуудан ирүүлхээс илүү нэг мөр хэрэгжүүлэх нь тэднийг өгсөн дуудлагадаа харамсаж залхах эрсдэлээс сэргийлнэ;
48. Хамтарсан баг хариуцсан баг хороондоо тогтмол гэр бүлийн хүчирхийллийн талаар судалгаа явуулж өрхийн үзлэгийг хагас жил, эсхүл улиралдаа нэг удаа зохион байгуулдаг байх;
49. Энэ нь хүчирхийлэлд өртсөнөөр үүссэн байж болох бие дээрх далд шарх сорви, хугарал гэмтэл, хохирогчийн сэтгэл зүй, сэтгэцийн байдлыг ажиглан тандах, шат дараалсан үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг бий болгоно;
50. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харъяа хүчирхийллийн дуудлага, мэдээллийн 108 утасны үйлчилгээг сайжруулах, дуудлагыг цаг алдалгүй түргэн шуурхай авч, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах, холбон зуучлах ажиллагааг тасралтгүй явуулж байх;
51. Хууль баталж, хэрэгжүүлэхээс нэн тэргүүнд хуулийн үйлчлэлд хамаарах асуудлаар үйл ажиллагаа явуулах хамтарсан багийн төсөв санхүүг баталгаажуулан батлах, мэргэжлийн дадлага туршлагатай хүн хүчийг сургаж бэлтгэх, шаардлагагүй холио солиогүйгээр (улс төр, хувийн асуудлаар) тогтвортой ажлын байр бий болгох;
52. Ерөнхий боловсролын сургалтын системд энэ төрлийн гэмт хэргийн талаар, урьдчилан сэргийлэх чиглэлээр танин мэдэхүйн мэдээлэл олгож, шаардлагатай арга хэмжээ авах дадлыг эзэмшүүлэх. Жишээ нь: Хичээлийн хэрэглэгдэхүүн болох дэвтрийн хавтсан дээр шаардлагатай үед холбоо барих холбогдох байгууллагын шуурхай дуудлага, тусламжийн утсыг байршуулах;
53. Гэр бүлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан гэрлэх нөхцөлд гэр бүлийн анхан шатны сургалтад улирал тутамд 2-5 удаа хамрагдаж, тодорхой багц цагийг хангасны үр дүнд гэр бүл болгох тухай заалтыг нэмж оруулах. Уг сургалтыг аймаг, нийслэл дэх Гэр бүл хөгжлийн төв хариуцан зохион байгуулж, тухайн сургалтад гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой мэдээллийг тусгасан байх;
54. Ерөнхий боловсролын сургуулиудад шар хайрцгийг байршуулж, тухайн хайрцаганд хүүхдүүд өөрсдөд нь болон найз нөхдөд нь тохиолдсон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай мэдээллийг тогтмол хийдэг болгон хэвлүүлж, түүний хүртээмжтэй байдлыг нь хангах. Уг хайрцгийг байршуулснаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн ажил тодорхой хэмжээгээр багасна гэж үзэж байна;

55. Онлайн орчныг ашиглан гэр бүлүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч гэр бүлийн харилцааг улам бат бөх болгож, орлогын эх үүсвэр болон ядуурлаас сэргийлэх, түүнээс гарах аргын талаар гэр бүлүүдэд сургалт зохион байгуулах түүнд төрийн оролцоог нэмэгдүүлэх.
56. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг бие даасан бус тодорхой
57. Хохирогч талаас хүчирхийлэгчийг баривчлуулахгүй, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахгүй байх, гомдолгүй гэх талаар хүсэлт гаргасан тохиолдолд няхуур хандах. Ихэнхи тохиолдолд хүчирхийлэгч айлган сүрдүүлж, дарамт үүсгэснээс хохирогч нь тийнхүү хүсэлт гаргах боломжтой байдаг;
58. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч хэрэг үйлдэх үедээ согтуу байсан, уур нь хүрсэн, эсхүл гэм буруугаа ойлгож гэмшсэн зэрэг нь түүний хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байхаар зохицуулахгүй байх.
59. Цахим орчин нийгмийн сүлжээ идэвхитэй болсон цаг. Сэтгэлзүйн зөвөлгөө, гэр бүлийн асуудлалд анхан шатны зөвөлгөө өгөх шугамыг илүү идэвхжүүлэх хэрэгтэй;
60. Видео тоглоом, олны танил юүтүбэрчидэдийг хүчирхийллийн эсрэг дуу хоолойг хүргүүлэх.

НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖ

Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946
Иргэний болон улстөрийн эрхийн тухай олон улсын пакт. НҮБЕА. 1966
Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай Конвенц.
НҮБЕА. 1993
Иргэний хууль 2002
Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл 1999. №30
Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002. //Төрийн мэдээлэл. 2002. № 05
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр., Засгийн газрын 2007 оны
225 дугаар тогтоолын хавсралт
Монгол Улсын хөрөнгийн тухай хууль 2010
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011
Зөрчлийн тухай хууль 2015
Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015.
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль УБ., 2016
Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017

ХОЁР. НОМ, СУРАХ БИЧИГ, СУДЛАГААНЫ БҮТЭЭЛ

Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи УБ., 2005.
Д.Зүмбэрэллхам. Монгол Улсын Гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт номын өмнөх
үг. УБ., 2009
Т.Мөнхдалай. Гэр бүл дэх хүчирхийлэл, эмэгтэйчүүдээс гэмт хэрэг үйлдэхэд
нөлөөлөх нь /Шинжлэх ухаан, практикийн анхаарал татсан асуудлууд. Эрдэм
шинжилгээний бичиг-23. УБ., 2010.
Хохирогчийн эрхийн судалгааны төв, UNDP, “Гэрч, хохирогчийг хамгаалах
үндэсний тогтолцоог бий болгох асуудал” судалгааны тайлан, 2010
Г.Ганбаатар. Хүн алах гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй ялтангуудын дунд явуулсан
судалгаа. УБ., 2015
Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдсэн гэмт хэргийг мөрдөх
арга зүйн тулгамдсан асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2016.
Жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан 2017 он
Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном УБ., 2016
Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном УБ., 2017
Монгол улс дахь гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааны өнөөгийн байдал УБ.,
2017
Монгол улс дахь гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал УБ., 2017

ГУРАВ. ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

<http://information.police.gov.mn/resource/information/File/2020/12/04/8nqjonzvvcu9v2zq1/gemt%20hereg.pdf>
<http://information.police.gov.mn/resource/information/File/2020/12/04/8nqjonzvvcu9v2zq1/gemt%20hereg.pdf>
<http://eincenter.police.gov.mn/media/huuhed.pdf?fbclid=IwAR3UFcG9ElaPb7rJII5XGRIW0EV5lop0-kx-1PCGGI0z2mfG9PPwGGtr7Tk>

<http://eincenter.police.gov.mn/media/huuhed.pdf?fbclid=IwAR3UFcG9ElaPb7rJII5XGRIW0EV5lop0-kx-1PCGGI0z2mfG9PPwGGtr7Tk>
https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=GBHuchirhiilel_2020q1.pdf&ln=M
www.police.gov.mn
https://acws.ca/wp-content/uploads/2020/04/2020-03-27_COVID19-InterimGuidelinesDV.pdf.
<https://doi.org/10.1177/0886109920916038>.
<https://dccadv.org/2020/03/coronavirus-covid-19-response>.
<https://www.axios.com/exclusive-snapchat-to-offer-in-app-domestic-violence-support-844cf1a9-60e0-425a-90ed-67e2e1f311ea.html>.
<https://www.brandeis.edu/now/2020/may/dinnar-competition.html>.
<https://www.theguardian.com/society/2020/apr/15/domestic-abuse-killings-more-than-double-amid-covid-19-lockdown>.
<https://www.healthaffairs.org/doi/full/10.1377/hlthaff.28.6.w1052>.
https://www.vice.com/en_us/article/v749x3/nova-scotia-mass-shooting-started-as-a-domestic-assault-reports.
<https://www.dailydemocrat.com/2020/04/28/can-a-new-app-help-domestic-violence-survivors>.
<https://fivethirtyeight.com/features/what-we-know-about-crises-and-domestic-violence-and-what-that-could-mean-for-covid-19>.
<https://ncadv.org/why-do-victims-stay>.
<https://ncadv.org/why-do-victims-stay>
<https://www.techsafety.org/digital-services-toolkit>.
<https://www.thestar.com/news/gta/2020/03/24/gta-domestic-violence-groups-brace-for-perfect-storm-as-abused-women-stay-home-amid-covid-19.html>.
https://safeandtogetherinstitute.com/wp-content/uploads/2020/05/MARAPR20-Virtual-Support-Group-Summary_DS042220-1.pdf.
<https://www.sagesse.org/wp-content/uploads/2020/03/Domestic-Violence-Community-Protocol-COVID.pdf>.
<https://www.nytimes.com/2020/03/23/opinion/covid-domestic-violence.html>.
<http://www.adfvc.unsw.edu.au>.
<http://www.adfvc.unsw.edu.au>
<https://www.nytimes.com/2020/04/06/world/coronavirus-domestic-violence.html>.
<https://www.smh.com.au/national/nsw/nation-s-largest-hotel-chain-shelters-domestic-abuse-survivors-20200406-p54hl5.html>.
<https://www.theguardian.com/society/2020/apr/12/domestic-violence-surges-seven-hundred-per-cent-uk-coronavirus>.

ДӨРӨВ. ГАДААД ЭХ СУРВАЛЖ

Aujla, W. (2010). Domestic violence and immigrant women's access to services in Edmonton, Alberta. *Annual Review of Interdisciplinary Justice Research*, 1.

Berns, N. (2009). *Framing the victim: Domestic violence media and social problems*. Piscataway, NJ: Transaction Publishers.

Buttell, F. P., & Carney, M. M. (2009). Examining the impact of Hurricane Katrina on police responses to domestic violence. *Traumatology*, 15. doi:10.1177/1534765609334822

DC Coalition Against Domestic Violence. (2020). Coronavirus (COVID-19) resources for survivors. Retrieved May 19, 2020

- DePrince, A. P., Allard, C. B., Oh, H., & Freyd, J. J. (2004). What's in a name for memory errors? Implications and ethical issues arising from the use of the term "false memory" for errors in memory for details. *Ethics Behav*, 14(3), 201-233. doi:10.1207/s15327019eb1403_1
- Douglas, H., Harris, B. A., & Dragiewicz, M. (2019). Technology-facilitated domestic and family violence: Women's experiences. *British Journal of Criminology*, 59. doi:10.1093/bjc/azy068
- Dragiewicz, M., Burgess, J., Matamoros-Fernández, A., Salter, M., Suzor, N. P., Woodlock, D., & Harris, B. (2018). Technology facilitated coercive control: Domestic violence and the competing roles of digital media platforms. *Feminist Media Studies*, 18. doi:10.1080/14680777.2018.1447341
- Enarson, E. (1999). Violence against women in disasters: A study of domestic violence programs in the United States and Canada. *Violence Against Women*, 5. doi:10.1177/10778019922181464
- Foster, H., & Fletcher, A. (2020). Women's safety NSW update: Impacts on COVID-19 on domestic and family violence in NSW.
- Fried, I. (2020). Exclusive: Snapchat to offer in-app domestic violence support. Axios. Retrieved May 20, 2020
- Fulara, S. (2020). Developing a web-based platform to support domestic violence survivors. Brandeis Now. Retrieved May 18, 2020
- Gillespie, L. K., Richards, T. N., Givens, E. M., & Smith, M. D. (2013). Framing deadly domestic violence: Why the media's spin matters in newspaper coverage of femicide. *Violence Against Women*, 19. doi:10.1177/1077801213476457
- Grierson, J. (2020). Domestic abuse killings 'more than double' amid Covid-19 lockdown. The Guardian. Retrieved April 20, 2020 from
- Iyengar, R., & Sabik, L. (2009). The dangerous shortage of domestic violence services. *Health Affairs*, 28(1). Retrieved May 11, 2020
- Kumar, A. (2020). COVID-19 and Domestic Violence: A Possible Public Health Crisis. *Journal of Health Management*, 22(2), 192-196. doi:10.1177/0972063420932765
- Lamoureux, M. (2020). Nova Scotia mass shooting started as a domestic assault: Reports. VICE News. Retrieved May 6, 2020
- Meyer, C. (2020). Can a new app help domestic violence survivors? The Daily Democrat. Retrieved May 11, 2020
- PenzeyMoog, E. & Slakoff, D. C. (in press). As technology evolves, so does domestic violence: Modern-Day tech abuse and possible solutions. In J. Bailey, A. Flynn, & N. Henry (Eds.), *Technology-facilitated violence & abuse: International perspectives and experiences*. Bingley, England: Emerald Publishing Group.
- National Coalition Against Domestic Violence. (2020). Why do victims stay? Retrieved May 6, 2020
- National Network to End Domestic Violence. (2020). Digital services toolkit. Retrieved May 19, 2020
- Rossiter, K. R., Yercich, S., Baobaid, M., Al Jamal, A., David, R., Fairbairn, J., . . . Jaffe, P. (2018). *Domestic homicide in immigrant and refugee populations: Culturally informed risk and safety strategies*. London: Canadian Domestic Homicide Prevention Initiative.
- Ryan, C., Anastario, M., & DaChunha, A. (2006). Changing coverage of domestic violence murders: A longitudinal experiment in participatory communication. *Journal of Interpersonal Violence*, 21. doi:10.1177/0886260505282285
- Safe & Together Institute. (2020). Domestic violence-informed practice observations and tips from the front line of the pandemic.
- Sagesse. (2020). Domestic violence community protocols. Retrieved June 17, 2020

- Selvaratnam, T. (2020). Where can domestic violence victims turn during Covid-19? The New York Times. Retrieved April 20, 2020
- Sety, M. (2012). Domestic violence and natural disasters. Retrieved May 1, 2020
- Special Taskforce on Domestic and Family Violence. (2015). Not now, not ever: Putting an end to domestic and family violence in Queensland.
- Taub, A. (2020). A new Covid-19 crisis: Domestic abuse rises worldwide. The New York Times. Retrieved April 20, 2020
- Thompson, A. (2020). Nation's largest hotel chain shelters domestic abuse survivors. The Sydney Morning Herald. Retrieved April 20, 2020
- Townsend, M. (2020). Revealed: Surge in domestic violence during Covid-19 crisis. The Guardian. Retrieved April 20,

